# ГАРЧИГ


**НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ** ........ 3
**Төслийн нэр:** “Хөөтийн хонхор “-2 нэртэй нүүрсний орд ашиглах төсөл ........ 3
**ТӨСЛИЙН ДЭД БҮТЭЦ.** ........ 3
**ХОЁР. ТӨСЛИЙН ТАЛБАЙН БАЙРШИЛ , ФИЗИК ГАЗАРЗҮЙ** ........ 4
**Уур амьсгал** ........ 4
**Ус зүй** ........ 4
**Ургамлан нөмрөг** ........ 5
**Амьтны аймаг** ........ 6
**Хүн ам, дэд бүтэц.** ........ 6
**ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ, ҮНЭЛГЭЭ** ........ 6
**Агаарын чанар** ........ 6
**Хөрсөн бүрхэвч** ........ 7
**Амьтны аймаг.** ........ 7
**Гадаргын болон газрын доорх ус** ........ 7
**ДӨРӨВ. 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ** ........ 8
4.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө ........ 29
4.3. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах ажлын төлөвлөгөө ........ 32
4.4. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө ........ 39
4.5. Нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө ........ 45
4.6. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө ........ 45
4.7. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө ........ 45
4.8. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө ........ 52
4.9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр ........ 54
4.9.1. Агаарын чанар ........ 54
4.9.2. Хөрсний агрохимийн шинжилгээ ........ 57
4.9.3. Усны химийн задлан шинжилгээний хариу ........ 62
4.10. Бомт, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хуваарь ........ 67
**ЗУРГАА.БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН НИЙТ ТӨСӨВ** ........ 68


## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ


*Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгчийн товч мэдээлэл* ........ 3
*Хүснэгт 2.* ........ 9
*Хүснэгт 3. Ундны усны химийн задлан шмнжилгээний дүнг MNS0900:2018 стандартад зөвшөөрөгдсөн хэмжээтэй харьцуулсан харьцуулалт,* ........ 15

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

*Зураг 1. Төслийн талбайн байршлын зураг* ....4
*Зураг 2. Тээврийн машин ачааны хэсгийг бүтээсэн байдал.* ....11
*Зураг 3. Шимт хөрсний овоолго* ....12
*Зураг 4. Химийн элементүүдийг агууламжыг стандартын зөвшөөрөгдсөн хэмжээтэй хайрцуулсан үзүүлэлт* ....16
Зураг 5. Замын усалгааны ажлын зураг ....21
Зураг 6. Замын тэмдэг, тэмдэглэгээ байрлуулсан байдал. ....22
Зураг 7. Дотоод тээврийн замыг засаж сайжруулсан, замын 2 талаар хөмсөг татсан. ....23
Зураг 8. Эм, тарианы хангамт ....24
Зураг 9. Ашигласан тос, тосолгооны материал цугларуулах хэсэг, засвар үйлчилгээ хийх талбай ....25
Зураг 10. Кемпийн гадна 500 ширхэг хайлаас мод тарьсан. ....26
Зураг 11. Дотоод тээврийн замын нөхөн сэргээлтийн ажлын зураг. ....31
Зураг 12. Эвдэрсэн талбайд нөхөн сэргээлт хийхийн өмнөх байдал. ....34
Зураг 13. Нөхөн сэргээлтийн ажлын зураг ....35
Зураг 14. Булгийн хашаа ....36
*Зураг 15. Хөөтийн булаг орчмын хог цэвэрлэгээ, 2024.10-р сар* ....36
Зураг 16. Аюултай хог хаягдлал түр хадгалах хэсэг ....41
Зураг 17. ШТС болон харуулын байрны гадна хогийн сав байрлуулсан. ....42
Зураг 18. Кемпийн гадна хог хаягдал ангилан ялгах сав байрлуулсан. ....43
Зураг 19. Ашигласан тос, тосолгооны материал хадгалах цэгийг тохижуулж, хашаалан тэмдэгжүүлсэн. ....44
Зураг 20. Ажилчдад аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч байна. ....48
зураг 21. Нийт ажилчдад гал түймрээс сэргийлэх, гал гарсан тохиолдолд авах арга хэмжээний тухай сургалт орсон. ....49
Зураг 22. Галын аюулгүй ажиллагааны самбар, галын хор ....49
Зураг 23. Кемпийн гадна болон зааварчилгааны өрөөний гаднах галын сараа ....50
Зураг 24. 2024 оны эм, тарианы орлого зарлага, зарцуулалтын бүртгэл хөтөлсөн байдал. ....51
Зураг 25. Хог хаягдлын тухай сургалт орсон. ....53

## НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

**Төслийн нэр:** “Хөөтийн хонхор “-2 нэртэй нүүрсний орд ашиглах төсөл

“Хөөтийн хонхор-2” нүүрсний ордын нөөцийг ашигт малтмалын нөөцийн улсын бүртгэлд 2014 онд бүртгүүлж 2017 оноос олборлолтын үйл ажиллагаа явуулж эхэлсэн. Ордын хэмжээнд нөөцийг цэврээр:

Бодиттой В зэргээр - 7,189.31 мян.тн;

Боломжтой С зэргээр - 11,001.90 мян.тн;

Нийт В+С нөөц 18,191.21 мян.тн тооцоолсон.

**Төслийн зорилго:** Монгол Улсын хууль, дүрэм журмын хүрээнд эдийн засгийн хувьд үр ашигтай, байгаль орчинд ээлтэйгээр уурхайн үйл ажиллагаа явуулж улмаар улс, орон нутгийн эдийн засгийн өсөлтөд бодитой хувь нэмэр оруулах, орон нутгийн ард иргэдийг ажлын байраар хангах.

*Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгчийн товч мэдээлэл*

| | |
|---|---|
| Төсөл хэрэгжүүлэгч | “Биг могул коул энд энержи” ХХК |
| Улсын бүртгэлийн дугаар | 9011665117 |
| Регистрийн дугаар: | 5369223 |
| Ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаар | MV-020772 |
| Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг | Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө, “Натур тур” ХХК-ийн байр, 4 давхар. |

## ТӨСЛИЙН ДЭД БҮТЭЦ.

1. ***Цахилгаан хангамж.*** Уурхайн цахилгаан хангамжийг цахилгаан дизель үүсгүүр ашиглан хангаж байна.
2. ***Усан хангамж.*** Унд ахуйн хэрэглээнд ашиглах усны хэрэгцээг төсөл хэрэгжих талбайд байрлах 1.1 л/с ундаргатай гүний худгаас, зам талбайн тоосжилт дарах болон нөхөн сэргээлт, ногоон байгууламжийн усалгаанд шаардлагатай усны хэрэгцээг уурхайн үйл ажиллагааны явцад шүүрэн орж ирэх шүүрлийн усаар хангана.
3. ***Зам харилцаа.***

   Гадаад тээврийн зам: “Хөөтийн хонхор-2” нэртэй нүүрсний уурхайгаас Чойрын өртөө хүртэл 130 км зайтай.

   Дотоод тээврийн зам: Ил уурхайн хөрс тээвэрлэлтэд БНХАУ-ын 60 тн даацтай MT86 маркийн автосамосвал, нүүрсний тээвэрлэлтэд 20 тн даацтай Howo маркийн автосамосвал ажиллуулдаг. Ил уурхайгаас олборлосон нүүрсийг автосамосвалаар тээвэрлэн ил уурхайгаас баруун хойд зүгт байрлах нүүрсний агуулахад буулгах ба нүүрс тээвэрлэлтийн хамгийн их зай хамгийн 2 км байна.

## ХОЁР. ТӨСЛИЙН ТАЛБАЙН БАЙРШИЛ , ФИЗИК ГАЗАРЗҮЙ

Ашигт малтмал ашиглалтын MV-020772 тоот тусгай зөвшөөрлийн дугаартай “Хөөтийн хонхор-2” нэртэй нүүрсний орд нь Дундговь аймгийн Баянжаргалан сумын Энгэр-Ус багийн нутагт нийт 1046.73 га талбайг хамран Говь-Угтаал, Гурвансайхан, Баянжаргалан сумдын нутгийн заагт баруун талаараа Баруун хүрийн ухаа, зүүн талаараа Талын хоолой, Талын худгийн хөндий, хойд талаараа Хар хадны толгодоор оршдог.

“Хөөтийн хонхор-2” нэртэй нүүрсний орд орчмын район нь Монгол орны физик газарзүйн мужлалаар говийн их муж, дорнод говийн муж, умард говийн ухаа толгодот талын тойрогт хамаарах бөгөөд байгалийн бүс бүслүүрийн хувьд цөлөрхөг хээрийн бүсэд багтаж байна.

Сав газрын ангиллаар Умард говийн гүвээт халхын дундад талын сав газарт харъяалагдана.




*Зураг 1. Төслийн талбайн байршлын зураг*

### Уур амьсгал

Цаг уурын хувьд Төв Монголын эрс, тэс уур амьсгалтай нутагт байрлах ба өвлийн улиралд дунджаар -16°-31°С хэмийн хүйтэн, зуны улиралд дунджаар +20°-25°С хэмийн халуун байдаг. Жилд унах хур тунадасны дундаж хэмжээ 205-350 мм, хавар, намрын улиралд хүчтэй салхи элбэг гарах ба хүч нь 15-20м/сек хүрнэ. Салхины чиглэл нь баруун, баруун хойт зүгээс зонхилон салхилна. Энгэр-ус, Хавиргын худгууд хайгуулын талбайгаас 1-8 км зайтай байдаг. Шатдаг занар, нүүрс, нефть агуулсан хурдсанд агуулагддаг ус эрдэсжилт ихтэй байдаг учир ундны усны шаардлага хангадаггүй эрдэсжилт ихтэй байдаг.

### Ус зүй

Судалгаагаар газар дорхи усны статистик түвшин 5.8м, динамик түвшин 9.0м , газар дорхи усны ундарга 0.5 л/сек болохыг тогтоосон байна. Хөөтийн ордын орчимд тархсан газар доорхи усны химийн найрлага нь хлор сульфатын ангийн, натри-калийн бүлгийн ус

зонхилох бөгөөд усны эрдэсжилтийн хэмжээ 3.1-3.5г/л, ерөнхий хатуулаг 52.7-57.б2мг-экв, pH 15.6-16.9 мг-эка байна. Шинжилгээний дүнгээс үзэхэд эрдэсжилт ихтэй давслаг, хатуулаг их илэрч байгаа нь бетонон эдлэлд тохиромж муутай, унд ахуйн хэрэгцээнд тохирохгүй ус байна.

## Ургамлан нөмрөг

Төсөл хэрэгжих орчмын бүс нутаг нь ургамалжилтын хэв шинжээрээ цөлөрхөг хээрийн ургамалжилттай.

Төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд тусгасан, тус ажлын хүрээнд мэргэжлийн байгууллагын хийсэн ургамлын хээрийн судалгаагаар төслийн талбай болон түүний ойр орчмын нутаг дэвгэрт цөлийн хээрийн ургамлан бүлгэмдлийн 13 овогт хамаарах 28 төрлийн 42 зүйл ургамлыг бүртгэсэн байна.

| № | Шинжлэх ухааны нэр | Монгол нэр | Амьдралын хэлбэр | Статус |
|---|---|---|---|---|
| I. | Poaceae- Үетний овог | | | |
| 1 | Achnatherum splendens | Гялгар дэрс | Бэлчээр | |
| 2 | Cleistogenes squarrosa | Дэрвээн хазаар өвс | Бэлчээр | Элбэг |
| 3 | Stipa glareosa | Сайрын хялгана | Бэлчээр | Элбэг |
| 4 | Reagrostis minor | Бага хургалж | Дүүргэгч | элбэг |
| 5 | Setaria viridis | Ногоон хоног будаа | Дүүргэгч | |
| 6 | Chloris virigata | Сарваан булган сүүл | Дүүргэгч | |
| 7 | Stipa krylovii | Шивээт хялгана | дүүргэгч | элбэг |
| 8 | Cleistogenes soogarica | Зүүнгарын хазаар өвс | Бэлчээр | элбэг |
| 9 | Leymus chinensis | Нангиад түнгэ | Бэлчээр | элбэг |
| 10 | Stipa klemenzii | Хялгана | Бэлчээр | элбэг |
| II. | Asteraceae- Нийлмэлцэцэгтэний овог | | | |
| 11 | Artemisia annua | Зуны шарилж | Дүүргэгч | Элбэг |
| 12 | Artemisia pectinata | Шүлхий шарилж | Дүүргэгч | Элбэг |
| 13 | Heteropappus hispidus | Арзгар согсоолж | Бэлчээр | |
| 14 | Ajiana achilloides | Төлөгчдүү бороолз | Бэлчээр | элбэг |
| 15 | Artemisia Adamsii | Адамсын Шарилж | Дүүргэгч | элбэг |
| 16 | Artemisia frigida | Хүйтсэг Шарилж | Бэлчээр | элбэг |
| 17 | Artemisia scoparia | Ямаан шарилж | Дүүргэгч | элбэг |
| 18 | Sausurea salsa | Давссаг банздоо | Бэлчээр | элбэг |
| III. | Alliaceae - Сонгинотоны овог | | | |
| 19 | Allium mongolicum | Хөмүүл | Бэлчээр | Элбэг |
| 20 | Allium polyrrihizum | Таана | Бэлчээр | Элбэг |
| IV. | Chenopodiaceae- Луультаны овог | | | |
| 21 | Anabasis brevifolia | Ахар навчит баглуур | Бэлчээр | |
| 22 | Krashinnikovia ceratioides | Орог тэсэг | Бэлчээр | |
| 23 | Bassia dasyphylla | Манан хамхаг | Дүүргэгч | |
| 24 | Corispermum mongolicum | Монгол хамхуул | Дүүргэгч | |
| 25 | Kochia prostrata | Дэлхээ тогторгоно | Бэлчээр | |
| 26 | Salsola collina | Толгодын budраа | Дүүргэгч | Элбэг |
| 27 | Reamurea songorica | Улаан бударгана | Бэлчээр | Элбэг |
| 28 | Salsola collina | Толгодын будраа | Дүүргэгч | Элбэг |
| 29 | Salsola passerina | Бор бударгана | Бэлчээр | Элбэг |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 30 | Salsola pestifera | Өргөст Бударгана | Дүүргэгч | |
| | | V. Fabaceae - Буурцагтаны овог | | |
| 31 | Astragalus galactites | Шүдэн цагаан хунчир | Бэлчээр | Элбэг |
| 32 | Caragana pygmeae | Алтан харгана | Бэлчээр | Элбэг |
| 33 | Caragana stenophylla | Нарийн навчит харгана | бэлчээр | элбэг |
| | | VI. Cyperaceae - Улалжийн овог | | |
| 34 | Carex stenophylla | Нарийн навчит улалж | Бэлчээр | Элбэг |
| 35 | Carex duriuscula | Ширэг улалж | Бэлчээр | Элбэг |
| | | VII. Convolvulaceae - Сэдэргэний овог | | |
| 36 | Convolvulus ammonii | Аммонний сэдэргэнэ | Бэлчээр | Элбэг |
| | | VIII. Brassicaceae - Тооноолжин цэцэгтэний овог | | |
| 37 | Ptilotricum canascens | Бууралдуу янгиц | Бэлчээр | |
| | | IX. Amrantahceae- Гагадайн овог | | |
| 38 | Axyris amaranthoides | Гагадай алис | Дүүргэгч | |
| | | X. Zygophyllaceae - Хотирын овог | | |
| 39 | Tribulus terretris | Зээлэн зангуу | Бэлчээр | Элбэг |
| 40 | Peganum harmala | Эгэл өмхий өвс | Бэлчээр | |
| | | XI. Asparaginaceae- Хэрээнүдэнгийн овог | | |
| 41 | Asparagus gobicus | Говийн хэрээннүд | Бэлчээр | Элбэг |
| | | XII. Geramnaceae –Шимтэглэйн овог | | |
| 42 | Erodium tibetanum | Түвд Заантаваг | Дүүргэгч | Элбэг |
| | | XIII. Rosaceae – Сарнайн овог | | |
| 43 | Potentilla bifurca | Имт гичгэнэ | Бэлчээр | Элбэг |

## Амьтны аймаг

“Хөөтийн хонхор-2” нүүрсний ордын бүс нутаг нь Монгол орны амьтны аймгийн газарзүйн мужлалаар Монгол-Төвдийн муж, Монгол дагуурын хээрийн дэд муж, Монгол дагуурын хээрийн тойргийн урд зах, Дорноговийн хээрийн тойргийн хойд захад хамаарна.

## Хүн ам, дэд бүтэц.

Улаанбаатар хотоос зүүн урагш 300 км, төмөр замын зангилаа Чойр хотоос баруун урагш 110км, аймгийн төв Мандалговь хотоос зүүн хойш 130км, Налайх-Замын Үүдийн хатуу хучилттай авто замаас 110кмөнгөрнө. Ашиглалтын талбайд хүн ам байнга суурьших төв газар байхгүй. Хар тэвшийн нүүрсний уурхай нь Дундговь аймгийн Говь-Угтаал, Өндөршил, Гурван сайхан, Цагаан дэлгэр, Дэрэн, Дэлгэр цогт зэрэг сумдын хүн ам олноор суурьшсан газар Баянжаргалангаас 25км зайд оршино.

# ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ, ҮНЭЛГЭЭ

Уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг, хүний эрүүл мэнд, орон нутгийн нийгэм эдийн засагт учруулах эерэг болон сөрөг нөлөөллийг тухайн төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд тодорхойлсноор дараах эерэг болон сөрөг нөлөөг үзүүлэхээр байна.

**Агаарын чанар**

⇒ Бүтээгдэхүүн тээвэрлэх үеийн машины утаа тортог, замын тоос үүсэх

⇒ Хүдэр боловсруулах үед үүсэх тоосжилт

⇒ Барилга байгууламжийн орчмын шимт хөрс элэгдэж эвдэрснээс ургамлын нөмрөг талхлагдсанаас тоосжилт үүсэх

⇒ Хатуу хог хаягдлыг цаг тухайд нь зайлуулаагүйгээс ялзарч муудан, үнэр орсноор агаар орчныг бохирдуулах зэрэг нөлөө үзүүлэхээр байна.

**Хөрсөн бүрхэвч**

Төслийн зүгээс хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт дор дурдсан сөрөг нөлөөллүүдийг үзүүлэхээр байна. Үүнд:

⇒ Барилга байгууламжийн ойр орчмын шимт хөрс элэгдэж, эвдэрснээс ургамлан нөмрөг талхлагдах

⇒ Ачиж тээвэрлэх үеийн машин техникийн хөдөлгөөнөөс хучилтгүй зам талбайн хөрс элэгдэж, эвдрэх

⇒ Олон салаа зам гарган зорчих

⇒ Машин техникийн эвдрэл гэмтлээс үүдэн тос, тослох материалын асгаралтаас хөрс, ус бохирдох

⇒ Хог хаягдлыг төвлөрсөн цэгт хаяагүй, мөн ангилан ялгаагүйгээс болж хөрсийг бохирдуулах

⇒ Ажилчдын ариун цэврийн газар болон хоолны газраас гарах шингэн хог хаягдлын байгууламж байхгүй, тэдгээрийн эвдрэл гэмтэл, дүүрэх зэрэг асуудлаас хөрс бохирдох

**Ургамлан нөмрөг**. Хүнд машин техникийн хөдөлгөөн, замын тогтсон маршрутгүйгээр зорчих, анхаарал болгоомжгүйгээс гал түймэр гарах, хог хаягдлыг ил задгай хаях зэрэг нь тухайн орчмын ургамлан нөмрөг устах , түүний төрөл зүйлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах (хог ургамал ихсэх) сөрөг нөлөө учруулна.

**Амьтны аймаг.**

Төслөөс амьтны аймагт нөлөөлөх шууд нөлөөлөл байхгүй. Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн орчимд тээврийн хэрэгсэл, техникийн дуу чимээний нөлөөнөөс ойр орчмын амьтад дайжиж, амьдрах орчин хумигдсан.

**Гадаргын болон газрын доорх ус**

⇒ Уурхайн үйл ажиллагаанд шаардагдах усны хэрэглээг гүний худгаас хангах тул тухайн бүсийн газрын доорх усны нөөцөд нөлөөлөх магадлалтай.

⇒ Мөн уурхайн олборлолтын явцад үүсэх шүүрлийн усыг шавхах ажил нь тухайн бүс нутгийн гүний уснб нөөцөд нөлөө үзүүлнэ.

⇒ Ахуйн бохир ус болон хог хаягдлыг зөв байршуулаагүй мөн орчны цэвэрлэгээ хийгээгүйн улмаас гадаргын болон хөрсний усыг тодорхой хэмжээгээр бохирдуулж болзошгүй.

**Нийгэм эдийн засаг**

Төсөл хэрэгжих хугацаанд аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, нийгмийн даатгал болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл, авто машин болон өөрөө явагч механизмын албан татвар, эдэлбэр газар ашигласны төлбөр болон бусад татвар төлбөрийг улс болон орон нутгийн төсвийн санд оруулах бөгөөд төсөл хэрэгжсэнээр орон нутагт шинэ ажлын байр нэмэгдэх боломжтой юм.

# ДӨРӨВ. 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

**4.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.**

| Д/д | Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд | Сөрөг нөлөөллийг бууруулах арилгах арга хэмжээ | Арга хэмжээний биелэлт |
|---|---|---|---|
| 1. | Агаарын чанар | Уурхайн карьер, овоолго, зам, талбайн усалгаа хэмжээ, норм, горимыг сар, улирлаар оновчтой тогтоох | - Цаг агаарын саатал болон машин техник засварт орсон өдрүүдээс бусад үед өдөрт 3-5 удаа 20 тонны багтаамжтай усны машинаар уурхайн дотоод тээврийн зам талбай, карьер, овоолгын усалгааг хийдэг.<br>- Зам усалгааны ажлын мэдээг өдөр бүр бүртгэдэг. |
| 2. | | Уурхайн ачиж буулгах талбай болон дотоод замыг услах, хөрс барьцалдуулагч шингэнээр шүрших (CaCl, MgCl-н хольц, FLOSET SR71 г.м) туршилт судалгаа хийх | Зам талбайн усалгаанд уурхайн ашиглалтын явцад үүсэх шүүрлийн усыг ашигладаг.<br>Усны газраас гаргасан усны боломжит нөөцийн дүгнэлтэд уурхайн зам талбай болон ногоон байгууламжийн усалгаанд ашиглах усны хэрэглээг шүүрлээр орж ирэх усаар хангахад хүрэлцээтэй байна гэж үзсэн.<br>Уурхайн зам талбайн усалгааг өдөрт 3-5 удаа хийдэг бөгөөд Дундговь аймгийн УЦУОХШ-ний төвөөс хийсэн агаарын нарийн тоосонцрын шинжилгээний дүнгээс үзэхэд уурхайн орчимд үүсэх тоосжилт харьцангүй бага байна. Иймд нэмэлт барьцалдуулагч шингэн ашиглах шаардлагагүй гэж үзлээ. |

<table>
<tr><td></td><td></td><td></td><td>



<table>
<tr><th></th><th>Нийт тоос /20 минут/</th></tr>
<tr><td>Карьер</td><td>0.08</td></tr>
<tr><td>Уурхай дотор</td><td>0.13</td></tr>
<tr><td>Засварын газар</td><td>0.035</td></tr>
<tr><td>Тээврийн зам</td><td>0.384</td></tr>
<tr><td>Ажлын байр дотор</td><td>0.162</td></tr>
<tr><td>Цайны газрын гадна</td><td>0.028</td></tr>
<tr><td>Зааварчилгааны өрөө</td><td>0.037</td></tr>
<tr><td>Хүлцэх хэмжээ</td><td>0.5</td></tr>
</table>
</td></tr>
<tr><td>3.</td><td></td><td>Хүнд механизм утааны хэмжээг стандартын шаардлага хангах хэмжээнд байлгах талаар засвар үйлчилгээг тогтмол явуулах. (бусад уурхайн жишгийн дагуу 200 мото/цаг) Хөдөлгүүрээс гарах утааны найрлага стандартад заасан хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд шүүлтүүр, гүйцэд исэлдүүлэх хэрэгсэл төхөөрөмж</td><td>
Уурхайн техник хэрэгслүүдийг тогтмол хугацаанд нь оношилгоонд оруулж засвар үйлчилгээг тогтмол хийдэг.
ОХШХөтөлбөрийн хүрээнд 4 болон 10-р сард хийгдсэн агаар бохирдуулагч хийн агууламжийг тодорхойлох шинжилгээний үр дүнг Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага 4585:2016 стандартад заасан бохирдуулагч бодисын хүлцэх хэмжээтэй харьцуулж үзэхэд давсан үзүүлэлт байхгүй байна.
Хүснэгт 2.
<table>
<tr><th rowspan="2">Сорьц авсан цэг</th><th colspan="2">SO2 мг/м3</th><th colspan="2">NO2 мг/м3</th></tr>
<tr><th>4-р сар</th><th>10-р сар</th><th>4-р сар</th><th>10-р сар</th></tr>
<tr><td>Ажилчдын хотхон</td><td>0.017</td><td>-</td><td>0.049</td><td>-</td></tr>
<tr><td>Карьер</td><td>-</td><td>0.007</td><td>-</td><td>-</td></tr>
<tr><td>Уурхайн дотор</td><td>0.088</td><td>0.011</td><td>0.052</td><td>0.057</td></tr>
<tr><td>Нүүрсний агуулах</td><td>0.032</td><td></td><td>0.02</td><td></td></tr>
<tr><td>Тээврийн зам</td><td>-</td><td>0.005</td><td>-</td><td>0.039</td></tr>
<tr><td>Хүлцэх агууламж</td><td colspan="2">0.45</td><td colspan="2">0.2</td></tr>
</table>
</td></tr>
</table>

| | | | |
|---|---|---|---|
| | | тавих /TWCAT002, Уурхайн хотхонд байрлах уурын зуухны янданд шүүлтүүр суурилуулах. | |
| 4. | | Уурхайн талбайд ажиллах авто тээврийн хэрэгслийн хурдыг /40км/ боломжит хэмжээгээр хязгаарлах арга хэмжээ авах | Уурхай дотор тээврийн хэрэгслийн хурдыг 40 км-аас хэтрүүлэхгүй байх тэмдэг тэмдэглэгээг уурхайн дотоод зам дагуу байрлуулсан. |
| 5. | | Уурхайн карьер, овоолгод ажиллаж байгаа ачиж буулгах, тээвэрлэх машин техникийн кабин доторх агаарыг цэвэршүүлэх төхөөрөмж хэрэгслийн бүрэн бүтэн байдал, хаалга, цонхны чигжээс, хамгаалалтын үзлэгийг тогтмол хийж, зөрчил илэрсэн тохиолдолд шуурхай арга хэмжээ авч байх | Уурхайд ашиглаж байгаа техникүүдийн үзлэг оношилгоог тогтмол хийдэг бөгөөд өглөө оройны ээлжийн операторууд ээлж солихдоо техникийн агаар шүүгч, хаалга, цонхны чигжээс болон бусад эд ангийн бүрэн бүтэн байдал, хэвийн ажиллагааг шалган бүртгэл хөтөлдөг. |

| | | | |
|---|---|---|---|
| 6. | | Уурхайн дотор замыг тэмдэгжүүлж, засаж сайжруулж байх | Уурхайн дотоод болон гадаад тээврийн замыг засаж, замын тэмдэг тэмдэглэгээг байрлуулсан. |
| 7. | | Замын ачааллын хяналтыг тэнцвэржүүлэх, шороон замаар зорчих ачааны автомашинуудын хоорондын зайг 20 секундээс 30 м-с их байхаар хугацаа болон хоорондох зайг тогтоох. | Уурхайн шороон замаар зорчих тээврийн машин болон бусад автомашин хоорондын зайг 50 м байхаар тогтоож замын тэмдгийг байрлуулсан. |
| 8. | | Нүүрс ачсан бүх тээврийн хэрэгсэл ачааны хэсгийг бүтээлэгтэй байлгах тал дээр анхаарч, шаардлага тавьж ажиллах | Нүүрс ачсан тээврийн хэрэгсэл бүрийг бүтээлэгтэй тээвэрлэлтэд гаргадаг.  *Зураг 2. Тээврийн машин ачааны хэсгийг бүтээсэн байдал.* |

| | | | |
|---|---|---|---|
| 9. | | Тоосноос эрүүл мэндээ хамгаалах нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, хүнсний нэмэлт бүтээгдэхүүнээр ажилчдыг хангах, тэдэнд сургалт, сурталчилгаа явуулах | - Уурхайн тоос их үүсэх хэсэгт буюу карьер, засварын талбайд ажиллаж байгаа ажилчдыг тоосноос хамгаалах шүүлтүүртэй маскаар хангадаг.<br>- Хүйтний улиралд ажилчдын дархлааг дэмжих зорилгоор аарц, чанаргана зэрэг хүнсний нэмэлт бүтээгдэхүүнээр хангадаг.<br>- Мөн уурхайн эмнэлэгийг шаардлагатай эм тариагаар бүрэн хангаж, өглөө болон оройн ээлжийн ажилчдын ажил эхлэхээс өмнө эмчийн үзлгийг тогтмол хийдэг. |
| 10. | Хөрсөн бүрхэвч | Шинээр эвдрэлд өртөх талбайн шимт хөрсийг 20-25 см зузаантайгаар хуулж овоолгод хадгалах | Шинээр хөрс хуулалтын ажил хийгдсэн талбай, хөрсний овоолгын талбайн шимт хөрсийг хуулж биологийн нөхөн сэргээлтэд ашиглахаар тусад нь овоолго үүсгэсэн.<br><br>*Зураг 3. Шимт хөрсний овоолго* |

| | | | |
|---|---|---|---|
| 11. | | ШТМ-ыг стандартын шаардлага хангасан саванд хадгалах, асгарч алдагдахаас сэргийлэх, байгаль орчныг бохирдуулахаас хамгаалах, бохирлогдсон тохиолдолд саармагжуулах, аюулгүй болгох арга хэмжээ авах, машин механизмын засвар үйлчилгээг тусгай зориулалтын талбайд хийх, хучилт хийх, урсгал засварыг тогтмол гүйцэтгэх | - Уурхайн үйл ажиллагаанд ашиглах тос, тосолгооны материалыг тусдаа зориулалтын агуулахад хадгаладаг.<br>Химийн бодис хадгалах агуулах нь Химийн бодисын агуулахад тавиглах ерөнхий шаардлага MNS 6458:2014 стандартад заасан дараах шаардлагуудыг хангасан.<br>Агуулах нь: Галд тэсвэртэй материалаар хийгдсэн, тос, тосолгооны материал асгарч хөрсөнд нэвчихээс сэргийлсэн бетонон суурьтай, суурь болон ханны завсраар шатах тослох материал асгарч, алдагдахаас сэргийлсэн зай завсаргүй, хур бороoны ус тогтохооргүй налуу дээвэртэй.<br>- Машин техникийн засвар үйлчилгээ хийх тусгай зориулалтын хатуу хучилттай талбай байгуулсан.<br>- Шатах тослох материал хөрсөнд асгарсан тохиолдолд бохирдсон хэсгийн хөрсийг хуулж, шинээр хөрс дэвсэх арга хэмжээг авч ажиллана.<br>- Техникүүдийн үзлэг оношилгоо, шаардлагатай засвар үйлчилгээг тогтмол хийдэг. Уурхайд ашиглаж байгаа техник бүр техник ашиглалтын паспорттой. |
| 12. | | Машин механизмын засвар үйлчилгээг тусгай зориулалтын талбайд хийх, хучилт хийх, урсгал засварыг тогтмол гүйцэтгэх Ахуйн хатуу, шингэн хог хаягдал болон химийн бодисыг эмх цэгцтэй хадгалах, устгах, зайлуулах, | - Уурхайн үйл ажиллагаанд ашиглах тос, тосолгооны материалыг тусдаа зориулалтын агуулахад хадгаладаг.<br>- Машин техникийн засвар үйлчилгээ хийх хэсгийг ШТМ хөрсөнд алдахаас сэргийлж хатуу хучилттай болгосон.<br>- Ахуйн хэрэглээний хатуу хог хаягдлыг ангилан хадгалж Баянжаргалан сумын ЗДТГ-тай энгийн хог хаягдлын гэрээ байгуулан сумын нэгдсэн хогийн цэгт хүргэдэг.<br>- Ахуйн хэрэглээний бохир усыг одоогоор хөрсөнд нэвчүүлэх замаар зайлуулж байна. Цаашид хэрэглээнээс гарсан бохир усыг бохир усны цооногт хуримлуулж “Дундговь-Ус” газартай байгуулсан гэрээний дагуу нийлүүлнэ.<br>- Засварын талбайд аюултай хог хаягдал цугуулах цэгийг байгуулж, аюултай хог хаягдлын гэрээг “Элемент” ХХК-тай байгуулан хүлээлгэж өгдөг. |

| | | | |
|---|---|---|---|
| | | тогтмол хяналт тавьж ажиллах | |
| 13. | | Уулын ажлын төлөвлөгөөний дагуу ажиллах. | Уурхайн 2024 оны уулын ажлын төлөвлөгөөг боловсруулан батлуулж төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаа явуулж байна. |
| 14. | | *Уурхайн үйл ажиллагаанаас хөндөгдсөн газарт мониторинг хийж холбогдох арга хэмжээг тухай бүр авах* | Олборлолтын үйл ажиллагааны явцад 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу маркшейдерийн хэмжилтийн ажлаар ямар хэмжээний уулын цул, ахилт хийсэн хэсгийг бүртгэж тайланд оруулдаг. |
| 15. | | Шимт хөрсийг нөхөн сэргээлтэнд ашиглахгүй 2 жилээс дээш хугацаанд хадгалсан бол ургамалжуулах | 2024 оны БОМТөлөвлөгөөг төслийн БОННҮ-ний нэмэлт тодотголын ажил хийсэнтэй холбоотой 2024 оны 09-р сард боловсруулж батлуулсан.<br>Төлөвлөгөө батлагдах үед биологийн нөхөн сэргээлт хийх хугацаа өнгөрсөн байсан тул тус ажлыг 2025 оны хавар хийнэ. |
| 16. | Гадаргын болон газрын гүний ус | Уурхайн шүүрлийн ус болон уурхайн унд ахуйд хэрэглэж буй гүний усны худгаас тогтмол хугацаанд дээж авч бохирдлыг хянаж, зохих арга хэмжээнүүдийг жил бүрийн БОМТ-нд тусган сөрөг нөлөөллийн эх үүсвэрийг арилгах, таслан зогсоох ажлыг | Усны шинжилгээг 4 болон 10 саруудад хийсэн. 4-р сард Дундговь аймгийн УЦУОШГ гэрээ байгуулан гүний худаг болон шүүрлийн усны шнжилгээ хийлгэж, 10-р сард уурхайн ухлагын явцад шүүрэн орж ирэх ус, гүний худаг, ундны уснаас дээж авч “Инженер геодези” ХХК-ийн итгэмжлэгдэж лабораториор шинжлүүлсэн.<br>*Унд ахуйн хэрэглээний ус.* Ажилчдын унд ахуйн хэрэглээний усны дээжинд 4 болон 10 сард хийсэн химийн задлан шинжилгээний үр дүнг Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900:2018 стандарттай харьцуулан үзэхэд 4-р сарын шинжилгээгээр зөвшөөрөгдсөн хэмжээнээс давсан үзүүлэлт байхгүй байна. Харин 10-р сард хийсэн шинжилгээгээр /$Ca^{2+}$/ агууламж стандарт хэмжээнээс 4.21-ээр давсан, |

тогтмол авч хэрэгжүүлж ажиллах

магнийн агууламж /$Mg^{2+}$/ стандартад заасан хэмжээнээс хайрцангүй өндөр агууламжтай байна.

Усны ерөнхий хатуулаг 5.90 мг-экв/л буюу хатуувтар, pH 7.91 сул шүлтлэг ус байна.

*Хүснэгт 3. Ундны усны химийн задлан шмнжилгээний дүнг MNS0900:2018 стандартад зөвшөөрөгдсөн хэмжээтэй харьцуулсан харьцуулалт,*

| Анион | 4-р сар, мг/л | 10-р сар, мг/л | **MNS 0900:2018** | Катион | 4-р сар, мг/л | 10-р сар, мг/л | **MNS 0900:2018** |
|---|---|---|---|---|---|---|---|
| $Cl^-$ | - | 109.90 | **350.0** | Na+K | 7.2 | 218.69 | - |
| $SO_4^{2-}$ | 6.5 | 183.86 | - | $NH_4^+$ | 0.07 | 0.00 | **1.5** |
| $NO_3^-$ | 0.16 | 0.69 | **50.0** | $Ca^{2+}$ | 1.6 | 104.21 | **100.0** |
| $NO_2^-$ | 0.001 | 0.01 | **1.0** | $Mg^{2+}$ | 1.6 | 160.51 | **30.0** |
| $CO_3^{2-}$ | - | 0.00 | - | $Fe^{2+}$ | - | 0.20 | - |
| $HCO_3^-$ | 23.2 | 1281.42 | - | $Fe^{3+}$ | - | 0.30 | - |
| Дүн | | 1575.87 | | Дүн | | 483.91 | |



<table>
<tr>
<td></td>
<td></td>
<td></td>
<td>

*Зураг 4. Хиймийн элементүүдийг агууламжыг стандартын зөвшөөрөгдсөн хэмжээтэй харьцуулсан үзүүлэлт*

<u>*Уурхайн шүүрлийн ус.*</u>

<table>
<tr><th>Анион</th><th>мг/л</th><th>Хүлцэх агууламж MNS 0900:2018</th><th>Катион</th><th>мг/л</th><th>Хүлцэх агууламж MNS 0900:2018</th></tr>
<tr><td>$CI^-$</td><td>248.15</td><td>350.0</td><td>Na+K</td><td>237.05</td><td>-</td></tr>
<tr><td>$SO_4^{2-}$</td><td>184.03</td><td>-</td><td>$NH_4^+$</td><td>0.10</td><td>1.5</td></tr>
<tr><td>$NO_3^-$</td><td>0.34</td><td>50.0</td><td>$Ca_2^+$</td><td>112.22</td><td>100.0</td></tr>
<tr><td>$NO_2^-$</td><td>0.03</td><td>1.0</td><td>$Mg_2^+$</td><td>183.62</td><td>30.0</td></tr>
<tr><td>$CO_3^{2-}$</td><td>36.00</td><td>-</td><td>$Fe_2^+$</td><td>0.30</td><td>-</td></tr>
<tr><td>$HCO_3^-$</td><td>1195.99</td><td>-</td><td>$Fe_3^+$</td><td>0.00</td><td>-</td></tr>
<tr><td>Нийт дүн</td><td>1664.55</td><td></td><td>Нийт дүн</td><td>533.29</td><td></td></tr>
</table>

Усны ерөнхий хатуулаг 20.70 мг-экв/л буюу маш хатуу, pH 8.56 байгаа нь Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага MNS 4943:2015 стандартад заасан зөвшөөрөгдөх хэмжээнээс даваагүй байна.

</td>
</tr>
<tr>
<td>17.</td>
<td></td>
<td>Уурхай ажил явагдах нийт хугацаанд ШТМ болон хорт хаягдал асгарахаас сэргийлэх тэдгээрийг ил задгай хаяхгүй байх ШТМ хөрсөнд шууд асгарсан тохиолдолд түүнийг саармагжуулах, зайлуулах арга хэмжээг авч ажиллах</td>
<td>

- Засварын талбайд ашигласан тос, тосолгооны материалын хаягдал цугларуулах цэгийг тохижуулсан.
- Машин техникийн засвар үйлчилгээ хийх хэсгийг хатуу хучилттай болгосон.
- ШТМ хөрсөнд асгарсан тохиолдолд бохирдсон хөрсийг хуулан шинэ хөрсөөр хучих арга хэмжээг авна.

</td>
</tr>
</table>

<table>
<tr><td>18.</td><td></td><td>Ил уурхайн дэргэд газрын доорх усны түвшин, чанарын өөрчлөлтийг хянах мониторингийн цооног байгуулах, тогтмол хэмжилт дээжлэлт хийж байх</td><td>Ордын хайгуулын ажлын үед гидрогеологийн судалгааны ажилд ашиглах зорилгоор гаргасан Н-2, Н-2А цооногуудад усны түвшингийн хэмжилт хийсэн цаашид тус цооногуудад  хэмжилт дээжлэлтийг тогтмол хийж байна.
<table>
<tr><td rowspan="2">Цооногийн дугаар</td><td colspan="2">Усны түвшин</td></tr>
<tr><td>Хэмжилт-1</td><td>Хэмжилт-2</td></tr>
<tr><td>Н-2</td><td>31.15</td><td>31.20</td></tr>
<tr><td>Н-2А</td><td>31.10</td><td>31.13</td></tr>
<tr><td>Хэмжилт хийсэн огноо</td><td>2024.12.05</td><td>2024.12.09</td></tr>
</table>
Усны түвшний хэмжилтийг эхний хэмжилт хийсэн өдрөөс гурван хоногийн дараа дахин хэмжихэд Н-2 цоонгийн усны түвшин 3 см, Н-2А цооног 5 см-аар нэмэгдсэн байна.<br>Усны түвшний хэмжилт хийх хугацаанд уурхайн шүүрлийн ус соруулах ажлыг зогсоосон байсан.</td></tr>
<tr><td>19.</td><td></td><td>Төслийн хэрэглээнд ашиглаж буй усны зарцуулалтыг хэмжих зорилгоор ашиглаж буй усны эх үүсвэрт мэргэжлийн байгууллагаар баталгаажуулсан тоолуур тавих</td><td>- Төслийн унд ахуйн хэрэглээнд ашигладаг гүний худагт тоолуур суурилуулсан,<br>- Уурхайн шүүрлийн ус соруулах хэсэгт Дундговь аймгийн "Дундговь-Ус" ОНӨААТҮГазарт хүсэлт хүргүүлэн бэлтгэл ажлыг ханган, тоолуур суурилуулах ажлын төлбөрийг төлсөн байгаа ч одоогоор шүүрлийн ус соруулах хэсгийн хоолой хөлдсөнтэй холбоотой тоолуур суурилуулах ажил хийгдэх боломжгүй болсон байна. 2025 оны нэгдүгээр улиралд багтаан мэргэжлийн байгууллагатай хамтран тоолуур суурилуулж үүссэн зөрчлийг арилган, цаашид усны төлбөр тооцоог тоолуурын заалтын дагуу төлнө.</td></tr>
<tr><td>20.</td><td>Ургамал амьтны аймаг</td><td>Барилга байгууламж, ажилчдын хотхоны гадна талбайд ногоон байгууламж бий болгох зорилгоор мод сөөг тарьж ургуулах</td><td>2024 оны хавар уурхайн кемпийн гадна 500 ширхэг хайлаас мод шуудуулан тарьсан.<br><u>Мод тарьсан талбайн солбицол</u>
<table>
<tr><td>№</td><td>Өргөрөг</td><td>Уртраг</td></tr>
<tr><td>1</td><td>45°43'13.55"N</td><td>107°41'58.34"E</td></tr>
<tr><td>2</td><td>45°43'13.09"N</td><td>107°42'0.22"E</td></tr>
<tr><td>3</td><td>45°43'13.01"N</td><td>107°42'0.16"E</td></tr>
<tr><td>4</td><td>45°43'13.51"N</td><td>107°41'58.25"E</td></tr>
</table></td></tr>
</table>

| | | | |
|---|---|---|---|
| 21. | | Зэрлэг амьтдын амьдардаг гол тархац нутаг, уст цэг орчимд хужир шүү, тэжээл тавих, өвөл хаврын хуурайшилт ихтэй үед усан хангамжийг сайжруулах зэргээр биотехнологийн арга хэмжээг орон нутгийн захиргаатай хамтран зохион байгуулах | Тус ажлын хүрээнд манай байгууллага нийт 100 боодол өвс худалдан авч Баянжаргалан сумын байгаль орчны хяналтын улсын байцаагч болон байгаль хамгаалагч нарт хүлээлгэн өгсөн бөгөөд хавар хоёрдугаар сард өвс тэжээл муу үед зэрлэг амьтдын тархац нутаг, уст цэгүүдэд тараан тавихаар төлөвлөсөн. |
| 22. | | Ашиглалтын талбайд гидрогеологийн нарийвчилсан судалгаа хийлгэх | 2013 оны үр дүнгийн тайланд гидрогеологийн судалгааны ажил хийгдсэн бөгөөд уурхайн шүүрлийн ус шавхан зайлуулахтай холбоотой ус ашиглах дүгнэлт (2024.10.03)-д шүүрлийн усны хэмжээтэй зөрүүтэй гарсан. Тус ажлыг 2025 онд мэргэжлийн байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлнэ. |
| 23. | | Шүүрлийн ус зайлуулах хөв цөөрөм байгуулах, усны мэргэжлийн байгууллагаар судалгаа хийлгэх | Тус ажлыг 2025 оны төлөвлөгөөнд тусгаж мэргэжлийн байгууллагатай хамтран хийж эхэлнэ. |

9, 10-р сарын зам талбайн усалгааны ажлын бүртгэл

| Огноо | Ээлж | Оператор нэр | Хийсэн ажил | Эхэлсэн мот цаг | Дууссан мот цаг | ажилласан мот/цаг | Бүтээлт цаг | Техник ашиглалтын хувь | Түлш зарц | Сул зогсолт: Эхэлсэн | Сул зогсолт: Дууссан цаг | Сул зогсолт: зөрүү | Сул зогсолт, бусад тайлбар | Засвартай зогсолт: Эхэлсэн цаг | Засвартай зогсолт: Дууссан | Засвартай зогсолт: зөрүү | Засвартай зогсолт, бусад тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 01.9-р сар | Өдөр | | | | | | | | | | | | | | | | |
| 02.9-р сар | Өдөр | Лхагвадорж | Зам талбай усалсан (4удаа) | 08:00 | 19:00 | 10 | 10 | 100 | | | | | | | | | |
| 03.9-р сар | Өдөр | Лхагвадорж | Зам талбай усалсан (3удаа) | 08:00 | 19:00 | 10 | 10 | 100 | | | | | Тог тасарсан. | | | | |
| 04.9-р сар | Өдөр | Лхагвадорж | Зам талбай усалсан (5удаа) | 08:00 | 19:00 | 10 | 10 | 100 | | | | | | | | | |
| 05.9-р сар | Өдөр | Лхагвадорж | | | | | 10 | 0 | | | | | | 08:00 | 19:00 | 10:00 | Засварт орсон. |
| 06.9-р сар | Өдөр | Лхагвадорж | Зам талбай усалсан(3удаа) | 14:00 | 19:00 | 5 | 10 | 50 | | | | | | 08:00 | 13:00 | 05:00 | Засварт орсон. |
| 07.9-р сар | Өдөр | Лхагвадорж | Зам талбай усалсан(5удаа) | 08:00 | 19:00 | 10 | 10 | 100 | | | | | | | | | |
| | Шөнө | Мягмардорж | Технологийн замд усалгаа хийв | 20:00 | 07:00 | 10 | 10 | 100 | | | | | | | | | |
| 08.9-р сар | Өдөр | Лхагвадорж | Зам талбай усалсан(5удаа) | 08:00 | 19:00 | 10 | 10 | 100 | | | | | | | | | |
| | Шөнө | Мөнхзул | Зам талбай усалсан(4удаа) | 20:00 | 07:00 | 6.9 | 10 | 69 | | 23:30 | 02:40 | 03:10 | Агаарын саатал шороон шуурга болсон. | | | | |
| 09.9-р сар | Өдөр | Лхагвадорж | Зам талбай усалсан(5удаа) | 08:00 | 19:00 | 10 | 10 | 100 | | | | | | | | | |
| | Шөнө | Мөнхзул | Зам талбай усалсан(5удаа) | 20:00 | 07:00 | 10 | 10 | 100 | | | | | | | | | |
| 10.9-р сар | Өдөр | Лхагвадорж Мягмардорж | Зам талбай усалсан(3удаа) | 08:00 | 19:00 | 10 | 10 | 100 | | | | | 16:00 ээлжээ сольсон. | | | | |
| | Шөнө | Мөнхзул | Зам талбай усалсан(4удаа) | 20:00 | 07:00 | 10 | 10 | 100 | | | | | | | | | |
| 11.9-р сар | Өдөр | Мягмардорж | Технологийн замд усалгаа хийв | 08:00 | 19:00 | 10 | 10 | 100 | | | | | | | | | |
| | Шөнө | Мөнхзул | Зам талбай усалсан | 20:00 | 07:00 | 10 | 10 | 100 | | | | | | | | | |
| 12.9-р сар | Өдөр | Мягмардорж | Технологийн замд усалгаа хийв | 08:00 | 19:00 | 10 | 10 | 100 | | | | | | | | | |
| | Шөнө | Мөнхзул | | | | | 10 | 100 | | 20:00 | 07:00 | 10:00 | Агаарын саатал бороо орж зогссон. | | | | |
| 13.9-р сар | Өдөр | Мягмардорж | | | | | 10 | 100 | | 08:00 | 19:00 | 10:00 | Бороо орж зам талбайд усалгаа шаардлагагүй тул нөөцөнд зогссон. | | | | |
| 14.9-р сар | Өдөр | Мягмардорж | Технологийн замд усалгаа хийв. | 08:00 | 19:00 | 10 | 10 | 100 | | | | | | | | | |
| 15.9-р сар | Өдөр | | | | | | 10 | 0 | | | | | | | | | |
| 16.9-р сар | Өдөр | | | | | | 10 | 0 | | | | | | | | | |
| 17.9-р сар | Өдөр | Ганбаатар | Зам талбай усалсан. | 08:00 | 19:00 | 10 | 10 | 100 | | | | | | | | | |
| 18.9-р сар | Өдөр | Ганбаатар | Зам талбай усалсан. | 08:00 | 19:00 | 10 | 10 | 100 | | | | | | | | | |
| 19.9-р сар | Өдөр | Ганбаатар | Зам талбай усалсан. | 08:00 | 19:00 | 10 | 10 | 100 | | | | | | | | | |
| 20.9-р сар | Өдөр | Ганбаатар | Зам талбай усалсан. | 08:00 | 19:00 | 10 | 10 | 100 | | | | | | | | | |
| 21.9-р сар | Өдөр | Ганбаатар | Зам талбай 3 удаа усалсан. | 08:00 | 19:00 | 10 | 10 | 100 | | | | | | | | | |
| 22.9-р сар | Шөнө | Ганбаатар | Зам талбай 4 удаа усалсан. | 08:00 | 19:00 | 10 | 10 | 100 | | | | | | | | | |
| 23.9-р сар | Өдөр | Ганбаатар | Зам талбай 5 удаа усалсан. | 08:00 | 19:00 | 10 | 10 | 100 | | | | | | | | | |
| 24.9-р сар | Шөнө | Ганбаатар | Зам талбай усалсан. | 08:00 | 19:00 | 10 | 10 | 100 | | | | | | | | | |
| 25.9-р сар | Өдөр | Ганбаатар | Зам талбай усалсан. | 08:00 | 19:00 | 10 | 10 | 100 | | | | | | | | | |
| 26.9-р сар | Шөнө | Ганбаатар | Зам талбай усалсан. | 08:00 | 19:00 | 10 | 10 | 100 | | | | | | | | | |
| 27.9-р сар | Өдөр | Ганбаатар | Зам талбай усалсан. | 08:00 | 19:00 | 10 | 10 | 100 | | | | | | | | | |
| 28.9-р сар | Шөнө | Ганбаатар | Зам талбай усалсан. | 08:00 | 19:00 | 10 | 10 | 100 | | | | | | | | | |
| 29.9-р сар | Өдөр | Ганбаатар | | | | | 10 | 100 | | 08:00 | 19:00 | 10 | Агаарын саатал бороо орж зогссон. | | | | |
| 30.9-р сар | Шөнө | Ганбаатар | | | | | 10 | 100 | | 08:00 | 19:00 | 10 | Агаарын саатал бороо орж зогссон. | | | | |

**“Хөөтийн хонхор-2 нэртэй нүүрсний ордыг ашиглах” төслийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан**

| Огноо | Ээлж | Оператор нэр | Хийсэн ажил | Эхэлсэн мот/цаг | Дууссан мот цаг | Ажил ласан мот/ цаг | Бүтээлт цаг | Техник ашиглалтын хувь | Түлш зарц | Сул зогсолт | | | Сул зогсолт, бусад тайлбар | Засвартай зогсолт | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | Эхэлсэн цаг | Дууссан цаг | зөрүү | | Эхэлсэн цаг | Дууссан цаг | зөрүү |
| 01.10-р сар | Өдөр | | | | | | 10 | 0 | | 08:00 | 19:00 | 10:00 | Оператор байхгүй. | | | |
| 02.10-р сар | Өдөр | | | | | | 10 | 0 | | 08:00 | 19:00 | 10:00 | Оператор байхгүй. | | | |
| 03.10-р сар | Өдөр | | | | | | 10 | 0 | | 08:00 | 19:00 | 10:00 | Оператор байхгүй. | | | |
| 04.10-р сар | Өдөр | | | | | | 10 | 0 | | | | | | | | |
| | Шөнө | Б.Мөнхзул | Зам талбай усалсан | 20:00 | 00:10 | 4.2 | 10 | 42 | | 00:10 | 07:00 | 05:50 | Агаарын саатал. | | | |
| 05.10-р сар | Өдөр | Ганбаатар | | | | | 10 | 0 | | 08:00 | 19:00 | 10:00 | Агаарын саатал. | | | |
| 06.10-р сар | Өдөр | Ганбаатар | | | | | 10 | 0 | | 08:00 | 19:00 | 10:00 | Агаарын саатал. | | | |
| 07.10-р сар | Өдөр | Ганбаатар | | | | | 10 | 0 | | 08:00 | 19:00 | 10:00 | Агаарын саатал. | | | |
| 08.10-р сар | Шөнө | Ганбаатар | | | | | 10 | 0 | | 08:00 | 19:00 | 10:00 | Агаарын саатал. | | | |
| 09.10-р сар | Өдөр | Ганбаатар | | | | | 10 | 0 | | 08:00 | 19:00 | 10:00 | Агаарын саатал. | | | |
| 10.10-р сар | Шөнө | Ганбаатар | | | | | 10 | 0 | | 08:00 | 19:00 | 10:00 | Агаарын саатал. | | | |
| 11.10-р сар | Өдөр | Ганбаатар | Зам талбай усалсан | 08:00 | 19:00 | 10 | 10 | 100 | | | | | | | | |
| 12.10-р сар | Шөнө | Ганбаатар | Зам талбай усалсан | 08:00 | 19:00 | 10 | 10 | 100 | | | | | | | | |
| 13.10-р сар | Өдөр | Ганбаатар | Зам талбай усалсан | 08:00 | 19:00 | 10 | 10 | 100 | | | | | | | | |
| 14.10-р сар | Шөнө | Ганбаатар | Зам талбай усалсан | 08:00 | 19:00 | 10 | 10 | 100 | | | | | | | | |
| 15.10-р сар | Өдөр | Ганбаатар | Зам талбай 2 удаа усалсан | 08:00 | 19:00 | 10 | 10 | 100 | | | | | | | | |
| 16.10-р сар | Шөнө | Ганбаатар Буянжаргал | Зам талбай 2 удаа усалсан.Буянжаргал усны машинаа | 08:00 | 19:00 | 10 | 10 | 100 | | | | | Ганбаатар ростероор буусан. | | | |
| 17.10-р сар | Өдөр | Н.Буянжаргал | Зам талбай 4 удаа усалсан. | 08:00 | 19:00 | 10 | 10 | 100 | | | | | | | | |
| 18.10-р сар | Шөнө | Н.Буянжаргал | Зам талбай 5 удаа усалсан. | 08:00 | 19:00 | 10 | 10 | 100 | | | | | | | | |
| 19.10-р сар | Өдөр | Н.Буянжаргал | Зам талбай 5 удаа усалсан. | | | | 10 | 0 | | | | | | | | |
| 20.10-р сар | Өдөр | | | | | | 10 | 0 | | 08:00 | 19:00 | 10:00 | Агаарын саатал. | | | |
| 21.10-р сар | Өдөр | | | | | | 10 | 0 | | | | | | | | |
| 22.10-р сар | Өдөр | | | | | | 10 | 0 | | | | | | | | |
| 23.10-р сар | Өдөр | | | | | | 10 | 0 | | | | | | | | |
| 24.10-р сар | Өдөр | Ганбаатар | Зам талбай 3 удаа усалсан. | 08:00 | 19:00 | 10 | 10 | 100 | | | | | | | | |
| 25.10-р сар | Өдөр | Ганбаатар | Зам талбай 3 удаа усалсан. | 08:00 | 19:00 | 10 | 10 | 100 | | | | | | | | |
| 26.10-р сар | Өдөр | Ганбаатар | Зам талбай 3 удаа усалсан. | 08:00 | 19:00 | 10 | 10 | 100 | | | | | | | | |
| 27.10-р сар | Өдөр | | | | | | 10 | 0 | | | | | Бие нь өвдөөд хот явсан. | | | |
| 28.10-р сар | Шөнө | | | | | | 10 | 0 | | | | | | | | |
| 29.10-р сар | Өдөр | | | | | | 10 | 0 | | | | | | | | |
| 30.10-р сар | Шөнө | | | | | | 10 | 0 | | | | | | | | |
| 31.10-р сар | Өдөр | | | | | | 10 | 0 | | | | | | | | |



*Зураг 5. Замын усалгааны ажлын зураг*




*Зураг 6. Замын тэмдэг, тэмдэглэгээ байрлуулсан байдал.*



*Зураг 7. Дотоод тээврийн замыг засаж сайжруулсан, замын 2 талаар хөмсөг татсан.*










*Зураг 8. Эм, тарианы хангамт*




*Зураг 9. Ашигласан тос, тосолгооны материал цугларуулах хэсэг, засвар үйлчилгээ хийх талбай*





*Зураг 10. Кемпийн гадна 500 ширхэг хайлаас мод тарьсан.*



**Тээврийн хэрэгсэл хүлээлцэх акт**

**Парк дугаар...HD-.................** **2024 оны 12 сарын 08 Өдөр**

| № | Эд анги | хэвийн + гэмтэлтэй - | тайлбар |
|---|---|---|---|
| 1 | Маяак | + | |
| 2 | Галын хор | + | |
| 3 | Их гэрэл | + | |
| 4 | Тормозны гэрэл | + | |
| 5 | Ухрахын гэрэл | — | ЗХ гэмтэлтэй, солих |
| 6 | Хаалганы дохио гэрэл | + | |
| 7 | Салхины шил | + | |
| 8 | Толь | + | |
| 9 | Тормозны ажиллагаа | + | |
| 10 | Рулийн ажиллагаа | + | |
| 11 | Моторын ажиллагаа | + | |
| 12 | Хроп | + | |
| 13 | Төхөөрөмжийн ажиллагаа/подъём/ | + | |
| 14 | Тосолгоо | + | |
| 15 | Цэвэрлэгээ үйлчилгээ | + | |
| 16 | Дугуй | + | |
| 17 | Дугуйн ивээс | + | |
| 18 | Гар тормозны ажиллагаа | + | |
| 19 | Агаар шүүгч | + | |
| 20 | Кабины битүүмж | + | |

*Зураг 11. Тээврийн хэрэгсэл хүлээлцэх акт*



*Зураг 12. Машин техникийн галын хор, агаар шүүгч, эмийн сан, хаалга цонхны чигжээсийн бүрэн бүтэн байдлыг харуулсан зураг*

**4.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө**

| Д/д | Нөхөн сэргээлтийн ажлын төлөвлөгөө | Төлөвлөгөөний биелэлт |
|---|---|---|
| 1. | Техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн арга хэмжээнд жил бүр хуримтлуулах хөрөнгө | Манай байгууллага нь жил бүрийн уулын ажлын төлөвлөгөө болон тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нөхөн сэргээлтийн ажлын зардлыг тусган батлуулдаг. |
| 2. | Олборлолтын үйл ажиллагаа явуулсан талбайд дотоод овоолгоор нөхөн дүүргэлт хийж тэгшлэх түрэх техникийн нөхөн сэргээлт хийх | 2024 оны нөхөн сэргээлтийн ажлын хүрээнд ашиглалтын талбайн дотоод тээврийн зам дагуу хүнд машин механизмын хөдөлгөөнөөр эвдэрсэн 1 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийж Баянжаргалан сумаас томилогдсон ажлын хэсэгт хүлээлгэн өгсөн**.** |
| 3. | Тэр бум тод үндэсний хөдөлгөөний хүрээнд | Манай байгууллага “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 2030 он хүртэл 5000 ширхэг мод тарихаар Ойн газартай гэрээ байгуулсан. “Хөөтийн хонхор-2” төслийн хүрээнд БОННҮ-ний 5 жилийн хугацаанд 2500 ширхэг модыг тарихаар төвлөсөн.<br>Энэхүү ажлын хүрээнд 2024 оны хавар 5-р сард уурхайн кемпийн гадна 500 ширхэг хайлаас мод суулгацаар тарьсан. |








*Зураг 13. Дотоод тээврийн замын нөхөн сэргээлтийн ажлын зураг.*

**4.3. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах ажлын төлөвлөгөө**

| Д/д | Төлөвлөсөн ажил | Төлөвлөгөөний биелэлт |
|---|---|---|
| 1. | Дүйцүүлэн хамгаалалт хийх газрын хөрс цаг уурын суулгахад тохиромжтой мод, бут, сөөгийг тодорхойлох төлөвлөгөө гаргах | Хийгдээгүй. |
| 2. | Дүйцүүлэн хамгаалалт хийх газрын шаардлагатай хэсэгт техникийн нөхөн сэргээлт хийх | Дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль”-д заасны дагуу орон нутгаас зааж өгсөн бичил уурхайчдын үйл ажиллагаагаар эвдрэлд өртсөн 1061 $м^2$ талбайд 5300$м^3$ уулын цулаар дүүргэлт, хэлбэршүүлэлт хийн техникийн нөхөн сэргээлтийн ажил хийсэн.<br>Ажилласан техник: утгуурт ачигч-1, автосамосвал-2.<br>Талбайн эвдэрсэн байдал.<br>Нийтдээ 2350 м2 талбайд 16847.3 $м^3$ эзэлхүүн бүхий 20 м гүн, 24 м өргөн, 98 м урт жалга үүссэн байна. |
| 3. | Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээнд тариалах модлог ургамлын төрөл зүйлийг өсгөж үржүүлэх плантац, үржүүлгийн талбай, хүлэмж байгуулах Бэлчээрийн талбайг ургамалжуулж хашиж хамгаалах | 2024 оны дүйцүүлэн хамгаалах ажил 11-р сард хийгдсэн ургамлын ургах, тариалах хугацаа өнгөрсөн тул 2025 оны БОМТөлөвлөгөөнд тусган ирэх оны хавар хийнэ. |
| 4. | Хөөтийн булгийн эхийг хашиж, хамгаалах, ундарга, усны чанарыг тогтмол хянаж ажиллах | 2023 оны БОМТ- нд тусгасны дагуу Хөөтийн булгийн эхийг хашаалсан бөгөөд сар бүр булгийн ойр орчмын хог хаягдлыг цэвэрлэх ажлыг гүйцэтгэж байна. |
| 5. | Зэрлэг амьтдын амьдардаг гол тархац нутаг, уст цэг орчимд хужир шүү, тэжээл тавих, өвөл хаврын хуурайшилт ихтэй үед усан хангамжийг сайжруулах зэргээр биотехнологийн арга хэмжээг орон нутгийн захиргаатай хамтран зохион байгуулах | Тус ажлын хүрээнд нийт 100 боодол өвс худалдан авч нөөцөлсөн байгаа бөгөөд хавар өвс тэжээл ховордсон тарчиг үед Баянжаргалан сумын Байгаль орчны хяналтын улсын байцаагч болон байгаль хамгаалагчтай хамран тус сумын нутгийн зэрлэг амьтдын гол тархац нутгуудад уст цэг орчмоор тараан байрлуулна. |

| | | |
|---|---|---|
| 6. | Нутгийн иргэдэд нөхөн сэргээлт хийх, мод тарих, байгаль хамгаалах талаар сургалт явуулах | Тус ажлын хүрээнд Баянжаргалан сумын Энгэр ус буюу 2-р багийн иргэдэд говийн нөхцөлд тарихад тохиромжтой модны тухай мэдээлэл өгч, мод тарьсны ач холбогдлын талаар сургалт орсон. |





*Зураг 14. Эвдэрсэн талбайд нөхөн сэргээлт хийхийн өмнөх байдал.*



*Зураг 15. Нөхөн сэргээлтийн ажлын зураг*



*Зураг 16. Булгийн хашаа*



*Зураг 17. Хөөтийн булаг орчмын хог цэвэрлэгээ, 2024.10-р сар*


Nov 28, 2024 at 11:03:38 AM
N 45° 45' 36", E 107° 59' 33"
122° SE
Mongolia
Dundgovi
Altitude:1235.2meter
Speed:0.7km/h
Maps




*Зураг 18. Зэрлэг амьтдын гол тархац нэтгүүдад өвс, тэжээл тавьж өгөх ажлын хүрээнд Баянжаргалан сумын байгаль хамгаалагчид өвс хүлээлгэж өгсөн ажлын зураг.*



*Зураг 19. Багийн ИНХ-ийн үеэр мод тарих тухай сургалт орсон.*

### 4.4. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

| Д/д | Төлөвлөсөн арга хэмжээ | Төлөвлөгөөний биелэлт |
|---|---|---|
| 1. | Хог хаягдлыг ангилан ялгаж, дахин ашигладаг тогтолцоог нэвтрүүлэх | Ажилчдын ахуйн хэрэглээнээс үүсэх хог хаягдлыг дараах гурван төрлөөр ангилан хаях зориулалттай хогийн савыг ажилчдын кемпийн гадна байрлуулсан:<br>- Хуванцар сав, гялгар уут.<br>  - Ангилан ялгах савны өнгө: ногоон<br>- Шил, лааз.<br>  - Ангилан ялгах савны өнгө: улбар шар<br>- Бусад. |
| 2. | Ахуйн хог хаягдлын гэрээг Баянжаргалан сумын ЗДТГазартай байгуулах | Баянжаргалан сумын Засаг Даргын Тамгийн Газартай 2024 оны ахуйн хог хаягдлын гэрээг байгуулж гэрээнд заасан 960,000 төгрөгийн төлбөрийг төлсөн. |

| | | |
|---|---|---|
| 3. | Төслийн талбайд үүссэн бүх хатуу хог хаягдлыг цуглуулж нэгдсэн цэгт хүргэж устгах | Төслийн үйл ажиллагаанаас үүссэн хог хаягдлыг түр хадгалах цэг байгуулж тогтмол хугацаанд сумын хог хаягдлын нэгдсэн цэгт хүргэдэг. |
| 4. | Хог хаягдлыг цуглуулах савыг битүүмж сайтай хийх, ажилчдын байр, оффис, агуулах, ШТС зэрэг газарт байрлуулах, засварлаж байх | - Уурхайн хог хаягдал түр хадгалах хэсэгт битүүмжлэл сайтай, галд тэсвэртэй, төмөр тагтай хогийн сав байрлуулсан.<br>- ШТС, харуулын гадна байр, ажилчдын кемпийн дэргэд хогийн сав мөн байрлуулсан. |
| 5. | Хог хаягдал түр хадгалах цэгийн талбайг нэвчилт явагдахааргүй, ирмэг хөвөө бүхий цементэн суурьтай болгон тохижуулах | Хог хаягдал хадгалах төмөр хогийн сав хийж байрлуулсан. |
| 6. | Хийсэж тархсан болон үүссэн хог хаягдлын овоолгыг тогтмол цэвэрлэж хэвших | - Кемпийн ойр орчмын хог хаягдал болон харуулын байрны гадна тээврийн машин зогсдог хэсгийн хог хаягдлыг тогтмол цэвэрлэдэг.<br>- Мөн хог хаягдал түр хадгалах хэсэгт байрлуулсан хогийн сав дүүрсэн тохиолдолд үүссэн хог хаягдлыг сумын хогийн нэгдсэн цэгт хүргэдэг. |
| 7. | Дахин ашиглах боломжтой ахуйн гаралтай хатуу хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрт гэрээлэн нийлүүлэх ажлыг тогтмол хэрэгжүүлэх | Ажилчдын ахуйн хэрэглээнээс үүссэн дахин боловсруулах боломжтой хог хаягдлыг уурхай дээр ангилан ялгаж байгаа ч одоогоор дахин боловсруулах үйлдвэртэй гэрээ байгуулж нийлүүлээгүй байна. |
| 8. | Бие засах газар, бохир усны цооногийг тогтмол ариутгаж, халдваргүйжүүлж байх | Бие засах газарт тогтмол ариутгал, халдваргүйжүүлэлтийн ажил хийдэг. |
| | ***<u>Аюултай хог хаягдал</u>*** | |
| 9. | Ашиглагдсан тос, тосолгооны материал, аккумляторыг тусгай цэг гарган хуримтлуулах, түр хуримтлуулах цэгийг тохижуулах | Засварын газарт аюултай хог хаягдал түр хадгалах хэсгийг тохижуулсан. |

| | | |
|---|---|---|
| | | <br>*Зураг 20. Аюултай хог хаягдлал түр хадгалах хэсэг* |
| 10. | Ашигласан тос тосолгооны материалыг дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх, гэрээ байгуулах | Ашигласан тос, тосолгооны материалын хаягдлыг “Элемент” ХХК-тай гэрээ байгуулан хүлээлгэж өгдөг. |
| 11. | Хөрс шатах тослох материалаар бохирдсон тохиолдолд бохирдсон хэсгийг ялган авч саармагжуулах арга хэмжээ авах | Хөрсөнд шатах тослох материал асгарсан тохиолдолд бохирдсон хэсгийн шороог хуулж цэвэр шороогоор хучих арга хэмжээ авна. |
| 12. | Аюултай хог хаягдлын зэрэглэлээс хамааран хог хаягдлын цэгт хамгаалалтын бүс хашаа, хашлага татах. Хамгаалалтын бүсийн бүрэн бүтэн байдлыг хангах, хог хаягдлуудыг эмх | Аюултай хог хаягдал түр хадгалах хэсгийн гадуур төмөр тороор хашлага татаж, хашааны гадна аюултай хог хаядал гэсэн тэмдэглэгээ хийсэн. |

| | | |
|---|---|---|
| | цэгцтэйгээр байршуулах, тэмдэг тэмдэглэгээ байршуулах | |



*Зураг 21. ШТС болон харуулын байрны гадна хогийн сав байрлуулсан.*




*Зураг 22. Кемпийн гадна хог хаягдал ангилан ялгах сав байрлуулсан.*




*Зураг 23. Ашигласан тос, тосолгооны материал хадгалах цэгийг тохижуулж, хашаалан тэмдэгжүүлсэн.*

### 4.5. Нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

- Тухайн жилд төслийн хүрээнд нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагаа хийгдэхгүй тул БОМТ-нд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ тусгагдаагүй болно.

### 4.6. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

- Уурхайн ашиглалтын үйл явцад түүх соёлын дурсгалт зүйлс олдвол уурхайн үйл ажиллагааг түр зогсоон зохих байгууллагад мэдэгдэж, түүх соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах ажлыг зохион байгуулах болно.

### 4.7. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

| Д/д | Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ | Арга хэмжээний биелэлт |
|---|---|---|
| | ***Байгалийн гамшиг, аюулт үзэгдлээс үүдэн болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах*** | |
| 1. | Цаг агаарын урьдчилсан мэдээлэлд тулгуурлан уурхайн үйл ажиллагааг байгальд ээлтэйгээр зохицуулах | Төслийн талбайд хамгийн ойр орших Говь-угтаал /46007500/ болон Гурвансайхан /45407000/ цаг уурын станцуудын 2024 оны өдөр бүрийн агаарын дундаж температуурын мэдээ болон хур тунастай болон салхи шуургатай өдрийн мэдээг https://archive.weather.gov.mn/ сайтаас авч цаг агаарын мэдээнд тулгуурлан уурхайн үйл ажиллагааг зохион байгуулж ажилласан. |
| 2. | “Гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ”- мэргэжлийн байгууллагаар хийлгүүлэх | 2024 оны гамшгийн эрсдэлийн үнэлгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн бөгөөд үнэлгээний үр дүнд үндэслэн уурхайн 2024 оны гамшгаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулсан. |
| 3. | “Гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ”-г үндэслэн “Гамшгаас хамгаалах төлөвлөгөө” боловсруулан батлуулж, мөрдөн ажиллаж ажилтан бүрийн ажил үүргийн хуваарийг гаргаж, зааварчилгаа өгөх. | |
| | ***Химийн бодисын эрсдэлийн үнэлгээний дүнд тогтоосон аюултай болон хортой химийн бодис алдагдахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ*** | |
| 4. | Тэсрэх бодисын менежментийн төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх | Ил уурхайн ӨТА-г “Гэт бласт” ХХК-аар гэрээгээр гүйцэтгүүлдэг. |
| 5. | Шатах тослох материал ачиж буулгах, цэнэглэх хэсгийг хатуу хучилттай | Засварын талбайд машин зогсох хэсгийг хатуу хучилттай болгосон. |

| | | |
|---|---|---|
| | болгон, алдагдаж асгарсан тохиолдолд хөрсөнд нэвчүүлэхгүй байх арга хэмжээг авч хэрэгжүүлэх | - Хөрсөнд шатах тослох материал асгарсан тохиолдолд бохирдсон хэсгийн шороог хуулж цэвэр шороогоор хучих арга хэмжээ авч ажиллах тухай уурхайн ажилчдад сургалтаар орж, заавар зөвлөгөө өгсөн. |
| 6. | Тэсрэх бодис, шатах тослох материалын хор аюулын лавлах мэдээллийн агуулгаар сургалт орох | ӨТ-ний ажил хариуцсан компанийн мэргэжилтэн болон уурхайн БО-ны мэргэжилтэн хамтран тэсрэх бодис болон шатах тослох материалын хор аюулын лавлах мэдээллийн агуулгаар сургалт орсон. |
| 7. | Бүх ажилчдыг гал түймэр унтраах мэргэжлийн сургалтад хамруулах | - Нийт ажилчдын дунд гал түймэр унтраах сургалт зохион байгуулсан.<br>- УУАА 09-р ангитай 2025 онд гал түймэр унтраах мэргэжлийн сургалт оруулахаар тохирсон. |
| 8. | Галын дохиолол, гал унтраах багаж хэрэгслийг шаардлагатай газруудад байрлуулах Гал түймрээс сэргийлэх талаар анхааруулга, санамжийн хуудас хийж, шаардлагатай газруудад нүдэнд харагдахуйц газруудад байрлуулах хуурайшилт ихтэй саруудад гал унтраах хэрэгслийн бүрэн бүтэн байдалд хяналтыг ойртуулах тавих | - Кемпийн гадна, зааварчилгааны өрөө, ШТС, засварын талбай, харуулын байрны гадна галын сараа байрлуулсан.<br>- Мөн ажилчдын амрах байх, гал тогоо, оффисын өрөө, зааварчилгааны өрөө, эмнэлэг, ШТС болон уурхайд ашиглагдаж байгаа техник бүрд галын хор байрлуулсан.<br>- Зааварчилгааны өрөө, гал тогоо, эмнэлгийн өрөөнд галын аюул ослоос сэргийлэх тухай самбар байрлуулсан. |
| | ***Үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ*** | |
| 9. | Ажилчдыг ээлжинд гарахын өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгаанд хамруулах | Ажилчдад өглөө, орой ээлжинд гарахаас өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгааг уурхайн хөдөлмөрийн аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн өгдөг. |
| 10. | Ажилчин нэг бүрийг хөдөлмөр хамгааллын хувцас, багаж хэрэгслээр хангах | Нийт ажилчдыг өвөл зуны иж бүрэн хувцас, хөдөлмөр хамгааллын хувцас буюу каск, өндрийн бүс, цацаруулагчтай хантаазаар хангадаг. |
| 11. | Жил бүр мэргэжлийн байгууллага, мэргэжилтний тусламжтайгаар хөдөлмөр 1 хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт зохион байгуулах | Тус ажлыг 2025 онд хийхээр төлөвлөсөн. |

| | | |
|---|---|---|
| 12. | Осол аваар гарч хүний эрүүл мэнд хохирсон тохиолдолд яаралтай анхан шатны тусламж үзүүлэх, анхан шатны тусламжийн эмийн санг машины кабин, ажлын байрт байрлуулах | Уурхайн оффисын өрөө, гал тогоо, зааварчилгааны өрөө болон уурхайд ашиглагдаж байгаа техник бүрд анхан тусламжын эмийн санг байрлуулсан. |
| 13. | Ажилчдыг эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамруулах төлөвлөлтийг хийх, хэрэгжүүлэх | Жилд нэг удаа уурхайн нийт ажилчдыг эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамруулдаг. |





*Зураг 24. Тэсрэх бодис, шатах тослох материалын хор аюулын лавлах мэдээллийн агуулгаар сургалт орсон*



*Зураг 25. Ажилчдад аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч байна.*





*зураг 26. Нийт ажилчдад гал түймрээс сэргийлэх, гал гарсан тохиолдолд авах арга хэмжээний тухай сургалт орсон.*








*Зураг 27. Галын аюулгүй ажиллагааны самбар, галын хор*



*Зураг 28. Кемпийн гадна болон зааварчилгааны өрөөний гаднах галын сараа*




*Зураг 29. 2024 оны эм, тарианы орлого зарлага, зарцуулалтын бүртгэл хөтөлсөн байдал.*



*Зураг 30. Машины кабин, ажлын байранд байрлуулсан анхан тусламжын хайрцаг.*

**4.8. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө**

| Д/д | Төлөвлөсөн арга хэмжээ | Төлөвлөгөөний биелэлт |
|---|---|---|
| 1. | Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны ажлыг хийлгэх /5 жил тутамд/ | 2024 онд хийгдсэн |
| 2. | Байгаль орчны аудитыг мэргэжлийн байгууллагаар хийлгэх; Гарсан дүгнэлт зөвлөмжийг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах /2 жил тутамд/ | Манай компани нь 2024 онд “Цэхи-консалтинг” ХХК-тай гэрээ байгуулан Дундговь аймгийн Баянжаргалан суманд хэрэгжүүлж буй “Хөөтийн хонхор”-2 нүүрсний ордыг ил аргаар ашиглах төслийн үйл ажиллагаандаа Байгаль орчны аудитын тайлан хийлгэсэн. Батлагдсан нүүрийг хавсралт материалд хавсаргав. |
| 3. | Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ Байгаль орчны асуудлыг удирдлагын түвшний ажилтанд хариуцуулж, хяналт тавин ажиллах; Ажилтнуудад байгаль | Уурхайн ажилчдад байгаль хамгаалах тухай болон ахуйн хэрэглээнээс үүсэх хог хаягдлын менежментийн тухай сургалт орсон. |

| | | |
|---|---|---|
| | орчны сургалтуудыг ажлын байранд нь зохион байгуулах | |
| 4. | Жил бүрийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө ба тайлан боловсруулах | Жил бүрийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулж БОУАӨЯ-аар батлуулан төлөвлөгөөний биелэлтийн тайланг боловсруулан мэргэжлийн комиссоор дүгнүүлэн ажиллаж байна. |




*Зураг 31. Хог хаягдлын тухай сургалт орсон.*

## 4.9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, орчны төлөв байдалд үзүүлж буй өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөг багасгах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянахад Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр ач холбогдолтой байна.

“Хөөтийн хонхор”-2 нүүрсний ордыг ашиглах төслийн 2024 оны орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд нийт 2 удаа хөрс, ус, агаарын чанарын шинжилгээг мэргэжлийн байгууллагуудтай хамтран хийсэн.

2024 оны 4 болон 10 сард Дундговь аймгийн УЦУОШГазартай гэрээ байгуулан хөрс, ус, агаарын шинжилгээ хийлгэж, 10-р сард авсан хөрс, усны дээжийг “Инженер геодези” ХХК-ийн итгэмжлэгдсэн “Хөрс судлалын лаборатори”-д өгч шинжлүүлсэн.

### 4.9.1. Агаарын чанар

Дундговь аймгийн УЦУОХШ-ний төвийн мэргэжилтэнтэй гэрээ байгуулан 4 болон 10-р сард дараах цэгүүдэд шинжилгээ хийсэн.

| Д/д | Шинжилгээ хийсэн цэгүүд | Агаарын нарийн ширхэгт тоосжилтын шинжилгээ /PM2.5, PM10/ | Агаар бохирдуулагч бодисын шинжилгээ |
|---|---|---|---|
| **1.** | Уурхайн карьерийн гадна | ✓ | ✓ |
| **2.** | Карьерийн дотор | ✓ | ✓ |
| **3.** | ШТС | ✓ | |
| **4.** | Засварын талбай | ✓ | ✓ |
| **5.** | Дотоод тээврийн зам | ✓ | ✓ |
| **6.** | Кемпийн гадна хэсэг | ✓ | |
| **7.** | Оффис | ✓ | |
| **8.** | Зааварчилгааны өрөө | ✓ | |

Уурхайн үйл ажиллагаанаас үүсэх агаарын тоосжилт болон агаар бохирдуулагч хийн агууламж стандартад заасан зөвшөөрөгдөх хэмжээнээс давсан үзүүлэлт байгаагүй.


0.45
0.4
0.35
0.3
0.25
0.2
0.15
0.1
0.05
0
0.007
0.45
0.017
0.45
0.032
0.45
0.005
0.45
0.088
0.011
0.45
карьер
Ажилчдын хотхон
Нүүрсний агуулах
тээврийн зам
уурхай дотор
SO2, мкг/м3 4-р сар
SO2, мкг/м3 10-р сар
Стандарт 20мин/мкг/м3


0.2
0.15
0.1
0.05
0
0.034
0.2
0.049
0.2
0.02
0.2
0.039
0.2
0.052
0.057
0.2
карьер
Ажилчдын…
Нүүрсний…
тээврийн зам
уурхай дотор
4-р сар NO2, мкг/м3
10-р сар NO2, мкг/м3
10-р сар Стандарт, 20мин/мкг/м3

MNAS Accreditation system TL 08-09 MNS ISO/IEC 17025

УС ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИ

Дундговь аймаг Сайнцагаан сум 7-р баг бага тойруу 2-200
Утас/Факс: 70592350, 88819335
E-mail хаяг tsaguur@dundgovi.gov.mn

Сорьцын дугаар: А/09, А/10, А/11
Сорьц авсан газрын нэр, хаяг, утас: Биг Могул Коул Энд Энерэжи ХХК
Сорьц авсан хүний нэр, албан тушаал: БОШЛ-ийн техникч М.Баярмаа
Сорьцын тоо, хэмжээ: 3
Сорьцын төрөл: Агаарын шинжилгээ
Сорьц авсан огноо: 2024.04.29
Лабораторид хүлээж авсан : 2024.04.29
Шинжилгээ эхэлсэн огноо: 2024.04.29
Хэвлэсэн огноо: 2024.05.13
Хуудасны тоо: 1/1

**ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ДҮН**

| № | Сорьц авсан цэг | $SO_2$ мг/м$^3$ | $NO_2$ мг/м$^3$ |
|---|---|---|---|
| А/09 | Ажилчдын хотхон 45⁰43'07.3'' 107⁰42'05.3'' | 0.017 | 0.049 |
| А/10 | Уурхай дотор 45⁰42'43.5'' 107⁰42'02.0'' | 0.088 | 0.052 |
| А/11 | Нүүрсний агуулах 45⁰43'14.1'' 107⁰42'10.6'' | 0.032 | 0.020 |
| ***Агаарын чанарын стандарт MNS 4585:2016*** | | ***0.450мг/м$^3$*** | ***0.20 мг/м$^3$*** |

ХЯНАЖ БАТАЛГААЖУУЛСАН:
БОШ ЛАБОРАТОРИЙН ЭРХЛЭГЧ /Б.ЯНЖМАА /

ШИНЖИЛГЭЭ ГҮЙЦЭТГЭСЭН:
БОШЛАБОРАТОРИЙН ИНЖЕНЕР /Э.БУЯНДЭЛГЭР/

MNAS Accreditation system TL 08-09 MNS ISO/IEC 17025

УС ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИ

Дундговь аймаг Сайнцагаан сум 7-р баг бага тойруу 2-200
Утас/Факс: 70592350, 88819335
E-mail хаяг tsaguur@dundgovi.gov.mn

Сорьцын дугаар: Т/09, Т/10, Т/11
Сорьц авсан газрын нэр, хаяг, утас: Биг Могул Коул Энд Энерэжи ХХК
Сорьц авсан хүний нэр, албан тушаал: БОШЛ-ийн техникч М.Баярмаа
Сорьцын тоо, хэмжээ: 3
Сорьцын төрөл: Нийт тоос /20 минут/
Сорьц авсан огноо: 2024.04.29
Лабораторид хүлээж авсан : 2024.04.29
Шинжилгээ эхэлсэн огноо: 2024.04.29
Хэвлэсэн огноо: 2024.05.13
Хуудасны тоо: 1/1

**ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ДҮН**

| № | Сорьц авсан цэг | Нийт тоос /20 минут/ мг/м$^3$ |
|---|---|---|
| Т/09 | Ажилчдын хотхон 45⁰43'07.3'' 107⁰42'05.3'' | 0.016 |
| Т/10 | Уурхай дотор 45⁰42'43.5'' 107⁰42'02.0'' | 0.103 |
| Т/11 | Нүүрсний агуулах 45⁰43'14.1'' 107⁰42'10.6'' | 0.015 |

ХЯНАЖ БАТАЛГААЖУУЛСАН:
БОШ ЛАБОРАТОРИЙН ЭРХЛЭГЧ /Б.ЯНЖМАА /

ШИНЖИЛГЭЭ ГҮЙЦЭТГЭСЭН:
БОШЛАБОРАТОРИЙН ИНЖЕНЕР /Э.БУЯНДЭЛГЭР/

### 4.9.2. Хөрсний агрохимийн шинжилгээ

Хөрсний агрохимийн шинжилгээний дээж авсан цэгүүд:

1. Кемп, ⎫ 2. Засварын цэг, ⎫ 3. ШТМ-ын агуулах, ⎫ 4. Хогийн цэг ⎫ 5. ОО-ийн ойр орчмоос ⎫ 6. Хүнд машин механизмын зогсоол

Уурхайн хөрсний бохирдол үүсэх магадлалтай цэгүүдээс хөрсний дээж авч хөрсний химийн шинжилгээ болон хүнд металлын шинжилгээг хийлгэсэн.

*Хүснэгт 4. Хөрсний химийн задлан шинжилгээний үр дүн*

| № | Дээжний нэр | pH | Давс, % | ЦДЧ | Ялзмаг, % | NO3 мг/г | $CaCO_2$, % | Шингээгдсэн сууриуд, мг/экв/100гр | | Шим тэжээлийн элементүүд | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Ca | Mg | $P_2O_5$ | $K_2O$ |
| 1. | Машин зогсоол | 8.63 | 0.41 | 0.826 | 0.36 | 0.11 | 0.32 | 9.9 | 6.7 | 1.3 | 16 |
| 2. | 00-ын хажуу | 8.81 | 0.07 | 0.157 | 1.96 | 0.22 | 0.16 | 5.0 | 3.3 | 1.4 | 30 |
| 3. | Хогийн цэг | 8.49 | 0.60 | 1.205 | 0.44 | 0.16 | 0.49 | 16.0 | 12.4 | 2.4 | 11 |
| 4. | Кемп | 8.84 | 0.13 | 0.262 | 0.62 | 0.13 | 0.16 | 5.8 | 4.8 | 1.1 | 14 |
| 5. | Засварийн талбай | 8.79 | 0.53 | 1.169 | 1.83 | 0.28 | 0.66 | 10.6 | 6.7 | 2.2 | 12 |
| 6. | ШТМ хадгалах агуулах | 8.97 | 0.14 | 0.292 | 0.19 | 0.05 | 0.32 | 5.7 | 4.4 | 0.4 | 12 |

*Хүснэгт 5. Хөрсний хүнд металлын шинжилгээний үр дүн*

| № | Сорьц авсан цэг | Хүнд металл мг/кг<br>Харьцуулсан стандарт MNS 5850:2019 | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Ni<br>/Никель/ | Cd<br>/Кадми/ | Pb<br>/тугалга/ | Cu<br>/зэс/ | Zn<br>/Цайр/ | Cr<br>/Хром/ |
| 1) | ШТС | 34.18 | - | 16.55 | 5.38 | 51.36 | 47.15 |
| 2) | Хүлцэх агууламж | 150.0 | 3.0 | 100.0 | 100.0 | 300.0 | 150.0 |
| 3) | Хортой агууламж | 1000.0 | 10.0 | 500.0 | 500.0 | 600.0 | 400.0 |
| 4) | Аюултай агууламж | 1800.0 | 20.0 | 1200.0 | 1000.0 | 1000.0 | 1500.0 |

**“Хөөтийн хонхор-2 нэртэй нүүрсний ордыг ашиглах” төслийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан**




Үр дүн:

Шинжилгээний хариуг Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850:2019 стандарттай харьцуулж үзэхэд хөрсөнд агуулагдах хүнд металлын элементүүдийн хүлцэх агууламжаас давсан үзүүлэлт байхгүй байна.

Засварын талбайд хийсэн хүнд металлын шинжилгээнээс үзэхэд хөрсөнд агуулагдах хортой элементүүдийн агууламж Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ. Хамрах хүрээ. MNS 5850:2019 стандартын заасан хүнд металлын хүлцэх агууламжаас хэтрээгүй байна.

MNAS Accreditation system
TL 08-09
MNS ISO/IEC 17025

УС ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ
БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИ

Дундговь аймаг Сайнцагаан сум 7-р баг бага тойруу 2-200
Утас/Факс: 70592350, 88819335
E-mail хаяг tsaguur@dundgovi.gov.mn

Сорьцын дугаар: S/07, S/10, S/13, S/14
Сорьц авсан газрын нэр, хаяг, утас: Баянжаргалан сум БИГ МОГУЛ ХХК
Сорьц авсан хүний нэр, албан тушаал: БОШЛ-ийн техникч М.Баярмаа
Сорьцын тоо, хэмжээ: 4, 0.5 кг
Сорьцын төрөл: Хөрсний агрохимийн шинжилгээ
Сорьц авсан огноо: 2024.04.28
Лабораторид хүлээж авсан: 2024.04.29
Шинжилгээ эхэлсэн огноо: 2024.05.20
Хэвлэсэн огноо: 2024.05.31
Хуудасны тоо: 1/1

**ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ДҮН**

| Сорьцын дугаар | Сорьц авсан цэг | | | |
|---|---|---|---|---|
| | S/07 | S/10 | S/13 | S/14 |
| Хөрсний чанарын үзүүлэлтүүд | Ажилчдын байр | Технологийн зам | Засварын завод | ШТС |
| pH | 7.874 | 7.505 | 7.831 | 7.321 |
| Ялзмаг % | 1.79 | 1.83 | 1.70 | 1.94 |
| $NO_3$ мг/кг | 16.72 | 27.17 | 50.54 | 16.53 |
| $NH_4$мг/кг | 45.44 | 117.83 | 98.57 | 100.88 |
| $SO_4$ мг/кг | 1768.0 | 2650.0 | 2267.0 | 26.7 |
| $P_2O_5$ мг/кг | 9.680 | 51.304 | 46.024 | 50.248 |

ХЯНАЖ БАТАЛГААЖУУЛСАН:
БОШ ЛАБОРАТОРИЙН ЭРХЛЭГЧ /Б.ЯНЖМАА /

ШИНЖИЛГЭЭ ГҮЙЦЭТГЭСЭН:
БОШЛАБОРАТОРИЙН ИНЖЕНЕР /Э.БУЯНДЭЛГЭР/

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хамаарна.

**ХӨРС СУДЛАЛЫН ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ**

**ИНЖЕНЕР ГЕОДЕЗИ ХХК**
Утас/Факс 77278899, 77288899
E-mail: soil_lab@geo-mongol.mn mn

**Дугаар: 24/1994**

**Дээж авсан огноо:** 2024 он 11 сарын 04
**Шинжилгээ хийсэн огноо:** 2024 он 11 сарын 05-06
**Дээж авсан газрын нэр:** Дундговь аймаг, Баянжаргалан сум, 2-р баг, "Хөөтийн хонхор-2" уурхай
**Координат**: $45^{0}43^{1}5^{II}$ $107^{0}41^{1}59^{II}$
**Дээж шинжлүүлсэн байгууллага, хувь хүн:** "Биг могул коул энд энержи" ХХК
**Харилцах утас:** 80821128

***Хөрсний химийн задлан шинжилгээний дүн***

| № | Лаб № | Дээжний нэр | Гүн, см | pH | Давс, % | ЦДЧ, dsm | Ялзмаг,% | $NO_3$ мг/100г | $CaCO_3$,% | Шингээгдсэн суурууд мг-экв/100 гр | | Шим тэжээлийн элементүүд мг/ 100 гр | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | Ca | Mg | $P_2O_5$ | $K_2O$ |
| 0 | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 10 | 11 | 12 | 13 | 14 |
| 1 | 24/5888 | Машин зогсоол | - | 8.63 | 0.41 | 0.826 | 0.36 | 0.11 | 0.32 | 9.9 | 6.7 | 1.3 | 16 |

***Хөрсний механик бүрэлдэхүүн***

| № | Лаб № | Дээжний нэр | Гүн, см | Механик ширхэгүүд %, ширхэгийн хэмжээ, мм | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 1-0.25 | 0.25-0.05 | 0.05-0.01 | 0.01-0.005 | 0.005-0.001 | <0.001 | <0.01 |
| 1 | 24/5856 | Хөрс-1 | - | 17.2 | 52.3 | 5.9 | 3.4 | 12.5 | 8.7 | 24.6 |

*Жич: Энэхүү шинжилгээний хариу нь тухайн цэгийн дээжинд хамаарах ба хуулбарлан хэрэглэхийг хориглоно.*
Шинжилгээ хийсэн арга стандарт:
(MNS 3310:1991, MNS ISO 10390:2001, MNS 6824:2020)

Лабораторийн эрхлэгч: Я.Болдбаатар /MS.c/
Задлан шинжээч: С.Ганцэцэг

**ХӨРС СУДЛАЛЫН ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ**

**ИНЖЕНЕР ГЕОДЕЗИ ХХК**
Утас/Факс 77278899, 77288899
E-mail: soil_lab@geo-mongol.mn mn

**Дугаар: 24/1999**

**Дээж авсан огноо:** 2024 он 11 сарын 04
**Шинжилгээ хийсэн огноо:** 2024 он 11 сарын 05-06
**Дээж авсан газрын нэр:** Дундговь аймаг, Баянжаргалан сум, 2-р баг, “Хөөтийн хонхор-2” уурхай
**Координат:** $45^{0}43^{I}14^{II}$ $107^{0}42^{I}0^{II}$
**Дээж шинжлүүлсэн байгууллага, хувь хүн: “**Биг могул коул энд энержи” ХХК
**Харилцах утас:** 80821128

***Хөрсний химийн задлан шинжилгээний дүн***

| № | Лаб № | Дээжний нэр | Гүн, см | pH | Давс, % | ЦДЧ, dsm | Ялзмаг,% | $NO_3$ мг/100г | $CaCO_3$,% | Шингээгдсэн суурьнуд мг-экв/100 гр | | Шим тэжээлийн элементүүд мг/ 100 гр | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | Ca | Mg | $P_2O_5$ | $K_2O$ |
| 0 | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 10 | 11 | 12 | 13 | 14 |
| 1 | 24/5893 | ОО-хажуу | - | 8.81 | 0.07 | 0.157 | 1.96 | 0.22 | 0.16 | 5.0 | 3.3 | 1.4 | 30 |

***Хөрсний механик бүрэлдэхүүн***

| № | Лаб № | Дээжний нэр | Гүн, см | Механик ширхэгүүд %, ширхэгийн хэмжээ, мм | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 1-0.25 | 0.25-0.05 | 0.05-0.01 | 0.01-0.005 | 0.005-0.001 | <0.001 | <0.01 |
| 1 | 24/5893 | ОО-хажуу | - | 24.2 | 53.8 | 6.7 | 3.2 | 9.3 | 2.8 | 15.3 |

*Жич: Энэхүү шинжилгээний хариу нь тухайн цэгийн дээжинд хамаарах ба хуулбарлан хэрэглэхийг хориглоно.*
Шинжилгээ хийсэн арга стандарт:
(MNS 3310:1991, MNS ISO 10390:2001, MNS 6824:2020)

Лабораторийн эрхлэгч: Я.Болдбаатар /MS.c/
Задлан шинжээч: С.Ганцэцэг

**ХӨРС СУДЛАЛЫН ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ**

**ИНЖЕНЕР ГЕОДЕЗИ ХХК**
Утас/Факс 77278899, 77288899
E-mail: soil_lab@geo-mongol.mn mn

**Дугаар: 24/1998**

**Дээж авсан огноо:** 2024 он 11 сарын 04
**Шинжилгээ хийсэн огноо:** 2024 он 11 сарын 05-06
**Дээж авсан газрын нэр:** Дундговь аймаг, Баянжаргалан сум, 2-р баг, “Хөөтийн хонхор-2” уурхай
**Координат:** $45^{0}43^{I}13^{II}$ $107^{0}41^{I}58^{II}$
**Дээж шинжлүүлсэн байгууллага, хувь хүн: “**Биг могул коул энд энержи” ХХК
**Харилцах утас:** 80821128

***Хөрсний химийн задлан шинжилгээний дүн***

| № | Лаб № | Дээжний нэр | Гүн, см | pH | Давс, % | ЦДЧ, dsm | Ялзмаг,% | $NO_3$ мг/100г | $CaCO_3$,% | Шингээгдсэн суурьнуд мг-экв/100 гр | | Шим тэжээлийн элементүүд мг/ 100 гр | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | Ca | Mg | $P_2O_5$ | $K_2O$ |
| 0 | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 10 | 11 | 12 | 13 | 14 |
| 1 | 24/5892 | Хогийн цэг | - | 8.49 | 0.60 | 1.205 | 0.44 | 0.16 | 0.49 | 16.0 | 12.4 | 2.4 | 11 |

***Хөрсний механик бүрэлдэхүүн***

| № | Лаб № | Дээжний нэр | Гүн, см | Механик ширхэгүүд %, ширхэгийн хэмжээ, мм | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 1-0.25 | 0.25-0.05 | 0.05-0.01 | 0.01-0.005 | 0.005-0.001 | <0.001 | <0.01 |
| 1 | 24/5892 | Хогийн цэг | - | 14.0 | 52.3 | 10.6 | 1.5 | 15.8 | 5.8 | 23.1 |

*Жич: Энэхүү шинжилгээний хариу нь тухайн цэгийн дээжинд хамаарах ба хуулбарлан хэрэглэхийг хориглоно.*
Шинжилгээ хийсэн арга стандарт:
(MNS 3310:1991, MNS ISO 10390:2001, MNS 6824:2020)

Лабораторийн эрхлэгч: Я.Болдбаатар /MS.c/
Задлан шинжээч: С.Ганцэцэг

**ХӨРС СУДЛАЛЫН ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ**

MNAS

**ИНЖЕНЕР ГЕОДЕЗИ ХХК**
Утас/Факс 77278899, 77288899
E-mail: soil_lab@geo-mongol.mn mn

**Дугаар: 24/1997**

**Дээж авсан огноо:** 2024 он 11 сарын 04
**Шинжилгээ хийсэн огноо:** 2024 он 11 сарын 05-06
**Дээж авсан газрын нэр:** Дундговь аймаг, Баянжаргалан сум, 2-р баг, “Хөөтийн хонхор-2" уурхай
**Координат**: $45^{0}43^{I}16^{II}$ $107^{0}42^{I}1^{II}$
**Дээж шинжлүүлсэн байгууллага, хувь хүн: “**Биг могул коул энд энержи” ХХК
**Харилцах утас:** 80821128

***Хөрсний химийн задлан шинжилгээний дүн***

| № | Лаб № | Дээжний нэр | Гүн, см | pH | Давс, % | ЦДЧ, dsm | Ялзмаг,% | $NO_3$ мг/100г | $CaCO_2$,% | Шингээгдсэн суурнууд мг-экв/100 гр | | Шим тэжээлийн элемэнтүүд мг/ 100 гр | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | Ca | Mg | $P_2O_5$ | $K_2O$ |
| 0 | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 10 | 11 | 12 | 13 | 14 |
| 1 | 24/5891 | Кемп | - | 8.84 | 0.13 | 0.262 | 0.62 | 0.13 | 0.16 | 5.8 | 4.8 | 1.1 | 14 |

***Хөрсний механик бүрэлдэхүүн***

| № | Лаб № | Дээжний нэр | Гүн, см | Механик ширхэгүүд %, ширхэгийн хэмжээ, мм | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 1-0.25 | 0.25-0.05 | 0.05-0.01 | 0.01-0.005 | 0.005-0.001 | <0.001 | <0.01 |
| 1 | 24/5891 | Кемп | - | 38.4 | 45.0 | 5.0 | 3.9 | 6.7 | 1.0 | 11.6 |

***Жич: Энэхүү шинжилгээний хариу нь тухайн цэгийн дээжинд хамаарах ба хуулбарлан хэрэглэхийг хориглоно.***
Шинжилгээ хийсэн арга стандарт:
(MNS 3310:1991, MNS ISO 10390:2001, MNS 6824:2020)

Лабораторийн эрхлэгч: Я.Болдбаатар /MS.c/
Задлан шинжээч: С.Ганцэцэг

**ХӨРС СУДЛАЛЫН ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ**

MNAS

**ИНЖЕНЕР ГЕОДЕЗИ ХХК**
Утас/Факс 77278899, 77288899
E-mail: soil_lab@geo-mongol.mn mn

**Дугаар: 24/1995**

**Дээж авсан огноо:** 2024 он 11 сарын 04
**Шинжилгээ хийсэн огноо:** 2024 он 11 сарын 05-06
**Дээж авсан газрын нэр:** Дундговь аймаг, Баянжаргалан сум, 2-р баг, “Хөөтийн хонхор-2" уурхай
**Координат**: $45^{0}43^{I}6^{II}$ $107^{0}41^{I}60^{II}$
**Дээж шинжлүүлсэн байгууллага, хувь хүн: “**Биг могул коул энд энержи” ХХК
**Харилцах утас:** 80821128

***Хөрсний химийн задлан шинжилгээний дүн***

| № | Лаб № | Дээжний нэр | Гүн, см | pH | Давс, % | ЦДЧ, dsm | Ялзмаг,% | $NO_3$ мг/100г | $CaCO_2$,% | Шингээгдсэн суурнууд мг-экв/100 гр | | Шим тэжээлийн элемэнтүүд мг/ 100 гр | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | Ca | Mg | $P_2O_5$ | $K_2O$ |
| 0 | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 10 | 11 | 12 | 13 | 14 |
| 1 | 24/5889 | ШТМ хадгалах агуулах | - | 8.97 | 0.14 | 0.292 | 0.19 | 0.05 | 0.32 | 5.7 | 4.4 | 0.4 | 12 |

***Хөрсний механик бүрэлдэхүүн***

| № | Лаб № | Дээжний нэр | Гүн, см | Механик ширхэгүүд %, ширхэгийн хэмжээ, мм | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 1-0.25 | 0.25-0.05 | 0.05-0.01 | 0.01-0.005 | 0.005-0.001 | <0.001 | <0.01 |
| 1 | 24/5889 | ШТМ хадгалах агуулах | - | 28.8 | 41.8 | 10.4 | 3.5 | 6.7 | 8.7 | 18.9 |

***Жич: Энэхүү шинжилгээний хариу нь тухайн цэгийн дээжинд хамаарах ба хуулбарлан хэрэглэхийг хориглоно.***
Шинжилгээ хийсэн арга стандарт:
(MNS 3310:1991, MNS ISO 10390:2001, MNS 6824:2020)

Лабораторийн эрхлэгч: Я.Болдбаатар /MS.c/
Задлан шинжээч: С.Ганцэцэг

### 4.9.3. Усны химийн задлан шинжилгээний хариу

Усны дээж авсан цэгүүд:

1. Хөөтийн булгийн ус,
2. Унд ахуйн хэрэглээний гүний худгын цэвэршүүлсэн ус,
3. Ажилчдын ундны ус

*Унд ахуйн хэрэглээний ус.*

Унд ахуйн хэрэглээний усны дээжийг ажилчдын хоол хүнсэнд хэрэглэж байгаа крантны уснаас авсан.

Усны химийн задлан шинжилгээний үр дүнг Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900:2018 стандарттай харьцуулан үзэхэд /$Ca^{2+}$/ агууламж стандарт хэмжээнээс 4.21-ээр давсан, магнийн агууламж /$Mg^{2+}$/ стандартад заасан хэмжээнээс хайрцангүй өндөр агууламжтай байна.

Усны ерөнхий хатуулаг 5.90 мг-экв/л буюу хатуувтар, pH 7.91 сул шүлтлэг ус байгаа нь унд ахуйн хэрэглээнд зөөлрүүлэн ашиглахад тохиромжтой байна гэж үзлээ.

*Хүснэгт 6. Ундны усны химийн задлан шмнжилгээний дүнг MNS0900:2018 стандартад зөвшөөрөгдсөн хэмжээтэй харьцуулсан харьцуулалт,*

| Анион | 10-р сар, мг/л | **MNS 0900:2018** | Катион | 10-р сар, мг/л | **MNS 0900:2018** |
|---|---|---|---|---|---|
| $Cl^-$ | 109.90 | **350.0** | Na+K | 218.69 | **-** |
| $SO_4^{2-}$ | 183.86 | **-** | $NH_4^+$ | 0.00 | **1.5** |
| $NO_3^-$ | 0.69 | **50.0** | $Ca^{2+}$ | 104.21 | **100.0** |
| $NO_2^-$ | 0.01 | **1.0** | $Mg^{2+}$ | 160.51 | **30.0** |
| $CO_3^{2-}$ | 0.00 | **-** | $Fe^{2+}$ | 0.20 | **-** |
| $HCO_3^-$ | 1281.42 | **-** | $Fe^{3+}$ | 0.30 | **-** |
| Дүн | 1575.87 | | Дүн | 483.91 | |




*График 1. Хиймийн элементүүдийг агууламжыг стандартын зөвшөөрөгдсөн хэмжээтэй харьцуулсан үзүүлэлт*

<u>*Уурхайн шүүрлийн ус.*</u>

Усны ерөнхий хатуулаг 20.70 мг-экв/л буюу маш хатуу, pH 8.56 байгаа нь Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага MNS 4943:2015 стандартад заасан зөвшөөрөгдөх хэмжээнээс даваагүй байна.

| Анион | мг/л | Хүлцэх агууламж MNS 0900:2018 | Катион | мг/л | Хүлцэх агууламж MNS 0900:2018 |
|---|---|---|---|---|---|
| $Cl^-$ | 248.15 | 350.0 | Na+K | 237.05 | - |
| $SO_4^{2-}$ | 184.03 | - | $NH_4^+$ | 0.10 | 1.5 |
| $NO_3^-$ | 0.34 | 50.0 | $Ca_2^+$ | 112.22 | 100.0 |
| $NO_2^-$ | 0.03 | 1.0 | $Mg_2^+$ | 183.62 | 30.0 |
| $CO_3^{2-}$ | 36.00 | - | $Fe_2^+$ | 0.30 | - |
| $HCO_3^-$ | 1195.99 | - | $Fe_3^+$ | 0.00 | - |
| Нийт дүн | 1664.55 | | Нийт дүн | 533.29 | |

MNAS Accreditation system
TL 08-09
MNS ISO/IEC 17025

УС ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ
БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИ

Дундговь аймаг Сайнцагаан сум 7-р баг бага тойруу 2-200
Утас/Факс: 70592350, 88819335
E-mail хаяг tsaguur@dundgovi.gov.mn

ДУНДГОВЬ УЦУОШТ

Сорьцын дугаар: w/07
Сорьц авсан газрын нэр, хаяг, утас: Биг Могул Коул Энд Энержи ХХК
Сорьц авсан хүний нэр, албан тушаал: БОШЛ-ийн техникч М.Баярмаа
Сорьцын тоо, хэмжээ: 2 литр
Сорьцын төрөл: Булгийн ус
Сорьц авсан огноо: 2024.04.29
Лабораторид хүлээж авсан : 2024.04.29
Шинжилгээ эхэлсэн огноо: 2024.04.29
Хэвлэсэн огноо: 2024.05.13
Хуудасны тоо: 1/1

**ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ДҮН**

| **Тодорхойлсон үзүүлэлт** Шинжилгээний арга стандарт | | **Сорьц авсан цэг** Биг Могул Коул Энд Энержи /Булгийн ус/ | **MNS 4586:1998 Хүлцэх агууламж мг/л** |
|---|---|---|---|
| Жинлэгдэх бодис /MNS 6836:2020/ | Ж/Б мг/л | 2.8 | |
| Перманганатын исэлдэх чанар /MNS 6833:2020/ | Пич мг/л | 2.6 | 10 |
| Кальцийн ион /MNS ISO 1097:1970/ | $Ca^{2+}$ мг/л | 123.2 | |
| Магний ион /MNS ISO 1097:1970/ | $Mg^{2+}$ мг/л | 149.6 | |
| Аммоний ион /САЗ 1:2020/ | $NH_4^+$ мг/л | 0.19 | |
| Нийт төмөр /MNS 4430:2005/ | Fe мг/л | 0.31 | **300** |
| Хлорийн ион /MNS 4424:2005/ | $Cl^-$ мг/л | 163.1 | **100** |
| Сульфатын ион /MNS 6271:2011/ | $SO_4^{2-}$ мг/л | 321.1 | **0.5** |
| Нитритийн ион /MNS 6779:2019/ | $NO_2$ мг/л | 0.002 | **0.020** |
| Нитратын ион /MNS 6834:2020/ | $NO_3$ мг/л | 0.59 | **9** |
| Фосфатын ион /MNS ISO 6878:2001/ | $PO_4^{3-}$ мг/л | 0.019 | |
| Фтор /MNS 6272:2011/ | $F^-$ мг/л | 1.35 | **0.1** |
| Хатуулаг / MNS ISO 1097:1970/ | Хатуулаг мг-экв/л | 18.45 | **1.5** |
| Натри Кали | Na+K мг/л | 351.0 | |
| Цахилгаан дамжуулах чанар /MNS ISO 7888:1999/ | EC µS/cm³ | 2860 | |
| Гидрокарбонат MNS 6832:2020 | $HCO_3^-$ мг/л | 1293.6 | |
| Эрдэсжилт MNS ISO 1097:1970 | мг/л | 2401.6 | |
| Орчин MNS ISO 10523:2001 | pH | 7.678 | |

ХЯНАЖ БАТАЛГААЖУУЛСАН:
БОШ ЛАБОРАТОРИЙН ЭРХЛЭГЧ /Б.ЯНЖМАА /
ШИНЖИЛГЭЭ ГҮЙЦЭТГЭСЭН:
БОШЛАБОРАТОРИЙН ИНЖЕНЕР /Э.БУЯНДЭЛГЭР/

MNAS Accreditation system
TL 08-09
MNS ISO/IEC 17025

УС ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ
БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИ

Дундговь аймаг Сайнцагаан сум 7-р баг бага тойруу 2-200
Утас/Факс: 70592350, 88819335
E-mail хаяг tsaguur@dundgovi.gov.mn

ДУНДГОВЬ УЦУОШТ

Сорьцын дугаар: w/06
Сорьц авсан газрын нэр, хаяг, утас: Биг Могул Коул Энд Энержи ХХК
Сорьц авсан хүний нэр, албан тушаал: БОШЛ-ийн техникч М.Баярмаа
Сорьцын тоо, хэмжээ: 2 литр
Сорьцын төрөл: Ундны ус
Сорьц авсан огноо: 2024.04.29
Лабораторид хүлээж авсан : 2024.04.29
Шинжилгээ эхэлсэн огноо: 2024.04.29
Хэвлэсэн огноо: 2024.05.13
Хуудасны тоо: 1/1

**ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ДҮН**

| **Тодорхойлсон үзүүлэлт** Шинжилгээний арга стандарт | | **Сорьц авсан цэг** Биг Могул Коул Энд Энержи ХХК /ундны ус/ | **MNS 900:2018 Хүлцэх агууламж мг/л** |
|---|---|---|---|
| Жинлэгдэх бодис /MNS 6836:2020/ | Ж/Б мг/л | илр | |
| Перманганатын исэлдэх чанар /MNS 6833:2020/ | Пич мг/л | илр | |
| Кальцийн ион /MNS ISO 1097:1970/ | $Ca^{2+}$ мг/л | 1.6 | **100** |
| Магний ион /MNS ISO 1097:1970/ | $Mg^{2+}$ мг/л | 1.6 | **30** |
| Аммоний ион /САЗ 1:2020/ | $NH_4^+$ мг/л | 0.07 | **1.5** |
| Нийт төмөр /MNS 4430:2005/ | Fe мг/л | 0.02 | **0.3** |
| Хлорийн ион /MNS 4424:2005/ | $Cl^-$ мг/л | 0.7 | **350** |
| Сульфатын ион /MNS 6271:2011/ | $SO_4^{2-}$ мг/л | 6.5 | **500** |
| Нитритийн ион /MNS 6779:2019/ | $NO_2$ мг/л | 0.001 | **1.0** |
| Нитратын ион /MNS 6834:2020/ | $NO_3$ мг/л | 0.16 | **50** |
| Фосфатын ион /MNS ISO 6878:2001/ | $PO_4^{3-}$ мг/л | илр | **3.5** |
| Фтор /MNS 6272:2011/ | $F^-$ мг/л | илр | |
| Хатуулаг / MNS ISO 1097:1970/ | Хатуулаг мг-экв/л | 0.25 | **7** |
| Натри Кали | Na+K мг/л | 7.2 | |
| Цахилгаан дамжуулах чанар /MNS ISO 7888:1999/ | EC µS/cm³ | 53 | |
| Гидрокарбонат MNS 6832:2020 | $HCO_3^-$ мг/л | 23.2 | |
| Эрдэсжилт MNS ISO 1097:1970 | мг/л | 41.6 | |
| Орчин MNS ISO 10523:2001 | pH | 6.507 | |

Тайлбар: илр-илрээгүй

ХЯНАЖ БАТАЛГААЖУУЛСАН:
БОШ ЛАБОРАТОРИЙН ЭРХЛЭГЧ /Б.ЯНЖМАА /
ШИНЖИЛГЭЭ ГҮЙЦЭТГЭСЭН:
БОШЛАБОРАТОРИЙН ИНЖЕНЕР /Э.БУЯНДЭЛГЭР/

**ХӨРС СУДЛАЛЫН ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ**

**ИНЖЕНЕР ГЕОДЕЗИ ХХК**
Утас/Факс 77278899, 77288899
E-mail: soil_lab@geo-mongol.mn

**Дугаар: 24/1991**

**Дээж авсан огноо:** 2024 он 11 сарын 04
**Шинжилгээ хийсэн огноо:** 2024 он 11 сарын 05-06
**Дээж авсан газрын нэр:** Дундговь аймаг, Баянжаргалан сум, 2-р баг, “Хөөтийн хонхор-2” уурхай
**Координат:** 45⁰43ˡ5ˡˡ 107⁰41ˡ59ˡˡ
**Дээж шинжлүүлсэн байгууллага, хувь хүн:** “Биг могул коул энд энержи” ХХК
**Харилцах утас:** 80821128
**Уст цэгийн төрөл ба дугаар:** Гүний худаг дээж-1
**Лаб № 24/5825**

Усны химийн задлан шинжилгээний дүн

| Анион | мг/л | мг/экв | %, мг-экв/л | Катион | мг/л | мг/экв | %, мг-экв/л |
|---|---|---|---|---|---|---|---|
| $Cl^-$ | 46.09 | 1.30 | 12.22 | $Na^++K^+$ | 108.21 | 4.70 | 44.30 |
| $SO_4^{2-}$ | 100.87 | 2.10 | 19.77 | $NH_4^+$ | 0.00 | 0.00 | 0.00 |
| $NO_3^-$ | 1.38 | 0.02 | 0.21 | $Ca^{2+}$ | 30.06 | 1.50 | 14.12 |
| $NO_2^-$ | 0.01 | 0.00 | 0.00 | $Mg^{2+}$ | 53.50 | 4.40 | 41.43 |
| $CO_3^{2-}$ | 0.00 | 0.00 | 0.00 | $Fe^{2+}$ | 0.30 | 0.02 | 0.15 |
| $HCO_3^-$ | 439.34 | 7.20 | 67.79 | $Fe^{3+}$ | 0.00 | 0.00 | 0.00 |
| Дүн | 587.69 | 10.62 | 100.00 | Дүн | 192.07 | 10.62 | 100.00 |

Анион катионуудын нийлбэр: 779.76 мг/л
$HCO_3^-$ ийн хагасыг хассан анион катионуудын нийлбэр: 560.0 мг/л
Хуурай үлдэгдэл: 566.0 мг/л
Ерөнхий хатуулаг: 5.90 мг-экв/л
pH: 7.91
Исэлдэх чанар: 0.80 мг/л

Усны физик шинж. чанар

Шүүгдэсний өнгө: Өнгөгүй
Үнэр: Үгүй
Амт: -
Булингар: Тунгалаг
Тунадас: Үгүй

**Усны давсны химийн найрлагын томьёо** М (594.03 мг/л) = $\frac{HCO-53.97\ SO-25.05}{Ca-51.32\ Na+K\ 29.28}$

Тайлбар

Химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, кальцийн бүлгийн, 2-р төрлийн , чанарын хувьд цэнгэгдүү буюу харьцангуй ихэвтэр эрдэсжилттэй, хатуу ус байна.

Шинжилгээ хийсэн арга стандарт:
(MNS 1097:1970, MNS 6271:2011, MNS ISO 10523:2001, MNS ISO 9297:2005, MNS ISO 6059:2005)

Лабораторийн эрхлэгч: Я.Болдбаатар /MS.c/
Задлан шинжээч: О.Алтанцэцэг /MS.c/

**ХӨРС СУДЛАЛЫН ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ**

**ИНЖЕНЕР ГЕОДЕЗИ ХХК**
Утас/Факс 77278899, 77288899
E-mail: soil_lab@geo-mongol.mn

**Дугаар: 24/1990**

**Дээж авсан огноо:** 2024 он 11 сарын 04
**Шинжилгээ хийсэн огноо:** 2024 он 11 сарын 05-06
**Дээж авсан газрын нэр:** Дундговь аймаг, Баянжаргалан сум, 2-р баг, “Хөөтийн хонхор-2” уурхай
**Координат:** 45⁰43ˡ13ˡˡ 107⁰41ˡ59ˡˡ
**Дээж шинжлүүлсэн байгууллага, хувь хүн:** “Биг могул коул энд энержи” ХХК
**Харилцах утас:** 80821128
**Уст цэгийн төрөл ба дугаар:** Ундны усны дээж
**Лаб № 24/5824**

Усны химийн задлан шинжилгээний дүн

| Анион | мг/л | мг/экв | %, мг-экв/л | Катион | мг/л | мг/экв | %, мг-экв/л |
|---|---|---|---|---|---|---|---|
| $Cl^-$ | 109.90 | 3.10 | 11.08 | $Na^++K^+$ | 218.69 | 9.51 | 34.04 |
| $SO_4^{2-}$ | 183.86 | 3.83 | 13.70 | $NH_4^+$ | 0.00 | 0.00 | 0.00 |
| $NO_3^-$ | 0.69 | 0.01 | 0.04 | $Ca^{2+}$ | 104.21 | 5.20 | 18.61 |
| $NO_2^-$ | 0.01 | 0.00 | 0.00 | $Mg^{2+}$ | 160.51 | 13.20 | 47.25 |
| $CO_3^{2-}$ | 0.00 | 0.00 | 0.00 | $Fe^{2+}$ | 0.20 | 0.01 | 0.04 |
| $HCO_3^-$ | 1281.42 | 21.00 | 75.17 | $Fe^{3+}$ | 0.30 | 0.02 | 0.06 |
| Дүн | 1575.87 | 27.93 | 100.00 | Дүн | 483.91 | 27.93 | 100.00 |

Анион катионуудын нийлбэр: 2059.78 мг/л
$HCO_3^-$ ийн хагасыг хассан анион катионуудын нийлбэр: 1419.0 мг/л
Хуурай үлдэгдэл: 1726.0 мг/л
Ерөнхий хатуулаг: 18.4 мг-экв/л
pH: 8.34
Исэлдэх чанар: 0.80 мг/л

Усны физик шинж. чанар

Шүүгдэсний өнгө: Өнгөгүй
Үнэр: Үгүй
Амт: -
Булингар: Тунгалаг
Тунадас: Үгүй

**Усны давсны химийн найрлагын томьёо** М (1726.0 мг/л) = $\frac{HCO-75.17}{Mg-47.25\ Na+K\ 34.04}$

Тайлбар

Химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, магнийн бүлгийн, 2-р төрлийн , чанарын хувьд их эрдэсжилттэй, маш хатуу ус байна.

Шинжилгээ хийсэн арга стандарт:
(MNS 1097:1970, MNS 6271:2011, MNS ISO 10523:2001, MNS ISO 9297:2005, MNS ISO 6059:2005)

Лабораторийн эрхлэгч: Я.Болдбаатар /MS.c/
Задлан шинжээч: О.Алтанцэцэг /MS.c/

ХОРС СУДЛАЛЫН
ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ

**ИНЖЕНЕР ГЕОДЕЗИ ХХК**
Утас/Факс 77278899, 77288899
E-mail: soil_lab@geo-mongol.mn

**Дугаар: 24/1992**

**Дээж авсан огноо:** 2024 он 11 сарын 04
**Шинжилгээ хийсэн огноо:** 2024 он 11 сарын 05-06
**Дээж авсан газрын нэр:** Дундговь аймаг, Баянжаргалан сум, 2-р баг, “Хөөтийн хонхор-2” уурхай
**Координат**: $45^{0}31^{I}13^{II}$ $107^{0}41^{I}59^{II}$
**Дээж шинжлүүлсэн байгууллага, хувь хүн:** “Биг могул коул энд энержи” ХХК
**Харилцах утас:** 80821128
**Уст цэгийн төрөл ба дугаар**: Шүүрлийн ус Д-1
**Лаб №** 24/5827

Усны химийн задлан шинжилгээний дүн

| Анион | мг/л | мг/экв | %, мг-экв/л | Катион | мг/л | мг/экв | %, мг-экв/л |
|---|---|---|---|---|---|---|---|
| $Cl^-$ | 248.15 | 6.99 | 22.53 | $Na^++K^+$ | 237.05 | 10.31 | 33.22 |
| $SO_4^{2-}$ | 184.03 | 3.83 | 12.35 | $NH_4^+$ | 0.10 | 0.01 | 0.02 |
| $NO_3^-$ | 0.34 | 0.01 | 0.02 | $Ca^{2+}$ | 112.22 | 5.60 | 18.05 |
| $NO_2^-$ | 0.03 | 0.00 | 0.00 | $Mg^{2+}$ | 183.62 | 15.10 | 48.67 |
| $CO_3^{2-}$ | 36.00 | 0.60 | 1.93 | $Fe^{2+}$ | 0.30 | 0.02 | 0.05 |
| $HCO_3^-$ | 1195.99 | 19.60 | 63.17 | $Fe^{3+}$ | 0.00 | 0.00 | 0.00 |
| Дүн | 1664.55 | 31.03 | 100.00 | Дүн | 533.29 | 31.03 | 100.00 |

| | |
|---|---|
| Анион катионуудын нийлбэр: | 2197.83 мг/л |
| $HCO_3^-$ ийн хагасыг хассан анион катионуудын нийлбэр: | 1600.0 мг/л |
| Хуурай үлдэгдэл: | 2638.0 мг/л |
| Ерөнхий хатуулаг: | 20.70 мг-экв/л |
| pH: | 8.56 |
| Исэлдэх чанар: | 0.64 мг/л |

Усны физик шинж. чанар

Шүүгдэсний өнгө: Өнгөгүй
Үнэр: Үгүй
Амт: -
Булингар: Тунгалаг
Тунадас: Үгүй

**Усны давсны химийн найрлагын томьёо** M (2638.0 мг/л) = $\frac{HCO-63.17\ Cl-22.53}{Mg-48.67\ Na+K\ 33.22}$

Тайлбар

Химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, магнийн бүлгийн, 3-р төрлийн , чанарын хувьд их эрдэсжилттэй, маш хатуу ус байна.

Шинжилгээ хийсэн арга стандарт:
(MNS 1097:1970, MNS 6271:2011, MNS ISO 10523:2001, MNS ISO 9297:2005, MNS ISO 6059:2005)

Лабораторийн эрхлэгч Я.Болдбаатар /MS.c/
Задлан шинжээч О.Алтанцэцэг /MS.c/

## 4.10. Бомт, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хуваарь

| № | БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд | Тайлагнах хэлбэр | Мэдээллийн агуулга | Зохион байгуулах хугацаатов | Тайлагнах зардал мян.төг |
|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Баянжаргалан сумын багийн иргэд | ИНХ-д танилцуулах | Тухайн жилд хийгдсэн ажил | Тухайн оны 4 -р улирал | 2024.12.02-нд Энгэр-ус багийн иргэдэд тухайн жилд хийгдсэн ажлыг Баянжаргал сумын Соёлын төвд зохион байгуулсан багийн хурлаар танилцуулсан. |
| 2 | Дундговь аймгийн Байгаль орчны газар | https://eic.mn/envmng/ буюу Байгаль орчны мэдээллийн санд оруулах | Тухайн жилд байгаль орчны талаар хийгдсэн ажил нөхөн сэргээсэн ажлын акт болон холбогдох материал | Тухайн оны 11 - р сарын 1 дотор | 2024 оны БОМТөлөвлөгөөний биелэлтийн тайланг мэдээллийн санд оруулсан |
| 3 | Төрийн захиргааны төв байгууллага | https://eic.mn/envmng/ буюу Байгаль орчны мэдээллийн санд оруулах, тамгалуулах | | Тухайн оны 12 - р сарын 1 дотор | - |

## ЗУРГАА.БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН НИЙТ ТӨСӨВ

| Д/д | Зардлын ангилал | Зардал, мян.төг |
|---|---|---|
| 1. | Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө | 800 000 |
| 2. | Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ | 27 650 000 |
| 3. | Нөхөн сэргээлт | 6 150 000 |
| 4. | Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ | 17 960 000 |
| 5. | Нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох арга хэмжээ | - |
| 6. | Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө | - |
| 7. | Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө | 3 000 000 |
| 8. | Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө | 1 250 000 |
| 9. | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр | 3 082 800 |
| | **Нийт** | **59,092,800** |

**Хавсралт материал**

1. Улсын бүртгэлийн гэрчилгээ
2. Ашигт малтмалын тусгай зөршөөрлийн гэрчилгээ
3. 2024 оны ус ашиглуулах дүгнэлт
4. 2024 оны Ус ашиглуулах гэрээ
5. 2024 оны Хаягдал усны дүгнэлт
6. Ундны худагт тоолуур суурилуулсан акт
7. 2024 оны Хог хаягдлын гэрээ
8. “Элемент” ХХК-тай байгуулсан гэрээ
9. Дүйцүүлэн хамгаалах талбайд нөхөн сэргээлт хийсэн ажлын акт
10. Ашиглалтын талбайд хийсэн нөхөн сэргээлтийн акт
11. Гамшигийн эрсдлийн үнэлгээ, төлөвлөгөөний батлагдсан нүүр
12. Хөрс, Ус, Агаарын лабораторийн бичиг
13. Хогны төлбөр төлсөн баримт
14. Хаягдал усны төлбөр төлсөн баримт
15. Шинжилгээ хийлгэсэн баримт

Хууль зүйн сайдын 2016 оны
А/204 дүгээр тушаалаар батлав.

# МОНГОЛ УЛС
# ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

000140891

2010.04.08
/ Бүртгэсэн он,сар,өдөр /

9011665117
/ Хувийн хэргийн дугаар /

5369223
/ Регистрийн дугаар /

Биг могул коул энд энержи Хязгаарлагдмал хариуцлагатай компани
/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Дүрэм
/ Үүсгэн байгуулах баримт бичиг /

| Тушаал | А-2390 | 2010.04.07 |
|---|---|---|
| / шийдвэрийн нэр / | / дугаар / | / он, сар, өдөр / |

| 4610 | Гадаад худалдаа |
|---|---|
| / код / | / Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл / |

| 7490 | Ашигт малтмалын хайгуул хийх |
|---|---|
| 0710 | Ашигт малтмалын ашиглалт |
| / код / | / Туслах эрхлэх үйл ажиллагааны чиглэл / |

| Хугацаагүй | 2 | 13,277,382.0 |
|---|---|---|
| / хугацаа / | / гишүүдийн тоо / | / өөрийн хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр / |

Улаанбаатар, Сүхбаатар, 1-р хороо, чингисийн өргөн чөлөө, Натур тур ХХК-ийн байр 4 давхар, Утас1: 311073, Утас2: , Факс:
/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг /

МОНГОЛ УЛС МОНГОЛ УЛС МОНГОЛ УЛС

Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар Хуулийн этгээдийн бүртгэлийн газар
/ бүртгэсэн байгууллагын нэр /

*Гэрчилгээ дахин олгосон 2017 он 5 сар 2 өдөр*

## Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

| Д/д | Нэмэлт өөрчлөлтийн агуулга | Бүртгэсэн | |
|---|---|---|---|
| | | Огноо | Ажилтан тэмдэг |
| 1 | Хайсандай овогтой Наранбаатар-г Гүйцэтгэх захирал -р томилсныг бүртгэв. | 2017.05.02 | Э.Эрдэнэбилэг |
| 2 | Дахин гэрчилгээ олгов. | 2017.05.02 | Э.Эрдэнэбилэг |
| 1 | Хувь нийлүүлэгчээс 1 нэмэгдэж, 1 хасагдаж үүсгэн байгуулагчийн тоо нийт 2 болж өөрчлөгдсөнийг бүртгэв. | 2017.05.19 | Э.Эрдэнэбилэг |
| 2 | Батхүү овогтой Отгонбаатар -г Гүйцэтгэх захирал-р томилсныг бүртгэв. | 2017.06.15 | Э.Эрдэнэбилэг |
| 4 | Эцсийн өмчлөгч 1 иргэн бүртгэв. | 2020-12-31 | Б.Алтансүх |
| 5 | Самбуу овогтой Болд-г Гүйцэтгэх захирал -р сонгосон(томилсон)-ыг бүртгэв. | 2024.02.01 | П.Оюунцэрэн |

Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.
Улсын бүртгэлийн гэрчилгээ засвартай бол хүчингүй.

*0001408 91*

Хувьцаа эзэмшигчдийн хурлын
2017 оны 5 дугаар сарын 8-ны өдрийн
05... тоот тогтоолын Хавсралт А

# БИГ МОГУЛ КОУЛ ЭНД ЭНЕРЖИ ХХК-ИЙН ДҮРЭМ

Монгол улсын Компанийн тухай хуулийн дагуу байгуулагдсан

Хязгаарлагдмал хариуцлагатай компани

**(2017 ОНЫ 5 ДУГААР САРЫН 8-НЫ ӨДӨР НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛЖ ШИНЭЧЛЭН НАЙРУУЛСАН)**

1. **Компанийн оноосон нэр:**
   Монгол хэлээр: БИГ МОГУЛ КОУЛ ЭНД ЭНЕРЖИ ХХК
   Англи хэлээр: BIG MOGUL COAL AND ENERGY LLC
2. **Компанийн хаяг:** Компанийн үндсэн ажлын байрны болон шуудангийн хаяг:
   Монгол Улс
   Улаанбаатар хот
   Сүхбаатар дүүрэг, 1-р хороо
   Чингисийн өргөн чөлөө – 13
   Натур тур ХХК-ийн байр, 4 давхар
3. **Компанийн бизнесийн үйл ажиллагаа:** Компанийн бизнесийн үйл ажиллагааны чиглэл болон түүний үүсгэн байгуулагдсан зорилго нь:
   3.1. Гадаад худалдааны үйл ажиллагаа
   3.2. Ашигт малтмалын хайгуул хийх, ашиглах
4. **Компанийн хувьцаа:** Компани нь нэг бүр нь 1.00 (Нэг) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 13,277,382,018 ширхэг энгийн хувьцаа гаргасан. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө 13,277,382,018 төгрөг байна.
5. **Компанийн үүсгэн байгуулагч (ид), Хувьцаа эзэмшигч (ид)-ийн нэр, хаяг:**
   5.1. Компанийн хувьцаа эзэмшигчдийн нэр хаяг нь дараах болно. Үүнд:

| | |
|---|---|
| Нэр | Батхүү овогтой Эрдэнэцэцэг |
| Хаяг | Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 1-р хороо, Алтай хотхон, Энгельс гудамж, 18-р байр, 68 тоот |
| Хот | Улаанбаатар хот |
| Улс | Монгол улс |

| | |
|---|---|
| Нэр | Батхүү овогтой Батмөнх |
| Хаяг | СБД, 2-р хороо, 5-р хороолол, 26-1-29 тоот |
| Хот | Улаанбаатар хот |
| Улс | Монгол улс |

   5.2. Эзэмшлийн хувь:

| № | Хувьцаа эзэмшигч | Хувьцааны тоо | Хувь хэмжээ |
|---|---|---|---|
| 1 | Батхүү овогтой Эрдэнэцэцэг | 10,757,413,681 | 81.02 % |
| 2 | Батхүү овогтой Батмөнх | 2,519,968,337 | 18.98 % |
| | Нийт | 13,277,382,018 | 100 % |

6. **Хувьцаа эзэмшигчийн санал өгөх эрх:** Энгийн хувьцаа эзэмшигч бүр нь санал өгөх эрхтэй бүх асуудлаар санал өгөх эрхтэй бөгөөд нэг хувьцаа нь нэг саналын эрхтэй байна. Монгол улсын хуульд өөрөөр заагаагүй бол хувьцаа эзэмшигчид нь Компанийн тухай хуулиар Компанийн хувьцаа эзэмшигчдэд олгогдсон бүхий л эрхийг эдлэх бөгөөд үүнд (а)

"БИГ МОГУЛ КОУЛ ЭНД ЭНЕРЖИ" ХХК
BIG MOGUL COAL AND ENERGY LLC
УЛААНБААТАР ХОТ
ТТ31246 ☎ 5369223

Компаниас хууль ёсоор зарлан мэдэгдсэний дагуу ногдол ашиг авах (б) Компанийг татан буулгаж, эд хөрөнгийг нь хуваарилах тохиолдолд түүний үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос эзэмшиж буй хувьцааныхаа тоотой тэнцүүлэн хувь хүртэх зэрэг эрх хамрах боловч тэдгээрээр хязгаарлагдахгүй. Компани нэмж хувьцаа гаргасан тохиолдолд Б.Батмөнхийн хувь хэмжээ буурахгүй.

7. **Хувьцаа эзэмшигчийн удирдлага.** Компанийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал байна. Хувьцаа эзэмшигчдийн хурлын ирц нь Компанийн гаргасан бөгөөд эргэлтэд байгаа энгийн хувьцааны энгийн олонхи (50%+1 ширхэг хувьцаа)-оос доошгүй хувийг эзэмшигчид биечлэн буюу итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан хуралд оролцсоноор бүрдэж, хурал хүчин төгөлдөр болно. Хурлын ирц бүрдэхгүй бол Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулахгүй бөгөөд Хувьцаа эзэмшигчдийн хойшлогдсон хурлын товыг Компанийн тухай хуулийн заалтуудад нийцүүлэн шинээр зарлан явуулна. Компанийн тухай хууль болон энэхүү Дүрэмд өөрөөр заагаагүй бол Хувьцаа эзэмшигчдээс гарсан шийдвэрүүд нь тухайн хуралд биечлэн буюу итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан оролцож байгаа бөгөөд тухайн асуудлаар санал өгөх эрхтэй, Компанийн гаргасан бөгөөд эргэлтэд байгаа энгийн хувьцааны энгийн олонхи (50%+1 ширхэг хувьцаа)-ийг эзэмшигчдийн саналаар хүчин төгөлдөр болно.
8. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах зарыг бичгээр үйлдэж хурал хуралдуулах өдрөөс өмнөх ажлын 7 (долоо) өдрөөс доошгүй болон ажлын 21 (хорин нэг) өдрөөс дээшгүй хугацаанд багтаан хүргүүлнэ. Хурлын зарыг биечлэн, факсаар эсвэл электрон шуудангаар хүргүүлж болно. Хурлын эхэнд, тухайн хурал нь хууль бусаар зарлагдсан учраас аливаа асуудлыг татгалзах тусгай зорилгоор хүрэлцэн ирэхээс бусад тохиолдолд гишүүн нь хуралд хүрэлцэн ирсэн бол түүнийг тухайн хурлын зартай холбоотой аливаа эрхээсээ татгалзсанд тооцно.
9. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх шаардлагатай буюу зөвшөөрөгдсөн аливаа асуудлыг тийнхүү хэлэлцэхийг зөвшөөрч тухайн асуудлаар санал өгөх эрхтэй бүх хувьцаа эзэмшигчид гарын үсэг зурж бичгээр зөвшөөрсөн тохиолдолд хурал хуралдахгүйгээр шийдвэрлэж болох ба уг асуудлын талаар хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэлд тэмдэглэнэ. Дээрх зөвшөөрлийг хэдэн ч хувь үйлдэж болох бөгөөд уг зөвшөөрөлд өөрөөр заагаагүй бол хамгийн сүүлчийн гарын үсэг зурагдсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.
10. **Тэргүүн ээлжинд худалдан авах эрх:** Компанийн хувьцаа эзэмшигчид нь Компанийн тухай хуулийн 5 дугаар зүйлд зааснаар бусад хувьцаа эзэмшигчийн санал болгосон хувьцаа, хувьцаа худалдан авах эрхийн бичиг болон хувьцаанд хөрвөх үнэт цаасыг тэргүүн ээлжинд худалдан авах давуу эрхтэй байна.
11. **Компанийн удирдлага:** Компанийн удирдлагыг хувьцаа эзэмшигчид Гүйцэтгэх захирлыг томилох замаар хэрэгжүүлнэ.
12. **Гүйцэтгэх захирал:** Гүйцэтгэх захирал нь Компанийн гүйцэтгэх удирдлагын дээд албан тушаалтан байх ба Компанийн өдөр тутмын үйл ажиллагааны удирдлага болон хувьцаа эзэмшигчдийн хурлын бүх тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг хангана.
13. **Хариуцлага:** Дараах нөхцөлүүдээс бусад тохиолдолд Компанийн тухай хуулийн 84.1 дүгээр зүйлд тодорхойлсон Компанийн аливаа эрх бүхий албан тушаалтан, мөн хуулийн 84.10 дугаар зүйлд дурдсан хувьцаа эзэмшигч нь (хамтад нь “Эрх бүхий албан тушаалтан” гэх) Эрх бүхий албан тушаалтны хувьд итгэмжлэгдсэн үүргээ биелүүлээгүйн улмаас учирсан мөнгөн хохирлыг Компани, түүний хувьцаа эзэмшигчдийн өмнө биечлэн хариуцахгүй. Тэдгээр нөхцөлүүд нь: (а) Эрх бүхий албан тушаалтан болохын хувьд Компани буюу Компанийн хувьцаа эзэмшигчдийн төлөө үнэнч шударгаар ажиллах үүргээ биелүүлээгүйн



"БИГ МОГУЛ КОУЛ ЭНД ЭНЕРЖИ" ХХК
BIG MOGUL COAL AND ENERGY LLC
УЛААНБААТАР ХОТ
ТТ31246 ☎ 5369223

улмаас, (б) зориуд буруу үйл ажиллагаа явуулах, санаатайгаар хууль зөрчих зэрэг шударга бус үйлдэл, эс үйлдэл хийсний улмаас (в) Эрх бүхий албан тушаалтны хувийн ашиг сонирхлын үүднээс аливаа гэрээ хэлцэл ийсний улмаас хүлээх хариуцлага зэрэг болно. Хэрэв Компанийн тухай хуульд цаашид Эрх бүхий албан тушаалтны хүлээх хариуцлагыг хязгаарлах, эсвэл хасах тухай нэмэлт, өөрчлөлт оруулбал өмнөх өгүүлбэрт дурдсан хариуцлагын хязгаарлалтаас гадна уг нэмэлт, өөрчлөлт оруулсан хуулийн дагуу Эрх бүхий албан тушаалтан бүрийн хариуцлага хязгаарлагдана.

14. **Хохирлоос чөлөөлөх:** Компани нь өөрийн Эрх бүхий албан тушаалтнаар ажиллаж байгаа буюу байсан ямар ч хувь хүнийг үүргээ гүйцэтгэхтэй нь холбогдуулан ногдуулж болох бүхий л хариуцлага, зардлаас тухайн үед хүчин төгөлдөр үйлчилж буй холбогдох хуульд заасан хэмжээгээр чөлөөлж, хохиролгүй болгоно.
15. **Компани:** Компани нь өөрийн нэг буюу түүнээс олон хувьцаа эзэмшигчтэй эсвэл уг хувьцаа эзэмшигч нь Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр, эсвэл албан тушаалтнаар ажилладаг, эсвэл санхүүгийн сонирхолтой аливаа компани, нөхөрлөл болон бусад аж ахуйн нэгжтэй Монгол улсын Компанийн тухай хууль болон бусад хууль тогтоомжоор одоо болон цаашид зөвшөөрөгдсөн журмын дагуу тус тус гэрээ хэлцэл хийх эрхтэй. Ийнхүү хэлцэл хийхэд дээрх холбоо харилцаа болон тухайн хэлцэл байгуулахыг зөвшөөрсөн хувьцаа эзэмшигчдийн хуралд өмнөх өгүүлбэрт дурдагдсан хувьцаа эзэмшигч байсан эсвэл оролцсон нь хамаарахгүй.
16. **Ногдол ашиг:** Хувьцаа эзэмшигчид нь Монгол улсын Компанийн тухай хуулинд заасны дагуу болон Хувьцаа эзэмшигчдээс тодорхойлсон ногдол ашиг авах эрхтэй.
17. **Санхүүгийн жил:** Компанийн санхүүгийн жил нь 1 дүгээр сарын 1-ний өдөр эхэлж, 12 дугаар сарын 31-ний өдөр дуусна.

"БИГ МОГУЛ КОУЛ ЭНД ЭНЕРЖИ" ХХК
BIG MOGUL COAL AND ENERGY LLC
УЛААНБААТАР ХОТ

2017 оны 5 дугаар сарын 8-ны өдөр

Гарын үсэг: ______________________

Батхүү овогтой Батмөнх

Гарын үсэг: Б. Эрдэнэцэцэг

Батхүү овогтой Эрдэнэцэцэг

**"БИГ МОГУЛ КОУЛ ЭНД ЭНЕРЖИ" ХХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ШИЙДВЭР**

2024 оны 4-р сарын 23-ны өдөр №...001... Улаанбаатар хот

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйл болон "Биг Могул Коул Энд Энержи" ХХК-ийн дүрмийн 6.1 дахь заалтуудыг тус тус үндэслэн ШИЙДВЭРЛЭСЭН нь:

1. "Биг Могул Коул Энд Энержи" ХХК-ийн бизнесийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор "ХААН банк" ХК-иас 3,000,000,000 төгрөгийн, 24 сарын хугацаатай, жилийн 20,4% хүүтэй эргэлтийн хөрөнгийн зээл авахыг ШГ74123177 регистрийн дугаартай, хувьцаа эзэмшигч Батхүү овогтой Батмөнх -д зөвшөөрсүгэй.
2. Дээр дурьдсан зээлийн барьцаанд "Биг Могул Коул Энд Энержи" ХХК-ийн өмчлөлийн өөрөө буулгагч УБИ 4381 улсын дугаартай, 2023 онд үйлдвэрлэгдсэн, TL870430EP8755771 арлын дугаартай шар өнгийн тээврийн хэрэгсэл, өөрөө буулгагч УБВ 5921 улсын дугаартай, 2023 онд үйлдвэрлэгдсэн, TL870430CP8755772 арлын дугаартай, шар өнгийн тээврийн хэрэгсэл, өөрөө буулгагч УБВ 9431 улсын дугаартай, 2023 онд үйлдвэрлэгдсэн, TL870430TP8755773 арлын дугаартай шар өнгийн тээврийн хэрэгсэл, мөн тус компанийн өмчлөлийн 1,002,956,119.38 төгрөгийн үнийн дүнтэй тоног төхөөрөмжийг жагсаалтаар, хаан банкин дахь 5037661532 тоот харилцах дансанд дахь мөнгөн хөрөнгө, уг дансанд ирээдүйд орж ирэх орлого зэргийг тус тус барьцаалуулахыг зөвшөөрсүгэй.
3. Дээр дурьдсан зээлийг "ХААН банк" ХК-иас зээлж авахад шаардагдах холбогдох гэрээ, хэлцэл (зээлийн болон барьцааны гэрээ байгуулах тэдгээрт төлөөлж гарын үсэг зурах, барьцаалбар үйлдэх, түүнд төлөөлж гарын үсэг зурах)-д "Биг Могул Коул Энд Энержи" ХХК-ийг төлөөлөх эрхийг ШГ74123177 регистрийн дугаартай, хувьцаа эзэмшигч Батхүү овогтой Батмөнх -д зөвшөөрсүгэй.

ЗӨВШӨӨРСӨН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИДИЙН ГАРЫН ҮСЭГ, "Биг Могул Коул Энд Энержи" ХХК-ИЙН ТАМГА/ТЭМДЭГ :

1. ................ / "Биг Могул Коул Энд Энержи"ХХК-ийн 81.02%-ийн хувьцаа эзэмшигч иргэн Батхүүгийн Эрдэнэцэцэг-РД:ШГ86083066/
2. ................ / "Биг Могул Коул Энд Энержи"ХХК-ийн 18,98 %-ийн хувьцаа эзэмшигч иргэн Батхүүгийн Батмөнх РД: ШГ74123177 /

УЛААНБААТАР ХОТ
БИГ МОГУЛ КОУЛ ЭНД ЭНЕРЖИ ХХК
ШТТ9447 9021040316 53692

АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР

# АШИГТ МАЛТМАЛ АШИГЛАЛТЫН ТУСГАЙ

# ЗӨВШӨӨРӨЛ

Дугаар ***MV-020772***

Ашигт малтмалын тухай Монгол Улсын хуулийн 26 дугаар зүйлийг үндэслэн

***Дундговь*** аймаг /хот/-ийн

***Баянжаргалан*** сум /дүүрэг/-ын

***Хоотийн хонхор-2*** нэртэй газарт орших

***1046.73*** гектар талбай бүхий уурхайн талбайд

хуульд заасан нөхцөл, шаардлагын дагуу ашигт малтмал ашиглахыг

зөвшөөрч улсын бүртгэлийн ***9019046139*** тоот гэрчилгээтэй

***"Биг могул коул энд энержи" хамтарсан хоронго оруулалттай ХХК***-д

энэхүү тусгай зөвшөөрлийг ***2047.02.23*** дуустал

хугацаагаар олгов.

Тусгай зөвшөөрөл хавсралтгүй бол хүчингүй.

КАДАСТРЫН ХЭЛТСИЙН
ДАРГА Д.МӨНХТАМИР

2017 оны 2 сарын 23 өдөр

Улаанбаатар хот

0000067

# ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ 1 ДҮГЭЭР ХАВСРАЛТ

**MV-020772**

**Тусгай зөвшөөрлийн гэрчилгээгүй бол хүчингүй.**

| Дэс дугаар | Тусгай зөвшөөрөлд орох өөрчлөлтийн үндэслэл | Огноо, гарын үсэг, тэмдэг |
|---|---|---|
| 001-NM | • Бүртгэв: Ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосон 2017.02.23, дуусах хугацаа 2047.02.23<br>• Тусгай зөвшөөрлийн 1 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв<br>• Кадастрын хэлтсийн даргын 2017.02.07-ний 69 тоот шийдвэр | 2017-02-23<br>1 АМГТГ ГЕОЛОГИ, УУЛ УУРХАИН КАДАСТРЫН ХЭЛТЭС ХТО7043 |
| 002-CN | • Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн эзэмшигчийн нэрийг 9011665117 тоот улсын бүртгэлийн дугаартай Биг могул коул энд энержи ХХК болгон өөрчлөх. Компаний улсын бүртгэлийн гэрчилгээ болон Улсын бүртгэлийн ерөнхий газрын тодорхойлолтыг үндэслэн компаний оноосон нэрийг өөрчлөв.<br>• Кадастрын хэлтсийн даргын 2017.05.17-ний --- тоот шийдвэр | 2017-05-17<br>1 АМГТГ ГЕОЛОГИ, УУЛ УУРХАИН КАДАСТРЫН ХЭЛТЭС ХТО7043 |
| 003-FE | • Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 2 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2018.02.23 – 2019.02.23 хүртэл | 2018-03-07<br>1 АМГТГ ГЕОЛОГИ, УУЛ УУРХАИН КАДАСТРЫН ХЭЛТЭС ХТО7043 |
| 004-FE | • Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 3 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2019.02.23 – 2020.02.23 хүртэл | 2019-02-15<br>1 АМГТГ ГЕОЛОГИ, УУЛ УУРХАИН КАДАСТРЫН ХЭЛТЭС ХТО7043 |
| 005-FE | • Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 4 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2020.02.23 – 2021.02.23 хүртэл | 2020-03-24<br>1 АМГТГ ГЕОЛОГИ, УУЛ УУРХАИН КАДАСТРЫН ХЭЛТЭС ХТО7043 |
| 006-FE | • Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 5 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2021.02.23 – 2022.02.23 хүртэл | 1 АМГТГ ГЕОЛОГИ, УУЛ УУРХАИН КАДАСТРЫН ХЭЛТЭС ХТО7043<br>2021.02.24 |
| 007-FE | • Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 6 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2022.02.23 – 2023.02.23 хүртэл | 1 АМГТГ ГЕОЛОГИ, УУЛ УУРХАИН КАДАСТРЫН ХЭЛТЭС ХТО7043<br>2022.03.09 |

# ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ 1 ДҮГЭЭР ХАВСРАЛТ

**MV-020772**

**Тусгай зөвшөөрлийн гэрчилгээгүй бол хүчингүй.**

| Дэс дугаар | Тусгай зөвшөөрөлд орох өөрчлөлтийн үндэслэл | Огноо, гарын үсэг, тэмдэг |
|---|---|---|
| 008-FE | • Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 7 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2023.02.23 – 2024.02.23 хүртэл | 1 АМГТГ КАДАСТРЫН ХЭЛТЭС ХТО7043 2023.02.20 |
| 009-FE | • Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 8 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2024.02.23 – 2025.02.23 хүртэл | 1 АМГТГ КАДАСТРЫН ХЭЛТЭС ХТО7043 2024.02.20 |
| | | |
| | | |
| | | |
| | | |
| | | |

# ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ 2 ДУГААР ХАВСРАЛТ

**MV-020772**

**Тусгай зөвшөөрлийн гэрчилгээгүй бол хүчингүй.**

| Дэс дугаар | Тусгай зөвшөөрөлд орох өөрчлөлтийн үндэслэл | Хүчин төгөлдөр талбайн хэмжээ /га/ | Хасагдах талбайн хэмжээ /га/ | Тусгай зөвшөөрлийн талбайн солбицлууд, огноо, гарын үсэг, тэмдэг | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | # | Уртраг | Өргөрөг |
| 001-NM | • Ашиглалтын тусгай зөвшөөрлийг анх олгосон 2017.02.23 | 1046.73 Га | 0 Га | 1 | 107° 43' 1.55" | 45° 45' 1.6" |
| | | | | 2 | 107° 43' 1.53" | 45° 42' 1.6" |
| | | | | 3 | 107° 42' 20.54" | 45° 42' 1.6" |
| | | | | 4 | 107° 42' 20.54" | 45° 42' 8.61" |
| | | | | 5 | 107° 41' 31.54" | 45° 42' 8.61" |
| | | | | 6 | 107° 41' 31.54" | 45° 42' 35.8" |
| | | | | 7 | 107° 41' 44.85" | 45° 42' 35.8" |
| | | | | 8 | 107° 41' 44.85" | 45° 42' 49.47" |
| | | | | 9 | 107° 41' 31.54" | 45° 42' 49.47" |
| | | | | 10 | 107° 41' 31.54" | 45° 45' 1.6" |
| | | | | 2017-02-23 | | Н.Хэрлэнчимэг |

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
УСНЫ ГАЗАР

# УС АШИГЛУУЛАХ ДҮГНЭЛТ

Улаанбаатар хот

Утас: 265528, 265578

2024 оны 10 дугаар
сарын 3 -ний өдөр

Дугаар E-2409-000076

## 1. Аж ахуйн нэгж байгууллага, захирлын нэр, утас, факс, улсын бүртгэлийн болон регистрийн дугаар

| | |
|---|---|
| Оноосон нэр: | Биг могул коул энд энержи |
| Улсын бүртгэлийн дугаар: | |
| Регистрийн дугаар: | **5369223** |
| Захирал: | **Болд** |
| Холбоо барих дугаар: | **311073** |
| Факс : | |
| И-мэйл хаяг : | |

## 2.Төслийн нэр байршил

| | |
|---|---|
| Төслийн нэр: | **Дундговь аймаг, Баянжаргалан сумын нутаг дэвсгэрт орших "Хөөтийн хонхор"-2 нэртэй нүүрсний ордыг ашиглах төсөл** |
| Байршил: | **Дундговь, Баянжаргалан, 2-р баг, Энгэр-Ус** |
| Харьяалагдах сав газар: | **Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газар** |
| Хамаарах салбар: | **Уул уурхай** |

## 3. Төсөл хэрэгжүүлэгчийн нэр

**Биг могул коул энд энержи**

## 4. Ажиллах горим, хүчин чадал

| Үргэлжлэх хугацаа | Ажиллах горим | Жилд ажиллах хоног | Хоногт ажиллах ажилчидын тоо | Хоногт ажиллах цаг |
|---|---|---|---|---|
| 9 | 2 ээлжээр | 326 | 129 | 24 |

## 5. Үйлдвэрлэх, боловсруулах бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний хэмжээ

| Ажлын нэр | Тоо хэмжээ | Хэмжих нэгж | Тайлбар |
|---|---|---|---|
| Зам, талбайн тоосжилт дарахад ашиглах усны хэмжээ | 112000.0 | м2 | Хөрсийг гадаад овоолгод тээвэрлэх зай 2 км, уурхайн төв зам хүртэлх тээврийн зай 5 км, замын өргөн 16 м. Эхний жил буюу 2024 онд бороотой байх 15 хоногийг хасаад 43 хоног тоосжилт дарахаар тооцсон. (БОННҮ нэмэлт тодотгол тайлан 2024 он, 87, 88-р хуудас, Усны газрын 2024.02.23-ны 01/250 тоот усны ашиглах боломжит нөөцийн дүгнэлтээр тоосжилт дарахад |

| Ажлын нэр | Тоо хэмжээ | Хэмжих нэгж | Тайлбар |
| --- | --- | --- | --- |
| | | | шаардлагатай усыг уурхайн шүүрлийн уснаас эргүүлэн ашиглана.) Уурхайн ухлагад шүүрч орж ирэх 175,930.0 м3 шүүрлийн усанд төлбөр ногдуулсан тул 100 хувь хөнгөлөв. |
| Хайгуулын өрөмдлөгт ашиглах усны хэмжээ | 115.92 | 100.0 тууш.метр | Өрмийн машин хоногт 272 м өрөмдөх ба жил бүр харилцан адилгүй өрөмдөхөөр ТЭЗҮ-д тусгасан. Ашиглалтын эхний жил 1159.2 м өрөмдлөгийн ажил хийхээр төлөвлөсөн. (БОННҮ нэмэлт тодотгол тайлан 2024 он, 87, 88-р хуудас, Усны газрын 2024.02.23-ны 01/250 тоот усны ашиглах боломжит нөөцийн дүгнэлтээр өрөмдлөгт шаардлагатай усыг уурхайн шүүрлийн уснаас эргүүлэн ашиглана.) Уурхайн ухлагад шүүрч орж ирэх 175,930.0 м3 шүүрлийн усанд төлбөр ногдуулсан тул 100 хувь хөнгөлөв. |
| Ногоон байгууламж, нөхөн сэргээлтэд ашиглах усны хэмжээ | 20000.0 | м2 | Уурхай жилд 2 га талбайд олон наст ургамлын үр тарьж суулгана. Бороотой байх өдрүүдийг хасаад дунджаар жилд 42 хоног усалгаа хийхээр төлөвлөсөн. (БОННҮ нэмэлт тодотгол тайлан 2024 он, 88-р хуудас, Усны газрын 2024.02.23-ны 01/250 тоот усны ашиглах боломжит нөөцийн дүгнэлтээр ногоон байгууламжид шаардлагатай усыг уурхайн шүүрлийн уснаас эргүүлэн ашиглана.) Уурхайн 175,930.0 м3 шүүрлийн усанд төлбөр ногдуулсан тул 100 хувь хөнгөлөв. |
| Тэр бум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд мод услахад ашиглах усны хэмжээ | 500.0 | ш | 2024 оны уулын ажлын төлөвлөгөөгөөр биологийн болон дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээлт хийгдэхгүй. Тэр бум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд уурхайн тосгоны ард 0.3 га талбайд 500 ш тод тариалахаар төлөвлөсөн. (БОННҮ нэмэлт тодотгол тайлан 2024 он, 88-р хуудас, Усны газрын 2024.02.23-ны 01/250 тоот усны ашиглах боломжит нөөцийн дүгнэлтээр ногоон байгууламжид шаардлагатай усыгуурхайн шүүрлийн уснаас эргүүлэн ашиглана.) Уурхайн ухлагад шүүрч орж ирэх 175,930.0 м3 шүүрлийн усанд төлбөр ногдуулсан тул 100 хувь хөнгөлөв. |
| Уурхайн ухлагад шүүрэн орж ирэх усны хэмжээ | 482.0 | м3 | 2024 оны уулын ажлын төлөвлөгөөний маягт 3-т 2024 онд 12 сар буюу 365 хоног ажиллахаар төлөвлөж, батлуулсан. Нүүрсний давхраанудыг хуурайшуулан ил аргаар олборлоход уурхайн хажуугийн ханы шүүрэлтээр мөргөцөгт хуримтлагдах усны тоо хэмжээг хана руу шүүрэх "Том худаг"-ын аргаар тодорхойлоход хоногт 482.0 м3/хон шүүрэн орж ирэхээр байна. Өрөмдлөг, зам талбай, ногоон байгууламижид шаардлагатай усыг |

| Ажлын нэр | Тоо хэмжээ | Хэмжих нэгж | Тайлбар |
| --- | --- | --- | --- |
| | | | уурхайн шүүрлийн уснаас эргүүлэн ашиглана. (БОННҮ нэмэлт тодотголын тайлан 2024 он, 84, 88-р хуудас, Усны газрын 2024.02.23-ны 01/250 тоот усны ашиглах боломжит нөөцийн дүгнэлт) |
| Ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээнд ашиглах усны хэмжээ | 129.0 | хоногт 1 хүн | 2024 оны уулын ажлын төлөвлөгөөний маягт 3-т 12 сар буюу 365 хоног ажиллахаар төлөвлөж, батлуулсан. Байгууллагаас ирүүлсэн төслийн мэдээлэлд хоногт 129 хүн ажиллана гэсэн. (БОННҮ нэмэлт тодотгол тайлан 2024 он, 88-р хуудас, Усны газрын 2024.02.23-ны 01/250 тоот усны ашиглах боломжит нөөцийн дүгнэлтээр унд, ахуйд шаардлагатай усыг гүний худгаас авч ашиглана. ) |

## 6. Усны эх үүсвэр, нөөц, хоногт ашиглах хэмжээ

| Эх үүсвэр | Зориулалт | Усны нөөц (л) | Усны нөөц (м3) | Тайлбар |
| --- | --- | --- | --- | --- |
| Гүний худаг | Унд ахуй | 1.1 | 95.04 | Усны газрын 2024.02.23-ны 01/250 тоот усны ашиглах боломжит нөөцийн дүгнэлтээр " "Мэнд шүтээн" ХХК-ийн хэрэгжүүлэх Хөөтийн хонхор-2 нэртэй нүүрсний ордыг ашиглах төсөлд шаардагдах унд, ахуйн (162.02 м3/хон) усны хэрэглээг өөрийн эзэмшлийн 1.1 л/сек (95.04 м3/хон) ундаргатай гүний худгаас, өрөмдлөг зам, талбай, ногоон байгууламжийн усалгаанд шаардагдах (142.72 м3/хон) усны хэрэглээг уурхайн ухлагад орж ирэх 482.0 м3/хон шүүрлийн усаар хангахад усны ашиглах боломжит нөөцийн хэмжээ хүрэлцээтэй" гэсэн. Төслийн унд ахуйн хэрэглээнд ашиглах усны хэрэглээг гүний худгаас, өрөмдлөг, зам, талбай, ногоон байгууламжийн усалгаанд шаардагдах усны хэрэглээг хоногт уурхайн ухлагад орж ирэх 482,0 м3 шүүрлийн усаар хангана. |
| Шүүрлийн ус | Усны хэрэглээ | 5.578 | 481.9392 | Нүүрсний давхраануудыг хуурайшуулан ил аргаар олборлоход уурхайн хажуугийн ханы шүүрэлтээр мөргөцөгт хуримтлагдах усны тоо хэмжээг хана руу шүүрэх "Том худаг"-ын аргаар тодорхойлоход хоногт 482.0 м3/хон шүүрэн орж ирэхээр байна. (БОННҮ нэмэлт тодотголын тайлан 2024 он, 84-р хуудас, Усны газрын 2024.02.23-ны 01/250 тоот усны ашиглах боломжит нөөцийн дүгнэлт) |

## 7.Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, нөхцөл

| | |
| --- | --- |
| Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ боловсруулсан ААНБ : | **Мэнд шүтээн ХХК** |
| Холбоо барих : | **9905008** |
| Нэмэлт мэдээлэл: | |

## 8. Усны барилга байгууламжууд

| Барилга байгууламж | Хүчин чадал (м3) | Хэмжээ хийц |
|---|---|---|
| Гүний худаг | 95.04 | Цооногийн гүн 90.0 м<br>Усны тогтсон түвшин 10.0 м |

## 9. Дамжуулах байгууламж

| Хаанаас (эхлэх цэг) | Хаана хүртэл (төгсгөлийн цэг) | Шугамын голч, мм | Дамжуулах шугамын урт, м |
|---|---|---|---|
| | Ажилчдын кемп | | 300 |

## 10. Онцгой нөхцөл

- **Усны сан, голын хамгаалалтын бүсэд үйл ажиллагаа явуулахыг хориглох;**
- **Тусгай зөвшөөрлийн талбайд байгаа голыг хамгаалах, хөв цөөрөм байгуулах, татмын ойжуулалт хийх гэх мэт арга хэмжээ авч ажиллах;**
- **Усны тухай хуулийн 30.1.4-т заасны дагуу ус татах шугам хоолой бүрт баталгаажуулсан онлайн тоолуур суурилуулж ажиллахад анхаарах;**

## 11. Усны зарцуулалт

| Ажлын нэр | Тоо Хэмжээ | Хэмжих нэгж | Усны хэрэглээ, м3 (Норм) | Гүйцэтгэх давтамж | Хэмжих нэгж | Нийт ашиглах усны хэмжээ, м3 | Хөнгөлөх усны хэмжээ м3 | Төлбөр тооцох усны хэмжээ м3 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Зам, талбайн тоосжилт дарахад ашиглах усны хэмжээ | 112000.0 | м2 | 0.002 | 43.0 | Удаа | 9,632.00 | 9,632.00 | 0.00 |
| Хайгуулын өрөмдлөгт ашиглах усны хэмжээ | 115.92 | 100.0 тууш.метр | 10.0 | 1.0 | Удаа | 1,159.20 | 1,159.20 | 0.00 |
| Ногоон байгууламж, нөхөн сэргээлтэд ашиглах усны хэмжээ | 20000.0 | м2 | 0.004 | 42.0 | Удаа | 3,360.00 | 3,360.00 | 0.00 |
| Тэр бум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд мод услахад ашиглах усны хэмжээ | 500.0 | ш | 0.05 | 18.0 | Удаа | 450.00 | 450.00 | 0.00 |
| Уурхайн ухлагад шүүрэн орж ирэх усны хэмжээ | 482.0 | м3 | 1.0 | 365.0 | Хоног | 175,930.00 | 0.00 | 175,930.00 |
| Ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээнд ашиглах усны хэмжээ | 129.0 | хоногт 1 хүн | 0.15 | 365.0 | Хоног | 7,062.75 | 0.00 | 7,062.75 |
| **Нийт** | | | | | | **197,593.95** | **14,601.20** | **182,992.75** |

## 12. Урьдчилсан байдлаар тооцсон усны нөөц ашигласны төлбөрийн хэмжээ

| Ажлын нэр | Төлбөр тооцох усны хэмжээ, м3 | Усны ангилал | Хөнгөлөх хувь хэмжээ, % | 1 м3 усны үнэ | Усны нөөц ашигласны төлбөр, ₮ | Төлбөрөөс хөнгөлсөн дүн, ₮ | Төлбөл зохих дүн, ₮ |
|---|---|---|---|---|---|---|---|
| Зам, талбайн тоосжилт дарахад ашиглах усны хэмжээ | 0.00 | Газрын доорх ус | 0.0 | 185.00 | 0.00 | 0.0 | 0.00 |
| Хайгуулын өрөмдлөгт ашиглах усны хэмжээ | 0.00 | Газрын доорх ус | 0.0 | 1110.00 | 0.00 | 0.0 | 0.00 |
| Ногоон байгууламж, нөхөн сэргээлтэд ашиглах усны хэмжээ | 0.00 | Газрын доорх ус | 0.0 | 74.00 | 0.00 | 0.0 | 0.00 |
| Тэр бум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд мод услахад ашиглах усны хэмжээ | 0.00 | Газрын доорх ус | 0.0 | 74.00 | 0.00 | 0.0 | 0.00 |
| Уурхайн ухлагад шүүрэн орж ирэх усны хэмжээ | 175930.00 | Газрын доорх ус | 0.0 | 888.00 | 156,225,840.00 | 0.0 | 156,225,840.00 |
| Ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээнд ашиглах усны хэмжээ | 7062.75 | Газрын доорх ус | 0.0 | 88.80 | 627,172.20 | 0.0 | 627,172.20 |
| **Нийт** | **182,992.75** | | | | **156,853,012.20** | | **156,853,012.20** |

## 13. Тавигдах шаардлага, цаашид авах арга хэмжээ, зөвлөгөө

- **Усны тухай хуулийн 28.6-д заасны дагуу Умард говийн гүвээт халхын дундад талын сав газрын захиргаанаас ус ашиглах зөвшөөрөл авч, зохих журмын дагуу гэрээ байгуулах;**
- **Усны тухай хуулийн 28.18-д зааснаар ус ашиглуулах дүгнэлт, холбогдох зөвшөөрөлгүйгээр ус ашиглахыг хориглодог болохыг анхаарах;**
- **Жил бүрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн төлөвлөгөөг үндэслэлтэй, үнэн зөв гаргаж байх;**
- **Худаг, усны эх үүсвэр өөрчлөгдвөл усны ашиглах боломжит нөөцийн дүгнэлтийг шинэчлэн гаргуулах;**
- **Засгийн газрын 2018 оны 391 дүгээр тогтоолоор баталсан журмын дагуу зөвшөөрсөн хэмжээнээс илүү ашигласан усны нөөц ашигласны төлбөрийг шатлан өсгөж тооцохыг анхаарах;**
- **Усны тухай хуулийн 30.1.4-т заасны дагуу усыг ашиглах шугам хоолой бүрт тоолуур суурилуулан баталгаажуулж, тоолуурын заалтаар усны нөөц ашигласны төлбөрийг тооцож, Төсвийн тухай хуулийн 26.6.5-д заасны дагуу төсөвт төвлөрүүлэх;**
- **Хаягдал усны дүгнэлтийг дараа жилийн эхний улиралд багтаан гаргуулах;**
- **Усны тухай хуулийн 30.1.2-т заасны дагуу усны хэрэглээ хариуцсан ус ашиглалтын менежертэй байх;**
- **Үйл ажиллагаа нь зогсох, тасалдах нөхцөл байдал үүссэн үед Сав газрын захиргаа болон холбогдох төрийн захиргааны байгууллагуудад даруй мэдэгдэж, тухайн оны ус ашиглалтын тайланд тусгаж ирүүлэх;**
- **Усны тухай хуулийн 7.5-д заасны дагуу улсын усны мэдээллийн сан бүрдүүлэхэд шаардлагатай ус ашиглалтын тайлан (газрын доорх усны хяналт шинжилгээний мэдээ, ус ашиглах зөвшөөрөл, гэрээ, гэрээ дүгнэсэн акт, усны нөөц ашигласны төлбөрийн баримт, ус ашиглалтын тоо, хэмжээ)-г 2024 оны 12 дугаар сарын 20-ны дотор Усны газарт office@water.gov.mn цахим хаягаар болон холбогдох газруудад хүргүүлж ажиллах;**

**Боловсруулсан:**

| | |
|---|---|
| УС АШИГЛАЛТЫН ХЭЛТЭС | **Б.Мэндбаяр** |
| Боловсруулсан огноо: | **2024.10.03** |

БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН
ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ
**УМАРД ГОВИЙН
ГҮВЭЭТ-ХАЛХЫН ДУНДАД
ТАЛЫН САВ ГАЗРЫН ЗАХИРГАА**

Найрамдал хотхон, 3 дугаар баг,
Сүмбэр сум, Говьсүмбэр аймаг, 42015
Утас/Факс: (976) 7054 3599,
Цахим шуудан: umardgobi14@gmail.com,
Цахим хуудас: www.umardgobi.met.gov.mn

2024.11.14 № 316

танай ____________-ны №____________-т

БАЯНЖАРГАЛАН СУМЫН
ЗАСАГ ДАРГАД

"Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль" түүнийг дагалдан гарсан журмууд батлагдсантай холбогдуулан уг хуулийн 4.1, "Усны тухай хууль"-ийн 24.2-т тус тус заасны дагуу Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй ус бохирдуулагч "Биг могул коул энд энержи" ХХК-ийн 2024 оны хаягдал усны дүгнэлтийг гарган хүргүүлж байна.

Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2-т заасны дагуу ус бохирдуулсны төлбөрийн гэрээ байгуулж, хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрлийг олгоно уу.

Хувийг: "Биг могул коул энд энержи" ХХК-д
Хавсралт 2 хуудастай.

ДАРГА Б.ОТГОНСҮРЭН

ТТБ6849 4613376

**УМАРД ГОВИЙН ГҮВЭЭТ-ХАЛХЫН ДУНДАД ТАЛЫН САВ ГАЗРЫН ЗАХИРГААНЫ ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 11 сарын 14 өдөр Дугаар А/146 Сүмбэр сум

Зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын "Усны тухай хууль"-ийн 28 дугаар зүйлийн 28.6, 28.7, 29 дүгээр зүйлийн 29.1, 17 дугаар зүйлийн 17.1.10 дахь заалт, Монгол Улсын Засгийн Газрын хэрэгжүүлэгч агентлаг "Усны газар"-ын 2024 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн Е-2409-000076 тоот ус ашиглуулах дүгнэлтийг тус тус үндэслэн **ТУШААХ** нь:

1. Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт байрлах "Биг могул коул энд энержи ХХК-ийн уурхайн шүүрлийн ус 175'930.0 шоометр, ашиг олох зориулалтаар 7'062.75 шоометр нийт 182'992.75 шоометр усыг 1 жилийн хугацаагаар "Биг могул коул энд энержи ХХК-д ашиглахыг зөвшөөрсүгэй.

2. "Биг могул коул энд энержи ХХК-ийн ус ашиглалтын байдалд байнгын хяналт тавьж ажиллахыг ус Газрын доорх усны нөөц ашиглалтын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн /Б.Сарантуяа/-д үүрэг болгосугай.

3. Монгол Улсын "Улсын тэмдэгтийн хураамжий н тухай" хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.20-д заасны дагуу ус ашиглах зөвшөөрлийн хураамжийг Баянжаргалан сумын Төрийн сан банкны дансанд тушаах, "Төсвийн тухай хууль"-ийн 23 дугаар зүйлийн 23.6.5-д заасны дагуу үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөрийг Дундговь аймгийн төсөвт гэрээнд заасан хугацаанд төвлөрүүлэхийг "Биг могул коул энд энержи ХХК-ийн гүйцэтгэх захирал /С.Болд/-д үүрэг болгосугай.

4. "Усны тухай хууль"-ийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх заалтын дагуу ус ашиглагчийн үүрэг, тавигдах шаардлагыг ханган ажиллах, усны ашиглах боломжит нөөцийн хэмжээнээс хэтрүүлэн хэрэглэхгүй байх болон 7 дугаар зүйлийн 7.5 дахь заалтын дагуу усны мэдээллийн сан бүрдүүлэхтэй холбогдсон мэдээ, тайланг 2024 оны 12-р сарын 30-ны өдрийн дотор ирүүлэхийг "Биг могул коул энд энержи ХХК-ийн гүйцэтгэх захирал /С.Болд/-д даалгасугай.

ДАРГА Б.ОТГОНСҮРЭН

ТТБ6849 ☎ 4613376

| | |
|---|---|
| БАТЛАВ.<br>УМАРД ГОВИЙН ГҮВЭЭТ-ХАЛХЫН ДУНДАД ТАЛЫН САВ ГАЗРЫН ЗАХИРГААНЫ ДАРГА<br>................................/Б.ОТГОНСҮРЭН/ | БАТЛАВ:<br>“БИГ МОГУЛ КОУЛ ЭНД ЭНЕРЖИ” ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ<br>................................/С.БОЛД/ |

# УС АШИГЛАХ ГЭРЭЭ

2024 оны 11 сарын 14-ны өдөр Дугаар- **34** Чойр хот

**Нэг. Ерөнхий зүйл**

Монгол Улсын “Усны тухай хууль”-ийн 28 дугаар зүйлийн 28.4, 28.6, 28.7, 29 дүгээр зүйлийн 29.1-д заасны дагуу Монгол Улсын Засгийн Газрын хэрэгжүүлэгч агентлаг “Усны газар”-ын гаргасан 2024 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн Е-2409-000076 дугаартай ус ашиглуулах дүгнэлт, Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газрын захиргааны даргын олгосон 2024 оны 11 дугаар сарын 14-ны өдрийн А/46 дугаартай ус ашиглах зөвшөөрлийг үндэслэн:

Ус ашиглуулагчийг төлөөлж: Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газрын захиргааны Газрын доорх усны нөөц ашиглалтын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн Б.Сарантуяа,

Ус ашиглагчийг төлөөлж: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпийн гудамж, 7/13, Цэтрум төв, 4 давхар, 401 тоот. Улсын бүртгэлийн дугаар 9011225079. Регистрийн дугаар 5369223, Биг могул коул энд энержи ХХК-ийн Байгаль орчны мэргэжилтэн Г.Бадамгарав ус ашиглах талаар тохиролцон энэхүү гэрээг 1 жилийн хугацаатайгаар байгуулав.

**Хоёр. Гэрээний гол нөхцөл**

2.1. Ус ашиглах зориулалт: Нүүрс олборлох уурхай

2024 онд Хөөтийн хонхор-2 уурхай 3942.77 мян.м3 хөрс хуулалтын ажил гүйцэтгэх бөгөөд 950 мян.тн нүүрс олборлоно.

Уурхай жилд 2 га талбайд олон наст ургамлын үр тарьж суулгана. “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд 0.3 га талбайд 500ш мод тариалахаар төлөвлөсөн.

2.2. Нийт ашиглах усны хэмжээ: **182’992.75 м$^3$/жил**

2.2.1. Шүүрлийн ус: 175’930.0 м$^3$/жил

2.2.2. Ашиг олох зориулалтаар: 7’062.75 м$^3$/жил

2.4. Усны эх үүсвэр:

Усны газрын 2024.02.23-ны өдрийн 01/250 тоот усны ашиглах боломжит нөөцийн дүгнэлтээр “Мэнд шүтээн” ХХК-ийн хэрэгжүүлэх Хөөтийн хонхор-2 нэртэй нүүрсний ордыг ашиглах төсөлд шаардагдах унд, ахуйн 162.02м3/хон усны хэрэглээг өөрийн эзэмшлийн 1.1л/сек /95.04м3/хон/ ундаргатай ундаргатай гүний худгаас, өрөмдлөг зам, талбай, ногоон байгууламжийн усалгаанд шаардагдах /142.72м3/хон/ усны хэрэглээг уурхайн ухлагад ирэх 482.0м3/хон шүүрлийн усаар хангахад усны ашиглах боломжит нөөцийн хэмжээ хүрэлцээтэй гэсэн. Төслийн унд, ахуйн хэрэглээнд ашиглах усны хэрэглээг гүний худгаас, өрөмдлөгө, зам талбай, ногоон байгууламжийн усалгаанд шаардагдах усны хэрэглээг хоногт уурхайн ухлагад орж ирэх 482.0м3 шүүрлийн усаар хангана.

2.4.1. Байршил:Дундговь аймаг Баянжаргалан сум

| Худгийн дугаар | Уртраг | Өргөрөг | Ундарга л/с | Усны нөөц м3 |
|---|---|---|---|---|
| Шүүрлийн ус | - | - | 5.578 | 481.9392 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Худаг унд ахуй | - | - | 1.1 | 95.04 |

2.4.2. Барилга байгууламж: Ажилдын кемп дамжуулах шугамын урт 300м

2.4.3. Тоног төхөөрөмжийн нэр, марк: .......................................

2.5. Хаягдал ус: Ахуйн бохир усыг цооногт хуримтлуулж, соруулах байдлаар шийдсэн.

Хаях цэгийн байршил: Уурхай талбайд.

2.6. Хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээ:

Жинлэгдэх бодис, кг:.......................................................................................
Органик бодис, кг:.............................................................................................
Эрдэс бодис, кг:..................................................................................................
Хүнд металл, кг:.................................................................................................
Аюултай бохирдуулах бодис, гр:..................................................................

2.7. Бохир ус цэвэрлэх байгууламжийн байршил, хүчин чадал, технологи, цэвэрлэх арга, цэвэрлэгээний түвшин: -

2.8. Усны эх үүсвэрийг хамгаалах, усны нөөц хомсдох, бохирдохоос сэргийлэх арга хэмжээ, түүнд зарцуулах хөрөнгийн хэмжээ: .....................................................................

2.9. Усны тоолуур:

2.10. Ус ашигласны нэгж төлбөрийн хэмжээ:

Уурхайн шүүрлийн ус 175’930.0 $м^3$/жил, ашиг олох зориулалтаар 7’062.75 $м^3$/жил газрын доорх усны төлбөрийн хэмжээг Засгийн газрын 2011 оны 302 дугаар тогтоолоор баталсан Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газарт тогтоосон газрын доорх усны экологи-эдийн засгийн суурь үнэ, Засгийн газрын 2013 оны 327 дугаар тогтоолд заасан ашиглалтын зориулалтыг тооцох итгэлцүүр, Засгийн газрын 2013 оны 326 дугаар тогтоолд заасан газрын доорх усны нөөц ашигласны төлбөрийг урьдчилсан байдлаар тооцвол:

**Шавхан зайлуулах усны нөөц ашигласны төлбөр**:

*1$м^3$ газрын доорх усны үнэ 3700төг/$м^3$ x 0.15 x 1.6 = 888.0төг/$м^3$*

- 3700төг/$м^3$ Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газарт тогтоосон газрын доорх усны экологи, эдийн засгийн суурь үнэлгээ:
- (15%)- Засгийн газрын 326-р тогтоолын 7(в)-д заасан газрын доорх ус шавхан зайлуулсныг тооцох төлбөрийн хувь хэмжээ.
- 1.6 - Засгийн газрын 327-р тогтоолд заасан Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газарт усыг шавхан зайлуулах зориулалтаар газрын доорх ус шавхан зайлуулсныг тооцох итгэлцүүр

175’930.0 $м^3$/жил x 888.0 төг/$м^3$= 156’225’840 төгрөг

**Ашиг олох зориулалтаар ашиглах газрын доорх усны нөөц ашигласны төлбөр:**

*1$м^3$ газрын доорх усны үнэ 3’700төг/$м^3$ x 0.16 x 1.5 = 88.8төг/$м^3$*

- 3’700төг/$м^3$- Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газарт тогтоосон газрын доорх усны экологи, эдийн засгийн суурь үнэлгээ:
- (15%) - Засгийн газрын 2013 оны 326-р тогтоолын 9-т газрын доорх ус ашигласны төлбөрийн хувь, хэмжээ. Монгол Улсын Засгийн газрын тогтоол 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 416 дугаар тогтоолоор өөрчлөлт орсон/

- 0.16 - Ашиг олох зориулалтаар газрын доорх ус ашигласныг тооцох итгэлцүүр

7’062.75 $м^3$/жил х 88.8 төг/$м^3$ = 627’172.2 төгрөг

**Нийт төлбөр** = 156’225’840 төгрөг + 627’172.2 төгрөг = **156’853’012.2 төгрөг**

/Нэг зуун тавин зургаан сая найман зуун тавин гурван мянга арван хоёр төгрөг хоёр мөнгө/

Уурхайн хэрэгцээнд ашиглах **182’992.75 $м^3$/жил** газрын доорх усны төлбөр **156’853’012.2 төгрөг** //Нэг зуун тавин зургаан сая найман зуун тавин гурван мянга арван хоёр төгрөг хоёр мөнгө/-ийг Дундговь аймгийн Төрийн сан банкны **100080000944** тоот дансанд төвлөрүүлнэ.

**Гурав. Талуудын эрх үүрэг**

3.1. Ус ашиглуулагч нь “Усны тухай хууль”-ийн 17 дугаар зүйлийн 17.1.7, 17.1.9, 17.1.10 дахь заалтын дагуу эрх эдэлнэ.

3.2. Ус ашиглагч нь дараах үүрэгтэй:

3.1. Ус ашиглуулагч нь “Усны тухай хууль”-ийн 17 дугаар зүйлийн 17.1.7, 17.1.9, 17.1.10 дахь заалтын дагуу эрх эдэлнэ.

3.2. Ус ашиглагч нь дараах үүрэгтэй:

3.2.1. Усны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1 дэх заалтын дагуу ус ашиглах зөвшөөрөл, гэрээнд заасан хэмжээнээс хэтрүүлэн ашиглахгүй байх;

3.2.2. Усны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4 дэх заалтын дагуу ус авах цэг, газар доорх усны цооног, шугам хоолой бүрд баталгаажсан онлайн тоолуур суурилуулах

3.2.3. Усны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5 дахь заалтын дагуу усны мэдээллийн санг бүрдүүлэхтэй холбогдсон мэдээг сав газрын захиргаанд гаргаж өгнө.

3.2.4. Ажилчдын ундны усыг “Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар аюулгүй байдлын үнэлгээ” MNS0900:2018 стандартын шаардлагад нийцсэн усаар хангаж, улиралд 1 удаа байгаль орчны итгэмжлэгдсэн лабораториор шинжилгээ хийлгэж, хариуг Сав газрын захиргаанд ирүүлэх;

3.2.4. Ус ашиглалтын байдалтай холбоотой асуудлыг тухай бүрт нь мэдэгдэж, шаардлагатай тохиолдолд Сав газрын захиргааны холбогдох мэргэжилтнийг дуудаж газар дээр нь шийдвэрлэж байх.

3.2.5. Үйл ажиллагаа зогсох, тасалдах нөхцөл байдал үүссэн үед Сав газрын захиргаа болон холбогдох төрийн байгууллагуудад даруй мэдэгдэж, тухайн оны ус ашиглалтын тайланд тусгаж ирүүлэх;

3.2.6. Тухайн сумын татварын болон байгаль орчны хяналтын улсын байцаагчдыг тус тус байлцуулан тоолуурын заалтыг сар бүрийн эхний болон эцсийн заалтыг акт, зургаар баталгаажуулалт хийж 1 хувийг Сав газрын захиргаанд ирүүлэх;

3.2.7. Усны сан бүхий газрын хамгаалалтын бүсэд үйл ажиллагаа явуулахыг хориглох;

3.2.8. Голын хамгаалалтын бүсэд хөрс хуулалт, олборлолт явуулахыг хориглох;

3.2.9. Тусгай зөвшөөрлийн талбайд байгаа голыг хамгаалах, хөв цөөрөм байгуулах , татмын ойжуулалт хийх гэх мэт арга хэмжээ авч ажиллах;

3.2.10. Хаягдлын сангийн зургийг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, Усны газраар дүгнэлт гаргуулах

3.2.11. Улирал бүр 2-оос доошгүй удаа хаягдал усны холимог сорьц авч, байгаль орчны итгэмжлэгдсэн лабораториор шинжилгээ хийлгэж, хариу дүнг улирал бүрийн сүүлийн сарын 15-ны дотор Усны газар болон Сав газрын захиргаанд ирүүлэх;

3.2.12. Хаягдал бохир усыг стандартын шаардлагад нийцүүлэн цэвэрлэж, цэвэрлэсэн усаа ногоон байгууламжийн усалгаанд ашиглах;

3.2.13. "Усны тухай хууль"-ийн 6 дугаар зүйлийн 6.2.3, 30 дугаар зүйлийн 30.1.2 дахь заалтуудын дагуу аж ахуй нэгж байгууллага нь газрын доорх усны дотоод хяналтын цэгийг байгуулна.

3.2.14. Гэрээнд заасан хэмжээнээс илүү ус ашигласан тохиолдолд Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 26-ны 391 дүгээр тогтоолоор баталсан журмын дагуу усны нөөц ашигласны төлбөрийг шатлан өсгөж тооцно.

3.2.15. Усыг гэрээнд зааснаас бусад зориулалтаар, буюу хэмжээнээс хэтрүүлэн ашигласнаа нуун дарагдуулсан, зөвшөөрсөн хэмжээнээс хэтрүүлэн ашигласан, усны төлбөр төлөхөөс зайлсхийсэн болон төлбөрийг хугацаанд нь төлөөгүй тохиолдолд "Зөрчлийн тухай" хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

**Дөрөв. Бусад**

4.1. Гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

4.2. Ус ашиглуулах дүгнэлт, ус ашиглах зөвшөөрөл, хаягдал усны талаарх дүгнэлт, хаягдал ус зайлуулах зөвшөөрөл нь гэрээний салшгүй хэсэг байна.

4.3. Ус ашиглуулагч нь 2024 оны 12 дугаар сарын 30-ны дотор ус ашиглалтын тайлан болон усны нөөц ашигласны төлбөрийн мэдээг хүлээн авч гэрээний биелэлтийг дүгнэж, тэмдэглэл үйлдэнэ.

4.4. Талуудын тохиролцсоноор гэрээнд, нэмэлт өөрчлөлт оруулж болох ба бичгээр үйлдэнэ.

4.5. Гэрээг "Усны тухай хууль"-ийн 17 дугаар зүйлийн 17.1.9, 29 дүгээр зүйлийн 29.3 дахь заалтууд болон дор дурьдсан үндэслэлээр хугацаанаас өмнө цуцална.

4.5.1. Ашиглаж байгаа усны эх үүсвэр тусгай хэрэгцээнд шилжсэн.

4.5.2. Аль нэг тал нь татан буугдсан бол.

4.6. Талуудын хооронд үүссэн маргааныг эвийн журмаар шийдвэрлэхийг эрхэмлэх бөгөөд эс зөвшөөрвөл холбогдох шатны шүүхээр шийдвэрлүүлнэ.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

Ус ашиглуулагчийг төлөөлж:

Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газрын захиргааны Газрын доорх усны нөөц ашиглалтын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн

........................................................../Б.Сарантуяа /

Хаяг: Монгол улс, Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 2 дугаар баг, Ногоон хөгжлийн төв, 2 давхарт, 205 тоот

Харилцах утас: 7054-3598, 7054-3599

Ус ашиглагчийг төлөөлж:

Биг могул коул энд энержи ХХК-ийн Байгаль орчны мэргэжилтэн

............................................./Г.Бадамгарав/

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпийн гудамж, 7/13, Цэтрум төв, 4 давхар, 401 тоот.

Харилцах утас:

ЭВДЭРСЭН ГАЗАРТ НӨХӨН СЭРГЭЭЛТ

ХИЙСЭН ГАЗРЫГ ХҮЛЭЭЖ АВАХ АКТ

2024 оны 12 дугаар сарын 06 өдөр

| 1.Байршлын мэдээлэл | | |
|---|---|---|
| 1.1 | Аймаг, нийслэлийн нэр | Дундговь |
| 1.2 | Сум, дүүргийн нэр | Баянжаргалан |
| 1.3 | Газрын нэр | 3-р баг Сүүл-Өндөр |
| 2. Нөхөн сэргээлт хийсэн байгууллагын нэр | | |
| 2.1 | Аж ахуйн нэгжийн нэр, регистрийн дугаар | Биг могул коул энд энержи 5369223 |
| 2.2 | Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн дугаар | 020772A |
| 2.3 | Тус талбайд нийт эвдрэлд өртсөн талбайн хэмжээ (га) | |
| 2.4 | Нөхөн сэргээлт хийсэн аж ахуйн нэгжийн нэр, регистр | Биг могул коул энд энержи 5369223 |

| 3. Өмнөх жилүүдэд тухайн тусгай зөвшөөрлийн талбайд хийгдсэн нөхөн сэргээлтийн ерөнхий мэдээ | |
|---|---|
| 3.1 Техникийн нөхөн сэргээлт | 3.2 Биологийн нөхөн сэргээлт |
| Талбайн хэмжээ (га) : үйл ажиллагаа явуулаагүй | |
| Зардлын хэмжээ (төг) | Зардлын хэмжээ (төг) |
| 4. 2024 онд хүлээлгэн өгч буй нөхөн сэргээлтийн мэдээлэл | |
| 4.1 Техникийн нөхөн сэргээлт | 4.2 Биологийн нөхөн сэргээлт |
| Талбайн хэмжээ (га) 1061м$^2$ | Талбайн хэмжээ (га) |
| Зардлын хэмжээ (төг) 8,850,000төг | |
| 5. Орон зайн мэдээлэл | |
| 5.1 Нөхөн сэргээлт хийгдсэн газрын фото зураг | 5.2 Хэмжилт, зураглал<br>Кадастрын зураглал хийсэн мэргэжлийн байгууллага болон хэмжилт хийсэн хүний нэр:<br>Хэмжилтэд ашигласан программ, тоног төхөөрөмж<br>Холбогдох утас:<br>Гарын үсэг: |
| 5.3 Нөхөн сэргээлт хийсэн газрын солбилцол | № / Техник, биологи (доогуур зурах) / Өргөрөг / Уртраг |

| | | | |
|---|---|---|---|
| Жич. 4-өөс доошгүй эргэлтийн цэгийн солбилцол байна. | 1 | 45 46 24, 16,8 | 107 58 31 |
| | 2 | 45 46 17,557 | 107 58 31 |
| | 3 | 45 46 18,192 | 107 58 32 |
| | 4 | 45 46 18,61 | 107 58 32 |
| | 5 | 45 46 18,358 | 107 58 32 |
| | 6 | 45 46 17,665 | 107 58 32 |
| | 7 | 45 46 16,936 | 107 58 32 |

*Нөхөн сэргээлт хийсэн газарт хэмжилт хийж талбайн хэмжээг тогтоон полигон хэлбэрээр shape.file үүсгэн флаш болон CD-нд хуулж акттай хавсаргана.*

## 6. Мэдээллийн сангийн бүртгэл

Нөхөн сэргээлтийг хүлээн авсан ажлын хэсэг нь Байгаль орчны мэдээллийн сангийн www.eic.mn цахим системийн Нөхөн сэргээлтийн мэдээллийн дэд санд заавал бүртгүүлнэ.

Жич: Мэдээллийн санд бүртгэгдээгүй тохиолдолд нөхөн сэргээлтийг хүлээн авсан актыг хүчинтэйд тооцохгүй.

Мэдээлэл оруулсан хүний нэр, албан тушаал:

Гарын үсэг:

Огноо :

Нэмэлт мэдээлэл:

Нөхөн сэргээлтийн ажил холбогдох хууль, журам, стандартад нийцсэн талаарх ажлын хэсгийн дүгнэлт: Биг могул коул энд энержи ХХК нь 3-р багийн нутаг Сүүл өндөр нэртэй талбайд дүйцүүлэн нөхөн сэргээлт хийсэн цаашид уг талбайн байгалийн жамаар сэргээгдэх боломжтой гэж үзлээ.

АКТ ГАРГАСАН:

Комиссын дарга: ........................................ ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ А.ОТГОНСҮРЭН
(гарын үсэг) (албан тушаал)

Нарийн бичгийн дарга: ........................................ БОМЭРГЭЖИЛТЭН Х.САРАНГЭРЭЛ
(гарын үсэг) (албан тушаал)

Гишүүд:
........................................ 2-Р БАГИЙН ЗАСАГ ДАРГА Э.ДАШДАМБА
(гарын үсэг) албан тушаал)
........................................ ГАЗРЫН ДААМАЛ Т.ШУУХААЗ
(гарын үсэг) (албан тушаал)
........................................ ИРГЭНИЙ ТӨЛӨӨЛӨЛ М.ЦЭРЭНДУЛАМ
(гарын үсэг) (албан тушаал)

ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРСӨН ............................ Биг могул коул энд энержи ХХК –НИЙ БОМЭРГЭЖИЛТЭН
(гарын үсэг) (нөхөн сэргээлт хийсэн байгууллагын төлөөлөл)

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ ТАЛБАЙД НӨХӨН СЭРГЭЭЛТ

ХИЙСЭН ГАЗРЫГ ХҮЛЭЭЖ АВАХ АКТ

2024 оны 12 дугаар сарын 06 өдөр

| | | |
|---|---|---|
| 1.Байршлын мэдээлэл | | |
| 1.1 | Аймаг, нийслэлийн нэр | Дундговь |
| 1.2 | Сум, дүүргийн нэр | Баянжаргалан |
| 1.3 | Газрын нэр | Хөөтийн хонхор -2 |
| 2. Нөхөн сэргээлт хийсэн байгууллагын нэр | | |
| 2.1 | Аж ахуйн нэгжийн нэр, регистрийн дугаар | Биг могул коул энд энержи 5369223 |
| 2.2 | Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн дугаар | 020772A |
| 2.3 | Тус талбайд нийт эвдрэлд өртсөн талбайн хэмжээ (га) | 1,0 |
| 2.4 | Нөхөн сэргээлт хийсэн аж ахуйн нэгжийн нэр, регистр | Биг могул коул энд энержи 9011665117 |

| | |
|---|---|
| 3. Өмнөх жилүүдэд тухайн тусгай зөвшөөрлийн талбайд хийгдсэн нөхөн сэргээлтийн ерөнхий мэдээ | |
| 3.1 Техникийн нөхөн сэргээлт | 3.2 Биологийн нөхөн сэргээлт |
| Талбайн хэмжээ (га) : үйл ажиллагаа явуулаагүй 0,39 | |
| Зардлын хэмжээ (төг) | Зардлын хэмжээ (төг) |
| 4. 2024 онд хүлээлгэн өгч буй нөхөн сэргээлтийн мэдээлэл | |
| 4.1 Техникийн нөхөн сэргээлт 1,0 | 4.2 Биологийн нөхөн сэргээлт |
| Талбайн хэмжээ (га) 1,0 | |
| Зардлын хэмжээ (төг) 1.900.000 төг | |
| 5. Орон зайн мэдээлэл | |
| 5.1 Нөхөн сэргээлт хийгдсэн газрын фото зураг | 5.2 Хэмжилт, зураглал<br>Кадастрын зураглал хийсэн мэргэжлийн байгууллага болон хэмжилт хийсэн хүний нэр:<br><br>Хэмжилтэд ашигласан программ, тоног төхөөрөмж South GPS, Mavic 3E.<br>Холбогдох утас: 86469080<br>Гарын үсэг: [signature] |

| | |
|---|---|
| 5.3 Нөхөн сэргээлт хийсэн газрын солбилцол<br>Жич. 4-өөс доошгүй эргэлтийн цэгийн солбилцол байна. | Булангийн цэгүүд хавсралтаар<br>Нийт 16 цэг байгаа |
| *Нөхөн сэргээлт хийсэн газарт хэмжилт хийж талбайн хэмжээг тогтоон полигон хэлбэрээр shape.file үүсгэн флаш болон CD-нд хуулж акттай хавсаргана.* | |
| **6. Мэдээллийн сангийн бүртгэл** | |
| Нөхөн сэргээлтийг хүлээн авсан ажлын хэсэг нь Байгаль орчны мэдээллийн сангийн www.eic.mn цахим системийн Нөхөн сэргээлтийн мэдээллийн дэд санд заавал бүртгүүлнэ.<br>Жич: Мэдээллийн санд бүртгэгдээгүй тохиолдолд нөхөн сэргээлтийг хүлээн авсан актыг хүчинтэйд тооцохгүй.<br>Мэдээлэл оруулсан хүний нэр, албан тушаал:<br>Гарын үсэг:<br>Огноо : | |
| Нэмэлт мэдээлэл: | |

Нөхөн сэргээлтийн ажил холбогдох хууль, журам, стандартад нийцсэн талаарх ажлын хэсгийн дүгнэлт: Биг могул коул энд энержи ХХК нь 1,0 га талбайд нөхөн сэргээлт хийсэн цаашид уг талбайн байгалийн жамаар сэргээгдэх боломжтой олон настын үр цацах зэрэг ажлыг үр шаттай хийх.

АКТ ГАРГАСАН:

Комиссын дарга: ........................................ (гарын үсэг) — ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ А.ОТГОНСҮРЭН (албан тушаал)

Нарийн бичгийн дарга: ........................................ (гарын үсэг) — БОМЭРГЭЖИЛТЭН Х.САРАНГЭРЭЛ (албан тушаал)

Гишүүд:

........................................ (гарын үсэг) — 2-Р БАГИЙН ЗАСАГ ДАРГА Э.ДАШДАМБА албан тушаал)

........................................ (гарын үсэг) — ГАЗРЫН ДААМАЛ Т.ШУУХААЗ (албан тушаал)

........................................ (гарын үсэг) — ИРГЭНИЙ ТӨЛӨӨЛӨЛ Н.ГАНБОЛД (албан тушаал)

ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРСӨН:

. ........................................ (гарын үсэг) — Биг могул коул энд энержи ХХК –НИЙ БОМЭРГЭЖИЛТЭН (нөхөн сэргээлт хийсэн байгууллагын төлөөлөл

2024.12.10.

Оролдлого тэсэлгээний үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа.

9/9

| Нэрс: | Албан тушаал. | Гарын үсэг: |
|---|---|---|
| 1. Л. Ариунбаатар. | Тэрхайн дарга. | [signature] |
| 2. Ч. Мэнд-Амар | Уурхайн инженер | [signature] |
| М. Мөнх-Оргил | EX-02 | [signature] |
| [signature] | 04 | [signature] |
| Ш. Есөн-Эрдэнэ | Чулуун мастер | [signature] |
| Б. Гантулга | EX-03 | [signature] |
| Б. Довдонням | Ex-4 | Довдонням |
| Б. Оюунбилэг | LO6 | [signature] |
| Н. Төрбат | АНБэлтгэл механик | [signature] |
| Б. Мөнхсансар | Ex-1 | Мөнхсансар |
| Т. Бат-Эрдэнэ | Ex-6 | Бат-Эрдэнэ. |
| Цэрэнцэвээ | HD-04 | Цэрэнцэвээ |
| Э. Очир | HD-03 | [signature] |
| Баянцоож | механик | [signature] |
| Энхманлай | HD07 | [signature] |
| П. Мөнхнаранцэцэг | HD06 | П. [signature] |
| С. Мөнхтөгс | LO-07 | Мөнхтөгс |
| С. Мягмар | HD-10 | С. Мягмар |
| С. Цогбадрах | Мохимейдер | С. [signature] |
| Баянцоож | HD07 | Баянцоож |
| Б. Жаргалсайхан | HD-24 | Жаргал [signature] |
| Д. Баттөгөлдөр | HD12 | [signature] |
| Б. Мөнх-Эрдэнэ | HD-11 | [signature] |
| Т. Мягвадорж | HD-20 | Мягвадорж |
| Б. Эрдэнэтулга. | НБ-22 | [signature] |
| Б. Бямбадорж | LD01 | Бямбадорж |
| А. Нямдорж | LD02 | А. Нямдорж |
| У. Пүрэвсүрэн | LO-05 | У. Пү |
| Ж. Очонбаатар | засвар | Очоо |
| Ш. Мягмарсүрэн | LO-03 | [signature] |
| Д. БАТБААТАР | HD-32 | [signature] |
| Д. Ганхүү | HD09 | ДН |
| Ш. Цэрэнтулга | D-1 | Цэ-[signature] |
| Ж. Алтантуяа | HD 44 | [signature] |
| Б. Ватсаатан | EX-07 | [signature] |

Аюултай хог хаягдал хөрсөнд шингээж бохирдуулсан тохиолдолд хэрхэн хариу арга хэмжээ авах, хөрс бохирдуулахгүй байх талаарх экологи хамгаалалтын сургалтанд хамрагдсан ажилчдын нэрс.

| Д/д | Нэрс | Албан тушаал | Гарын үсэг |
|---|---|---|---|
| 1. | Х. Наранбаатар | Уурхайн дарга | [signature] |
| 2. | Ч. Мяг-Амар | Уулын инженер | [signature] |
| | Ш. Есөн-Эрдэнэ | Уулын мастер | Ш. [signature] |
| | Б. Гантулга | ХАБЭА-н менежер | [signature] |
| | Б. Оюунбилэг | EX-03 ковш 6 | Б. [signature] |
| | Даваажин | EX-04 | Даваажин |
| | Цэрэндаваа | HD-04 | Цэрэндаваа |
| | Мөнхсонор | Ex-1 | Мөнхсонор |
| | Г. Бат-Эрдэнэ | Ex-6 | Бат-Эрдэнэ |
| | Ө. [illegible] | EX-07 | [signature] |
| | Э. Очир | HD-03 | Очир |
| | С. Баяржиг | HD-5 | [signature] |
| | М. Мөнх-Оргил | EX-02 | [signature] |
| | С. Мягмар | HD-10 | Мягмар |
| | П. Мөнхнайрамдал | HD-06 | П. [signature] |
| | Б. Жаргалмаахан | HD-24 | Жаргал |
| | Д. Баттулга | HD 12 | [signature] |
| | Б. Мөнхзул | HD-11 | [signature] |
| | Т. Лхагвадорж | HD-20 | Лхагвадорж |
| | Ө. Оюунтуяа. | HD-22. | Б. [signature] |
| | Д. Ганцэцэг | HD 00 | ДГ |
| | М. Орхонбаатар | засвар | Орхонбаатар |
| | Ч. Пүрэвсүрэн | LO-05 | Ч. Пүр |
| | Ш. Мягмарсүрэн | LO-03 | [signature] |
| | Энхманлай | механик | Энхманлай |
| | А. Нандинцэцэг | LO-02 | [signature] |
| | Д. БАТБААТАР | HD-32 | [signature] |
| | С. Мөнхтогс | LO07 | Мөнхтогс |
| | Ш. Ч-ч, БАТТУЛГА | D-1 | Ш. Ч-ч, [signature] |

Баянжаргалан сумын Засаг даргатай байгуулсан "Ус бохирдуулсны төлбөрийн гэрээ"-г дүгнүүлж, сунгуулах

- "Усны тухай" хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь заалтад заасны дагуу Дундговь аймгийн Баянжаргалан сумаас олгосон "Хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрлийн бичиг"-ийг сунгуулах;
- Хаягдал усны дүгнэлтийг дараа оны эхний улиралд багтаан гаргуулах бөгөөд улирал бүр хоёроос доошгүй хаягдал усны сорьц авч, итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлэн, сүүлийн сарын 15-ны дотор ирүүлэх;
- Хаягдал ус хаях цэгийн байршлыг тогтоолгож Дундговь аймгийн Баянжаргалан сумын ЗДТГ-аас зөвшөөрөл авах
- Ус бохирдуулсны төлбөрийг дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор харьяалах татварын албанд төлөх ба хугацаанд нь төлөөгүй тохиолдолд "Зөрчлийн тухай" хуулиар хариуцлага хүлээх нөхцөл үүсэхийг анхаарах;
- Усны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5-д заасны дагуу усны мэдээллийн сан бүрдүүлэхэд шаардлагатай ус бохирдуулсны төлбөрийн гэрээг дүгнэсэн акт, хаягдал усны шинжилгээний дүгнэлтүүд, төлбөр төлсөн баримтыг Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газрын захиргааны Umardgobi14@gmail.com цахим хаягаар 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

**ХЯНАСАН:**

УГГ - ХДТСГЗАХИРГААНЫ ДАРГА Б. ОТГОНСҮРЭН

**БОЛОВСРУУЛСАН:**

УГГ - ХДТСГЗАХИРГААНЫ АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Б.САРАНТУЯА

# УМАРД ГОВИЙН ГҮВЭЭТ-ХАЛХЫН ДУНДАД ТАЛЫН САВ ГАЗРЫН ЗАХИРГАА
# ХАЯГДАЛ УСНЫ ДҮГНЭЛТ

2024 оны 11 дугаар сарын 14-ны өдөр — Дугаар:**47** — Говьсүмбэр Сүмбэр

**1. Иргэн, аж ахуйн нэгж байгууллага, захирлын нэр, утас, улсын бүртгэлийн болон регистрийн дугаар, цахим хаяг:**

"Биг могул коул энд энержи" ХХК,Захирал Б.Отгонбаатар Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг.1-р хороо.Олимпийн гудамж-7/13.Центрум төв.904 тоот. Улсын бүртгэлийн дугаар:9011225079. Регистрийн дугаар:5369223 . Утас: 88118817

**2. Төслийн нэр, байршил:**

Хар тэвш чулуун нүүрсний орд нь Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт орших ба Улаанбаатар хотоос зүүн-урагш 300 км, Дундговь аймгийн төв Мандалговь хотоос зүүн-урагш 110 км, Баянжаргалан сумаас баруун зүгт 25 км-т тус тус байрлана. Талбайн номенклатур L-48-84. Нийт 55.66 га талбайг хамран Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газарт оршино.

**3. Хаягдал ус хаях цэгийн байршил, координат:**

Уурхайн орчинд

**4. Цэвэрлэгээний арга, түвшин:**

Унд, ахуйн хаягдал усыг үйлдвэрийн орчинд хөрсөнд нэвчүүлэн зайлуулдаг.

**5. Хаягдал усны хэмжээ:**

Тус компанийн хаягдал усны хэмжээг Усны газрын 2024 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн Е-2409-000076 дугаартай ус ашиглуулах дүгнэлтээр гаргасан унд, ахуйн хэрэглээнд ашиглах 7062.75 $м^3$/жил - ийг үндэслэн тооцов.

**6. Хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээ, төрөл:**

Хаягдал усны шинжилгээ хийлгүүлээгүй тул Байгаль орчин аялал жуулчлалын сайд, Барилга хот байгуулалтын сайдын хамтарсан 2019 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн "Хаягдал усанд агуулагдах бохирдуулах бодисын жишиг хэмжээг тогтоох тухай" А/816/218 тушаалаар батлагдсан хэмжээг үндэслэн ахуйд ажилчдын тосгон 1.5кг/$м^3$-ээр тооцов.

**7. Ус бохирдуулсны төлбөр, тооцоо:**

Органик бодис /ХХХ/ 1.5кг/$м^3$ х 7062.75 $м^3$/жил х 50төг/кг = 529'687.5 төгрөг

/Таван зуун хорин есөн мянга зургаан зуун наян наян долоон төгрөг таван мөнгө/

**8. Хууль тогтоомж, дүрэм, журам, норм стандартын талаар зөвлөмж:**

- Байгаль орчин, ногоон хөгжлийн Сайдын 2013 оны А/156 дугаар тушаалаар баталсан "Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам"-ын 2.1.4, 3.6.1 дэх заалтын дагуу хаягдал усны шугам дээр тоолуур суурилуулах
- "Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага MNS 4943:2015" стандартаас давсан бол "Усны тухай" хуулийн 25 дугаар зүйлийн 25.2, БОАЖ-ын Сайдын 2019 оны А/635 дугаар тушаалаар баталсан "Ус бохирдуулсны нөхөн төлбөрийг шатлан өсгөх хэлбэрээр ногдуулах журам"-ын дагуу нөхөн төлбөр ногдуулахыг анхаарах;

**9. Тавигдах шаардлага, цаашид авах арга хэмжээ:**

- "Усны тухай" хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.13 дахь заалтад заасны дагуу Дундговь аймгийн

# ДУНДГОВЬ АЙМГИЙН БАЯНЖАРГАЛАН СУМАНД БАЙРЛАХ “БИГ МОГУЛ КОУЛ ЭНД ЭНЕРЖИ” ХХК-ийн “ХӨӨТИЙН ХОНХОР-2” ЧУЛУУН НҮҮРСНИЙ УУРХАЙН ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

ХЯНАСАН:
ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ОРЛОГЧ, ГАМШГААС ХАМГААЛАХ УЛСЫН ХЯНАЛТЫН БАЙЦААГЧ,
ДЭД ХУРАНДАА Д.БАТ-ЭРДЭНЭ

БОЛОВСРУУЛСАН:
ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА ҮНЭЛГЭЭ, ДОТООД АЖИЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН,
ДЭСЛЭГЧ Б.МӨНХ-ЭРДЭНЭ

2024 он

БАТЛАВ
"БИГ МОГУЛ КОУЛ ЭНД ЭНЕРЖИ" ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ С.БОЛД

2024 оны 05 сарын ..... өдөр

# ДУНДГОВЬ АЙМГИЙН БАЯНЖАРГАЛАН СУМАНД БАЙРЛАХ "БИГ МОГУЛ КОУЛ ЭНД ЭНЭРЖИ" ХХК-ИЙН "ХӨӨТИЙН ХОНХОР -2" НҮҮРСНИЙ УУРХАЙН ГАМШГААС ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

ХЯНАСАН:
ДУНДГОВЬ АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ГАМШГААС ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨЛТ, БЭЛЭН БАЙДАЛ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН ГАМШГААС ХАМГААЛАХ УЛСЫН ХЯНАЛТЫН БАЙЦААГЧ, ХОШУУЧ Л.ДОРЖДЭРЭМ

БОЛОВСРУУЛСАН:
БАЙГАЛ ОРЧНЫ МЭРГЭЖИЛТЭН А.ДАВААДОРЖ

2024 он

# ДУНДГОВЬ АЙМГИЙН БАЯНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ АШИГТ МАЛТМАЛ АШИГЛАЛТЫН MV-020772 ТООТ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААРТАЙ "ХӨӨТИЙН ХОНХОР-2" НЭРТЭЙ ОРДЫГ АШИГЛАХ ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ АУДИТЫН ТАЙЛАН

**ЗАХИАЛАГЧ: "БИГ МОГУЛ КОУЛ ЭНД ЭНЕРЖИ" ХХК**


**ГҮЙЦЭТГЭСЭН БАЙГУУЛЛАГА:**
**"ЦЭХИ КОНСАЛТИНГ" ХХК-ИЙН**
**ЗАХИРАЛ** Б.Мөнхболд **Б.МӨНХБОЛД**

ЦЭХИ-КОНСАЛТИНГ ХХК
У БМ02666 5660831

**АУДИТЫН БАГИЙН ГИШҮҮД:**

| | |
|---|---|
| Багийн ахлагч, ахлах аудитор | Н.Эрдэнэцэцэг |
| Мэргэшсэн шинжээч, магистр | Л.Амарсайхан |
| Химийн зөвлөх шинжээч, доктор | Г.Бурмаа |
| Байгаль орчны аудитор | Ц.Солонго |
| Хүрээлэн буй орчны экологич | Ө.Баясгалан |


**УЛААНБААТАР ХОТ**
**2024 ОН**

# МОНГОЛЫН ТАТВАРЫН АЛБА

**ТАТВАР ТӨЛСӨН БАРИМТ № - 3241202109853**

| | |
|---|---|
| ТТД / Регистр: | 20101038241 / 5369223 |
| Татвар төлөгчийн нэр: | Биг могул коул энд энержи |
| Татварын төрөл: | 01030724 - Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөр |
| Харъяалах татварын алба: | Дундговь / Аймгийн төвлөрсөн |
| Төлсөн дүн: | 27,620,352.00 ₮ |
| Гүйлгээний огноо: | 2024-12-27 18:57:17.0 |
| Гүйлгээний утга: | 3241202109853 20101038241 Биг могул коул энд энержи MN240019009080001452;ТӨРИЙН САН БАНК;99010043 |
| Татварын данс: | Ду.Ус ашигласны төлбөр - 100080000944 |
| Төлөлтийн хэлбэр: | MOST |

Gmail

batkhuu erdenetuya <bigmogulcoul@gmail.com>

## Гүйлгээний мэдээлэл (Амжилттай)

**Transbank** <ebank@transbank.mn>
To: BIGMOGULCOUL@gmail.com

Mon, Dec 23, 2024 at 1:49 PM

TransBank

**Шилжүүлгийн мэдээлэл**
Журналын №: 912390024527

Гүйлгээний огноо: 2024/12/23 13:49:54

| | | | | |
|---|---|---|---|---|
| Илгээгч | Дансны дугаар<br>MN240019009080001452 | Нэр<br>БИГ МОГУЛ КОУЛ ЭНД ЭНЕРЖИ | Дүн<br>2,500,000.00 MNT | Ханш<br>1.0 |
| Хүлээн авагч | Банкны нэр<br>ГОЛОМТ БАНК<br>Дансны дугаар<br>1715164140 | Нэр<br>ЭЛЕМЕНТ ХХК | 2,500,000.00 MNT | 1.0 |

Гүйлгээний утга:
Аюултай хог хаягдал зайлуулах үйлчилгээ-биг могул,5369223

Шимтгэлийн мэдээлэл: БАЙГУУЛЛАГЫН БАНК ХООРОНДЫН БЭЛЭН БУС ШИЛЖҮҮЛГИЙН ШИМТГЭЛ 200 MNT
Танд баярлалаа.

Гүйлгээний баримтыг баталгаажуулсан

Салбар, тооцооны төв:

Гарын үсэг:

Тамга:

Огноо:______Он ___Сар ___Өдөр

Gmail

batkhuu erdenetuya <bigmogulcoul@gmail.com>

**Гүйлгээний мэдээлэл (Амжилттай)**

**TransBank (Internet bank)** <ebank@transbank.mn>
To: BIGMOGULCOUL@gmail.com

Thu, Nov 14, 2024 at 5:01 PM

TransBank

**Шилжүүлгийн мэдээлэл**
Журналын №: 908490025356

Гүйлгээний огноо: 2024/11/14 17:01:46

| | | | | |
|---|---|---|---|---|
| | Дансны дугаар | Нэр | Дүн | Ханш |
| Илгээгч | MN240019009080001452 | БИГ МОГУЛ КОУЛ ЭНД ЭНЕРЖИ | 960,000.00 MNT | 1.0 |
| Хүлээн авагч | Банкны нэр<br>ТӨРИЙН САН<br>Дансны дугаар<br>100080500947 | Нэр<br>Ду.Ба Хог хаягдлын хураамж | 960,000.00 MNT | 1.0 |

Гүйлгээний утга:
Хог хаягдлын төлбөр-2024он -5369223,Биг могул коул энд энержи

Шимтгэлийн мэдээлэл: БАЙГУУЛЛАГЫН БАНК ХООРОНДЫН БЭЛЭН БУС ШИЛЖҮҮЛГИЙН ШИМТГЭЛ 200 MNT
Танд баярлалаа.

Гүйлгээний баримтыг баталгаажуулсан

Салбар, тооцооны төв:

Гарын үсэг:

Тамга:

Огноо:______Он ___Сар ___Өдөр